



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 08-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2022 оны 12 дугаар сарын 08-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	0
Хуралдааны товч тэмдэглэл:	2-11
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	12-72
<hr/>	
<i>1.Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.11.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, нэн яаралтай, үргэлжлэл/</i>	19-20
<i>2.“Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Хилийн боомтоор ачаа, тээвэр, нүүрс тээвэрлэх болон чөлөөт бүсийн үйл ажиллагаанд учирч байгаа хүндрэлийг шалган тогтоох/</i>	20-37
<i>3.Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2021.11.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	37-51
<i>4.Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан нарын 3 гишүүн 2021.07.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	51-53
<i>5.Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар 2022.10.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	53-59
<i>6.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 3 гишүүн 2022.11.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	59-61
<i>7.Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.10.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	61-72

**Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы
12 дугаар сарын 08-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 76 гишүүнээс 39 гишүүн хүрэлцэн ирж, 51.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 06 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Аюурсайхан, Ж.Ганбаатар, Д.Өнөрболор, Ж.Чинбүрэн;

Чөлөөтэй: А.Адъяасүрэн, Ж.Батсуурь, Л.Оюун-Эрдэнэ, Б.Чойжилсүрэн;

Эмнэлгийн чөлөөтэй: Ш.Раднаасэд, Д.Сарангэрэл, Ч.Ундрэм;

Тасалсан: С.Батболд, Н.Ганибал, Б.Жавхлан;

Хоцорсон: Ш.Адъяаа-08 минут, С.Амарсайхан-55 минут, С.Ганбаатар-28 минут, Д.Ганбат-44 минут, Т.Доржханд-13 минут, Г.Мөнхцэцэг-07 минут, Н.Наранбаатар-08 минут, М.Оюунчимэг-1 цаг 15 минут, Ж.Сүхбаатар-20 минут, Ц.Сэргэлэн-09 минут, Ц.Туваан-06 минут, Г.Тэмүүлэн-35 минут, Н.Учрал-1 цаг 04 минут, Д.Цогтбаатар-08 минут, Б.Энхбаяр-10 минут, Н.Энхболд-11 минут, Т.Энхтүвшин-08 минут, Ж.Эрдэнэбат-1 цаг 29 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Б.Пүрэвдорж, Б.Жавхлан нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Б.Пүрэвдорж нар үг хэлэв.

Нэг.Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.11.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, нэн яаралтай, үргэлжлэл/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, мөн газрын ахлах шинжээч Н.Жамъянхүү, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Ногоон хөгжлийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Б.Буяннэмэх, мөн яамны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын дарга Б.Болортуяа, мэргэжилтэн П.Баярцэцэг, Хуулийн хэлтсийн дарга О.Цогтгэрэл, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга С.Мөнхнасан, “Монголын эрх зүйн судалгаа хөгжлийн төв” Төрийн бус байгууллагын хуульч Р.Лхагвабаяр нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга

Ц.Батбаатар нар байлцав.

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудал санал хураалтаар үргэлжлэв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Аялал жуулчлалын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 13

Бүгд: 55

76.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Хилийн боомтоор ачаа, тээвэр, нүүрс тээвэрлэх болон чөлөөт бүсийн үйл ажиллагаанд учирч байгаа хүндрэлийг шалган тогтоох/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар нар байлцав.

Төслийн талаар Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, С.Чинзориг, Ж.Батжаргал, Б.Жаргалмаа, П.Анужин, Б.Бат-Эрдэнэ,

Д.Бат-Эрдэнэ, Б.Баярсайхан нарын тавьсан асуултад Түр хорооны дарга Г.Ганболд хариулж, тайлбар хийв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар “Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 36

Татгалзсан: 25

Бүгд: 61

59.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./11:30/

Уг асуудлыг 11 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2021.11.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд О.Батнайрамдал, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Б.Анхбаяр, мөн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга Ч.Хишигдалай, Ашигт малтмал, газрын тосны газрын Газрын тосны бүтээгдэхүүний хэлтсийн дарга Д.Даваабаяр, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга С.Мөнхнасан, мөн газрын Агаарын тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга Г.Батбаяр, “МИАТ” ТӨХК-ийн захирал Б.Мөнхтамир, мөн компанийн Санхүү, удирдлагын газрын захирал Н.Цэгц, “Эрчис ойл” ТӨХК-ийн захирал З.Ширзана, мөн компанийн менежер Х.Эрдэнэбилэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд, С.Чинзориг, Б.Пүрэвдорж, М.Оюунчимэг, Б.Бейсен, Б.Энх-Амгалан нарын тавьсан асуултад Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд О.Батнайрамдал, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Б.Анхбаяр нар хариулж, тайлбар хийв.

Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 12 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан нарын 3 гишүүн 2021.07.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Барилга, хот байгуулалтын яамны Нийтийн аж ахуйн инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Цогтсайхан, мөн газрын ахлах шинжээч Р.Батчимэг, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Б.Нямдорж, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн дарга Ж.Батсуурь, мөн зөвлөлийн Тусгай зөвшөөрөл, хэрэглэгчийн газрын дарга Г.Нарантуяа нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 12 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

12 цаг 21 минутад хуралдааныг хаалттай горимд шилжүүлж, “Монгол Улсын хилийн зурвас газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулав.

Үдээс өмнөх хуралдаан 3 цаг 00 минут үргэлжилж, 13 цаг 06 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 00 минутад эхлэв.

Тав.Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар 2022.10.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн ерөнхийлөгч Г.Алтанзаяа, мөн нийгэмлэгийн дэд ерөнхийлөгч Ү.Галмандах, Хууль, эрх зүйн хорооны дарга Н.Түмэнбаяр, Тамгын газрын дарга Г.Хишигзул, Хуулийн зөвлөх, ерөнхий нягтлан бодогч П.Дашдаваа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх А.Болортуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар үг хэлэв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 20
Бүгд: 45
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 14 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 3 гишүүн 2022.11.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газрын дарга З.Батболд, мөн хорооны Орон тооны гишүүн буюу дэд дарга Н.Хүдэрчулуун, Монголын даатгалын холбооны гүйцэтгэх захирал Ж.Батжаргал, мөн холбооны Удирдах зөвлөлийн гишүүн Б.Батзул, Монголын эрчим хүчний барилга засварын холбоо болон Монголын үндэсний барилгын ассоциацийн удирдах зөвлөлийн гишүүн М.Батболд, “Үндэсний давхар даатгал” ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Жавхланта нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх А.Болортуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Нэг.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшингийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн хуулийн дагаж мөрдөх хугацааг “2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	29
Татгалзсан:	18
Бүгд:	47

61.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшингийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 6¹.1-ийн “баталгаа, батлан даалт гаргана.” гэснийг “даатгагчийн баталгаа, батлан даалт гаргаж болно.” гэж өөрчлөх гэсэн саналыг

дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 18
Бүгд: 48
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшингийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 6¹.1.1.-ийн “төлбөрийг даатгагчийн баталгаагаар гаргаж болно;” гэснийг “төлбөрт;” гэж өөрчилж, 6¹.1.2, 6¹.1.3 дахь заалтын “даатгагчийн баталгаа гаргаж болно.” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 19
Бүгд: 48
60.4 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшингийн гаргасан, Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 19
Бүгд: 48
60.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав. Найруулгын санал

1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшингийн гаргасан, Төслийн гарчгийн “нэмэлт” гэсний дараа “, өөрчлөлт” гэж, төслийн 2 дугаар зүйлийн “бараа, ажил, үйлчилгээ” гэсний дараа “худалдан” гэж нэмж, төслийн 1 дүгээр зүйлийн “4.1.13 дахь хэсэгт заасныг ойлгоно” гэснийг “4.1.13-т заасныг” гэж, төслийн 3 дугаар зүйлийн “хуульд дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.” гэснийг “хуулийн 20.2, 43.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.” гэж өөрчилж, төслийн 2 дугаар зүйлийн “5.1.7, 5.1.8” гэсний дараах “дахь заалт, 5 дугаар зүйлийн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 19
Бүгд: 48
60.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2. Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшингийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “зүйлд заасан зохицуулалтыг хэрэглэнэ” гэснийг “зүйлд заасныг баримтална” гэж, “6.1-д заасан” гэснийг “6.¹-д заасан” гэж, төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “үйл ажиллагааны журмыг Санхүүгийн зохицуулах хороо батална” гэснийг “үйл ажиллагааны журам” гэж өөрчилж, төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “даатгагчийн баталгаагаар” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 17
Бүгд: 48
64.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 14 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.10.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, мөн яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ц.Баярбат, мөн газрын Геодези, зураг зүйн бодлого, зохицуулалт хариуцсан шинжээч С.Болороо, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга А.Энх-Манлай, мөн газрын Геодези, зураг зүйн хэлтсийн дарга Д.Мөнхцэцэг, “Монголын геодези, фотограмметр, зураг зүйн холбоо” Төрийн бус байгууллагын тэргүүн, зөвлөх инженер О.Хосбаяр, мөн байгууллагын удирдах зөвлөлийн гишүүн, зөвлөх инженер Ц.Дашзэвгэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Г.Хоролмаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж

ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин, Б.Энхбаяр нарын тавьсан асуултад Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга А.Энхманлай, мөн газрын Геодези, зураг зүйн хэлтсийн дарга Д.Мөнхцэцэг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг дэмжиж үг хэлэв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон албаны нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хаягжуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын бүртгэлийн ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол хэлний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авто замын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Геодези, зураг зүйн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 21

Бүгд: 46

54.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Засгийн газраас 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төмөр замын тээврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төслөө татан авах тухай албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлснийг уншиж танилцуулав.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т заасны дагуу хууль санаачлагч төслөө татан авсанд тооцлоо./15:05/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 8 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч М.Номиндулам, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 4 цаг 05 минут үргэлжилж, 76 гишүүнээс 62 гишүүн хүрэлцэн ирж, 81.6 хувийн ирцтэйгээр 15 цаг 05 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2022 оны 12 дугаар сарын 08-ны өдөр,
Пүрэв гараг Төрийн ордон “Их
хуралдай” танхим 10 цаг 06 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Улсын Их Хурлын эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтган мэндчилж байна.

Хуралдааны ирц бүрдсэн тул Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сарын 8-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгдүгээрт, Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэхийг үргэлжлүүлж хэлэлцэнэ ээ.

Хоёрдугаарт, “Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ ээ,

Хилийн боомтоор ачаа тээвэр, нүүрс тээвэрлэх болон чөлөөт бүсийн үйл ажиллагаанд учирч байгаа хүндрэлийг шалган тогтоох, хянан шалгах түр хорооны хугацааг сунгах асуудлыг хэлэлцэнэ,

Гуравдугаарт, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг,

Тавдугаарт, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл,

Зургаадугаарт, “Монгол Улсын хилийн зурвас газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Засгийн газраас өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлэг,

Долоод, Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Д.Цогтбаатар нарын гишүүд өргөн мэдүүлсэн,

Долоод, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт төрийн мэдүүлсэн Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулна.

Наймд, Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ ээ.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал, өөрчлөх асуудал нэмэх, горимын санал гаргах бол Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдааны өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөр, Болдын Жавхлан, Бөхчулууны Пүрэвдорж нараас албан бичгүүд ирүүлсэн байна.

Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөр Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-т заасны дагуу 2022 оны 12 дугаар сарын наймны өдрийн чуулганы хуралдаанд асуудал нэмэх горимын саналаар үг хэлэхэд бол зөвшөөрөл олгоно уу, Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөр гэжээ.

Баагаагийн Баттөмөр гишүүн үг хэлнэ ээ.

Б.Баттөмөр: Ингээд бид ч одоо далд эдийн засгийн талаар бол хангалттай л ярьсан. Тэгээд одоо холбогдох арга хэмжээнүүдийг тухай бүр нь авч яваагүйгээс болж өнөөдөр энэ их айхтар асуудлууд гарч байна л даа.

Нүүрсээр илэрч байгаа ер нь экспортод гарч байгаа бусад бүтээгдэхүүнүүд дээр ч гэсэн энэ гарч байгаа. Энийг бол яах вэ ажлын хэсэг гарчихсан, ингээд үзэж байгаа. Хууль хяналтын байгууллага болон бусад байгууллагууд хамтраад үзэж байгаа. Энэний үр дүн гарах байх гэж ингэж бодож байгаа юм. Энэнээс гадна одоо энэ алтан дээр бол асар их хэмжээний хулгай байгаа шүү дээ.

Олборлож байгаа алтныхаа тархацыг нь тушаадаг ченжүүдээр дамждаг ААНОАТ-аас зугтаадаг, АМНАТ-аас зугтдаг. Лиценз тойрсон луйвар байгаа. 6200 лицензийг хоорондоо шилжүүлсэн байгаа. Энэний одоо ихэнх нь худалдагдсан байгаа шүү дээ. Бид үүнийгээ хувийн хэвшлийг дэмжиж байна л гэдэг. Энэ чинь одоо хувийн хэвшлийг дэмжих биш хулгайг дэмжиж байгаатай л адил санаа шүү дээ.

Ингээд эхний ээлжид энэ хулгай, авлигатай тэмцэхийн тулд авлигатай

тэмцэх хууль, Эрүүгийн хуульд өөрчлөлт гаргасан суудлуудыг эхний ээлжид авч үзье ээ гэж ингэж үзэж байгаа юм.

Энэнээс гадна одоо өнөөдрийн яг бодит байдал дээр байж байгаа энэ жолоодлогогүй болсон хяналтаас гарч байгаа инфляц, ханшийн уналт, төлбөрийн тэнцэл, урсгал дансны алдагдлыг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх, эрчим хүчний салбарын энэ өвөл гарч болох эрсдэлээс сэргийлэх мэт асуудлуудад маш их олон асуудлууд хуримтлагдсан байна. Энэ бол одоо хамгийн түрүүнд чухал авч үзэх ёстой асуудал. Тэр Үндсэн хуулийн өөрчлөлтөөс илүү ач холбогдолтой. Сонгуулийн хуулиас ч илүү ач холбогдолтой. Магадгүй энэ Үндсэн хуулийн өөрчлөлт, Сонгуулийн хуулийн өөрчлөлт бол 10 дахь асуудал байж магадгүй.

Тийм учраас энэ тулгамдсан асуудлуудаа одоо шийдэх нь зүйтэй гэж үзэж байгаа. Төрийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудад өөрчлөлт оруулах шаардлагатай. Ингээд үзэхээр зэрэг энэ өнгөрсөн 30 жилийн хугацаанд Монголчууд бид өөрсдөө хөгжүүлээгүй, Монгол Улсаа хөгжүүлээгүй. Тийм учраас Төрийн албаны хуульд өөрчлөлт оруулж төрд бэлтгэгдсэн, мэдлэгтэй, туршлагатай эрсдэл тооцох чадвартай, авлигалаас ангид ард түмний төлөө чин сэтгэлээр зүтгэж чаддаг ийм хүмүүсийг сонгон шалгаруулж, одоо төрд ажиллуулах нь зүйтэй гэсэн ийм саналыг хэлж байгаа.

Ийм учраас Төрийн албаны хуульд өөрчлөлт оруулах ёстой гэж. Өнөөдрийн одоо хөгжлийн мухардал бол юу вэ гэхээр төрд бэлтгэгдээгүй хүмүүсийг томилсны балгаас

хөгжлийн хоцрогдол, мухардал одоо үүсэж байгаа гэж байгаа юм. Энэ хулгай хийж байгаа улсуудын одоо ихэнх нь тавиулууд байгаа шүү дээ. Тавьсан эздийг нь ил тод зарлах хэрэгтэй. Эзэд нь бараг одоо тодорхой байгаа шүү дээ. Зарлах хэрэгтэй шүү дээ. Өнгөрсөн 30 жилийн хугацаанд одоо бидэнд бол Монголд энэ баялгийн хараал, Голланд өвчин Монголын эдийн засагт туссан байгаа юм. Өвчний шинж тэмдэг нь баялаг хөгжил дэвшил биш, ядуурал гуйланчид далд эдийн засгийг одоо улам дэвэргэдэг. Баялгийн үр шимийг цөөхөн хүмүүс хүртэж, ард иргэдийн олонх нь улам ядуурч, үндэсний мөнгөн тэмдэгт одоо цаас болж, инфляц жолоодлоготой болж хяналтаас гардаг. Үйлдвэрлэлийг одоо боомилсноос бусдын үйлдвэрлэснийг хэрэглэдэг хэрэглэгч одоо улс болж, баян хоосны ялгааг улам гааруулж, эдийн засгийн бүх үзүүлэлтүүд унадаг. Энэ шинж тэмдэг бол одоо өнөөдөр манайд илэрч байгаа юм.

Үүнийг засдаг арга нь олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хууль, энэ хуулийг одоо гаргах хэрэгтэй. Баялаг эзэмшиж байгаа бүх компаниудын үйл ажиллагаа ил тод байх ёстой. Энийг одоо ярих гэж байгаа юм. Дараа нь бол энэ шүгэл үлээгчийн тухай хуулийг хэлэлцэж байгаа. Энийг одоо бас ойрын хугацаанд гарах ёстой. Оффтейк гэрээний нууцлалыг одоо ил тод болгох хэрэгтэй. Хулгай хийсэн хүмүүстэй одоо зөвшилцөж ил тод болгоно гэж бол байхгүй.

Тийм учраас бол энийг ил тодорхой болгох ажлыг одоо өөрчлөх шаардлагатай гэж үзэж байгаа. Эрүүгийн хуулийн 22.1 гээд нэг ял наймаалцдаг. Авлига авчхаад тэгээд одоо буцаад хэдэн төгрөг төлөөд

тэрнээсээ мултардаг авлигалын хэрэгт бол одоо хатуу хандах, өршөөл уучлал үзүүлэх ёсгүй гэж ингэж үзэж байгаа юм.

Ийм учраас энэ хуулийг бол өөрчилье, шинэчилье. Уул уурхайн биржийн хуулиа одоо хэрэгжүүлэх ёстой. ХАА-н бирж дээр гаргасан алдаануудыг бол давтаж болохгүй. Бид хулгай хулгай нүүрлэхээс гадна худалдаа хийж чадахгүй байгаа юм. Худалдааны хууль өнөөдрийг хүртэл байхгүй. Бид нэг литр тосоо 200 төгрөгөөр экспортод гаргаад бензинээ 4000 төгрөгөөр худалдаж авдаг. Нэг тонн төмрийн хүдрээ 100 доллароор экспортод гаргаад 1000 доллароор арматураа худалдаж авдаг, 10 дахин их үнээр худалдаж авч байна.

Ийм учраас Худалдааны хуулиа яаралтай гаргах ёстой. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал.

Г.Занданшатар: Одоо Улсын Их Хурлын гишүүн Болдын Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, миний бие 2022 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх асуудалтай холбогдолтойгоор үг хэлэх хүсэлтэй байгаа тул холбогдох хууль, журмын дагуу зөвшөөрөл олгоно уу. Хүндэтгэсэн Улсын Их Хурлын гишүүн Болдын Жавхлан. Алга байна.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Асуудал нэмэх горимын саналаар үг хэлэх зөвшөөрөл өгч байна.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр ойрын үед бол энэ нүүрсний асуудал маш том проблем болж эхэлж байна. Энийг би 2 жилийн өмнөөс ярьж эхэлсэн. Харамсалтай нь одоо намайг ярьж байхад Их Хурлын гишүүд

хаширалдаад юм яриулдаггүй байсан, нэгдүгээрт.

Хоёрдугаарт энэ хулгай байна гэдгийг хэлээд байхад тэр Эрдэнэс Таван толгойн захирал Ганхуяг намайг 2 удаа цагдаад өгч байсан. Манайх ёстой ариухан цэвэрхэн компани гээд. Тэгээд өнөөдөр үнэнд гүйцэгдэж байна.

Тэгэхээр энэ нүүрсний хулгай гээд 6.4 сая тонн нүүрс хулгайгаар гарчихсан. Тэрний өртөг нь 6.5 тэрбум доллар гээд Доржханд гишүүн хэлж байгаа юм. 6.4 сая тонн нүүрс чинь одоо мянгаар үржүүлж байж 6.5 тэрбум болох байхгүй юу даа. 1000 долларын үнэтэй нүүрс гэж хаана байсан юм. Тэгээд энэ эрх баригчтай нийлээд л ингээд л нэг баахан өндөр тоо тавьдаг. Араас нь эрх баригч нар 40 их наяд, 400 их наяд гээд л. Ингээд ямар ч хамаагүй тоо яриад л энэ одоо нүүрсний хулгайг одоо замхруулах ийм юм руу орж байна шүү дээ.

Тэгээд 6.4 сая тонн нүүрс гэдэг чинь 64000 машин тэргээр одоо хилээр зөөж байж гарч дуусна. Тэгээд тэнд байгаа 9000 жолооч бүгдээрээ хулгайч гэж бүр бүгдийг нь замхруулах нь байна шүү дээ. Гаальчид, тэр хэлийнхэн бүгдийг нь. Энэ нүүрсний хулгай гэж ярьж байгаагийнхаа ард эрх баригч нар 3 зүйлийг нууж үлдэх гэж байгаа.

Тээврийн хулгай тэр Цагаан хаднаас Ганц мод хүртэл хамгийн оргил үедээ 120 сая төгрөг буюу 250 доллароор тээвэрлэсэн. Тэрний 125 долларыг нь Хятадын компаниуд авдаг. 125 долларыг эрх баригч нар авдаг. Нам руугаа авдаг. Янз янзын хэлбэрээр авдаг, авлигал болгож авдаг. Энэ жилийн тээврийн зардал дээр зөрүү гэхэд 7 их наяд төгрөгийн зөрүү

гарчихсан байгаа. Энийг би Төсвийн зарлагын хяналтын дэд хороон дээр Жавхлан сайдаас хариулт авах гэсэн боловч чадаагүй.

Дараа нь оффтейк гэрээний хулгай байна. Зүүнбаян, Таван толгой, Таван толгойгоос Гашуун сухайт 2 гэрээ. Дээрээс нь Таван толгойн нүүрсний баяжуулах үйлдвэрийн оффтейк гэрээ, Тамсагийн наашаа татаж байгаа нефтийн хоолойн гэрээ ингээд энэ гэрээнүүд чинь бүгдээрээ дабальдсан гэрээнүүд байгаа. Ганцхан жишээ хэлэхэд байна шүү дээ тэр Таван толгойгоос Гашуун сухайт хүртэл замыг Голомтын Баясгалан 2 сая доллароор барьчхаад 4.5 саяын оффтейкын гэрээ байгуулсан.

Дээрээс нь нүүрс гэрээлсэн нүүрсээ 60 доллароор авчхаад цаашаа хэдэн зуун доллароор зарсан. Ямар их шунал вэ. Тэрний гэрээг нь зогсоогооч ээ. Чи ажил өртгийг нь шалгаач тийм юм хийж чадахгүй байгаа шүү дээ. Тэд гэрээний хулгай байгаа Таван толгойн Ганхуяг дээр Их Хурлын гишүүд, сайд дарга нар, хуулийнхан бүгдээрээ очоод 100 мянгийн гэрээ байна. 200 мянгийн гэрээ байна. 500 мянгийн гэрээ байна. Энийг зураад өгөөч гэдэг тэгэнгүүт нөгөөдөх нь яах гэж байгаа юм гэхээр дундаас нь нэг 2-5 доллар авмаар байна гэж ярьдаг. Ийм л юм хийдэг шүү дээ. Тэгээд сүүлд одоо 2016 оноос 100 сая тонн, 2017 оноос хойш 100 сая тонн нүүрс гарсан байна. Багаар бодоход 400 сая долларын асуудал гарч байгаа шүү дээ.

Тийм учраас Ганхуяг чинь нээдийсэн хэвээрээ байна. Тийм учраас та бүгдийг Монголын төрийг бүгдийг нь худалдаж авсан гэж бодож байгаа учраас намайг цагдаад 2 удаа өгсөн юм. Тэгээд би Ганхуягт нэг зүйлийг зөвлөх гэж байгаа юм. Ганхуяг энэ 3

одоо тээврийн хулгайтай холбоотой оффтейк гэрээтэй холбоотой гэрээний хулгайтай холбоотой бүх асуудлыг ганцаараа мэдэж байгаа хүн байгаа.

Тийм учраас Ганхуяг энэтэй холбоотой бүх хүмүүсээ бүгдийг нь нэрлэх ээ. Тэгэх юм бол чиний ялыг багасгах талаар би санаачлаад ярилцаж өгье гэж хэлэх гэж байгаа юм.

Хэрвээ хэлж өгөхгүй бол би удахгүй ээ. Та нар бол ингээд аягүй бол ялыг нь багасгаж байгаад чимээгүй байж бай гэж байгаад нэг тохиролцож магадгүй. 2024 онд Ардчилсан нам ялна. Тэрийг чинь ясыг нь янгинуулж байгаад бүгдийг чинь одоо нэг талд нь гаргана гэдгийг хэлье.

Хоёрдугаарт нь БНХАУ-ын Коммунист нам манайд мэдээлэл өгчихнө өө. Ганцхан Ардын намтай ажилладаг юм биш, Ардчилсан нам жоохон тал талдаа.

Г.Занданишатар: Эрхэм гишүүд ээ, гишүүд хэлэлцэх асуудалтай холбогдуулж үг хэллээ.

Улс орны нийгэм, эдийн засгийн амьдрал, цаг үеийн нөхцөл байдал амаргүй, үнийн өсөлт, инфляци, орлогын хомсдол, иргэдийн амьжиргааг доройтуулж, дээр нь энэ шударга ёс алдагдсан, гэмт хэрэг, баялгийн хулгайтай тууштай тэмцэх асуудал ард иргэдийн бухимдлыг төрүүлж, ард иргэд, залуучууд төв талбай дээр тав дахь өдрөө жагсаал цуглаан хийж, шаардлага тавьж байна.

Энийг бол бас үл тоомсорлох ёсгүй. Тэр шударга ёсыг нэхэж, ард түмний баялгийг хулгайлсан гэмт

үйлдлийг түргэн шуурхай шийдвэрлэхийг шаардаж байгаа нь шударга зүй ёсны шаардлага гэж үзэж Улсын Их Хурлаас ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсэг өчигдөр хуралдаж нүүрсний хулгайн асуудлаар нийтийн сонсгол зохион байгуулах саналыг Эдийн засгийн байнгын хороонд оруулж, Эдийн засгийн байнгын хорооноос өчигдөр хуулийн дагуу 14 хоногийн дараа бэлтгэл хангаж, нээлттэй сонсголыг зарлах ёстой. Энэ сарын 21-нд 11 цагаас нээлттэй сонсгол хийхээр шийдвэрлэлээ. 14 хоногийн хугацаа заадаг нь бол энэ хугацаанд ард иргэдийн саналыг сонсож, холбогдох гэрч, холбогдох албан тушаалтнууд, шүгэл үлээсэн, үнэлгээ тогтоосон мэдээлэлтэй нотлох баримттай байгаа Улсын Их Хурлын гишүүд энэ талаар ярьж байгаа гишүүд бүгд оролцож мэдээлэх үүрэгтэй. Тэгвэл гэмт хэргийг нуун дарагдуулсан гэмт үйлдэл болж, эрүүгийн хариуцлага хүлээх болно. Ийм учраас энэ талаар ярьж байгаа, хэлж байгаа бүх гишүүд ингээд мэдээлэл хийгээд байгаа бүх гишүүд энэ дээр гэрчээр оролцож мэдүүлгээ өгөх хэрэгтэй.

Холбогдох хууль хяналтын байгууллагууд мэдээллээр хангах шаардлагатай. Ийм учраас ажлын хэсэг, Байнгын хороод, Тамгын газар, ард иргэдийн ялангуяа энэ жагсаал, цуглаанд оролцож байгаа залуусын төлөөллийг оролцуулж, энэ нээлттэй сонсголыг шуурхай, үр дүнтэй зохион байгуулахад онцгой анхаарах шаардлагатай байна.

Үндсэн хуулийн дагуу бол Улсын Их Хурлын гэмт хэрэгтэй тэмцэх ийм үүрэг хүлээдэггүй. Үндсэн хуулиараа л бид явах ёстой. Үндсэн хуулийн дагуу гэмт хэрэгтэй тэмцэх үүрэг хүлээсэн эрх бүхий байгууллагууд гэмт хэрэг,

хулгайтай тэмцэх ажлыг эрчимжүүлэхийг ард түмэн шаардаж байна. Улсын Их Хурал энэ гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох боломжгүй боловч үүссэн нөхцөл байдал биднийг Үндсэн хуулийн дагуу шаардлага тавьж, хяналт тавьж ажиллахыг шаардаж байна. Нүүрсний хулгайг зөвхөн хулгайлсан нүүрс гэж хязгаарлахгүй, нүүрс экспортын бүх шатанд гэрээ тээвэр, хөрс хуулалт, олборлолт, жишиг татвар, АМНАТ, НӨАТ, хил, гааль гээд энэ олон хүрээг хамарч байгааг ер нь бүх талаар нь анхаарч одоо асуудлыг шалгах хэрэгтэй. Нийт 21 эрүүгийн хэрэг байна гэж мэдээлж байгаа. Тэдгээрийг шүүхдээ шилжүүлээд хэргүүд холбогдсон улс төрчид, албан тушаалтнуудын нэрсийг иргэдэд ил тод зарлаад мэдээлээд явах хэрэгтэй. Тэгэхгүй бол эзэн биегүй хулгайн хэрэг ярихаа больё.

Сэдэв хулгай яриад, ингээд тэгээд эзэн биеийг нь зарлахгүй болохоор ард түмэн бухимдах нь аргагүй ээ. Ийм учраас тэр мэдээлэлтэй үнэлгээ тогтоосон Улсын Их Хурлын болон Засгийн газрын гишүүд, холбогдох албан тушаалтнууд, хуулийн байгууллагуудад мэдээлэл, гэрчийн мэдүүлгээ өгч энэ нотлох баримтуудаа өгөх шаардлагатай. Энийгээ бас нээлттэй сонсгол дээр гэрчээр оролцож мэдээлэх үүрэгтэй. Гэмт хэрэг нуун дарагдуулах нь эрүүгийн хариуцлага. Ямар нэгэн холбогдолтой гишүүд байвал төр ард түмний өмнө өргөсөн тангараг, иргэний үүргээ биелүүлж хууль хяналтын байгууллагад очиж шалгуулах хэрэгтэй. Энэ дээр дооргүй ингээд хулгай зэлгий гарахаараа одоо нөгөө хулгайч хулгайчийг бариарай гэж хаширдаг шиг. Аль эсвэл нэгнийгээ улс

төрийн зорилгоор хэлмэгдүүлэх гэсэн аль эсвэл гэмт хэргийг нуун дарагдуулах гэсэн ингээд энэ нүүрсний хулгайг замхруулах гэсэн аливаа үйлдэлтэй Улсын Их Хурал харин хатуу тэмцэх шаардлагатай.

Ийм учраас нүүрсний хулгайн хэргийг ард түмний хяналт дор ил тод, үнэн зөвөөр шийдвэрлэх үйл явцад Улсын Их Хурлын гишүүд, Улсын Их Хурал өөр өөрсдөөсөө шалтгаалах дэмжлэгийг бүрэн үзүүлж ажиллах шаардлагатай гэдгийг зориуд тэмдэглэж хэлье.

Хэрэг удааширч холбогдогчид нь ил болохгүй байгаа нь хуулийн буруу байхгүй, хууль хэрэглээний л буруу байгаа. Тэд бүх юмаа ингээд хаацайлаад ирэхдээ хууль хэрэглээн дээр хуулиас л болоод байна гээд ингээд үнэхээр тийм шаардлагатай хууль байгаа бол бид нар одоо яаралтай өргөн барьж хэлэлцүүлбэ. Тэр авлигатай тэмцэх багц хуулийг бид ярьж байгаа шүү дээ. Тэр ялын бодлогыг чангатгая. Гэмт хэрэг илрүүлэх, эрүүгийн энэ авлигатай тэмцэх хүртэл бүх талын шаардлагыг хэрэгжүүлэхэд бүх боломж байгаа. Энийгээ одоо оруулаад ир. Яг юу нь болохгүй байгаа юм. Ийм учраас улс орны өнөөгийн нөхцөл байдал, маргааш ирээдүйн зорилттой холбоотойгоор Улсын Их Хурал илүү ачаалалтай, хариуцлагатай ажиллах зайлшгүй шаардлага үүсэж байна.

Ийм учраас ойрын үед одоо бид нар бас ажлын төлөвлөгөөгөө энэ хувийн хэвшилээ дэмжих, эдийн засгаа солонгоруулах, төрөлжүүлэх, аялал жуулчлалын хуулиас авхуулаад ингээд багцлаад эдийн засгийн реформ, нийгмийн бодлогын реформ, тэр халамжаас хөдөлмөрт шилжинэ гээд л яриад байгаа энэ ард түмний энэ

хүнд үнийн өсөлт, валютын ханишийн өсөлтийг яаж шийдвэрлэх юм. Эдийн засгийг тогтворжуулах хуулиа яаралтай өргөн барьж хэлэлцүүлэх хэрэгтэй байна. Хувийн хэвшлийг дэмжих, хөрөнгө оруулалтыг дэмжих энэ асуудлуудаа шийдье. Нийгмийн бодлого, авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй, улс төр засаглалын энэ чадамжаа сайжруулж, ард түмний засаглах эрхийг хангасан энэ өөрчлөлтүүдийг хийх гэсэн ийм 3 багц, тэгээд энэ төвлөрөл, түгжрэлийг бууруулах шаардлагатай, үнийн өсөлтийг одоо анхаарах хэрэгтэй байна.

Ийм ард түмний өмнө тулгамдсан асуудлуудаа бид яаралтай шийдэхгүй бол ард түмэн хараад байна. Тэгээд өнөөдөр гэхэд бас энэ Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль одоо хэлэлцэгдэж амжсангүй. Мэдээж олон асуудал байгааг ойлгож байна. Энийг одоо маргаашийн хуралдаанд оруулахаар ажилла. Бат-Эрдэнэ дарга гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн ажлын хэсэг арай удаж байна аа. Энийг тэр олборлох салбарын ил тод байдлыг санаачлагчийн хуулийг би Ёндон сайдад энэ Батнайрамдал сайдыг ирэхээр ярьж байна, жил ярьж байна.

Тэр энэ чинь л одоо энэ нүүрсний хулгай энэ тэртэй тэмцэх хууль, эрх зүйн том үндэс шүү дээ.

Тэгээд энэ Уул уурхайн биржийн хуультай хамт оруулж ирнэ гээд Ёндон сайд алга болсон, өөрөө ч өөр тийшээ явсан. Одоо тэр олборлох салбарын ил тод байдлын тухай хууль, олон улсын байгууллагуудтай шаардаад тэр өгсөн авсан нь ил тод байдал, бүх шатны юмыг ил тод болгодог тэр хуулийг одоо яаралтай

оруулж ирэх хэрэгтэй байна. Тэгээд авлига, албан тушаалын гэмт хэргийн ялын бодлогыг чангатгах, тодорхой болгох, энэ төрлийн гэмт хэрэгт өршөөл уучлал үзүүлэхгүй байх, хөрөнгө хураах зэрэг шинэ санкцуудыг хуульд тусгах шаардлагатай гэж үзэж байгаа, энийгээ бас оруулж ирэх хэрэгтэй байна. Тэр уул уурхайн олборлох үйлдвэрлэлийн салбарын бүх төрлийн мэдээллийг ил тод, нээлттэй болгох хэрэгтэй байна. Нийгэмд лугшсан, ер нь тэгээд зөвхөн нүүрсний гэлгүй энэ хууль бус үйлдэл, авлига, албан тушаалын гэмт хэргийг илчлэн мэдээлэгчийг хамгаалах, төрийн хүнд суртал, чирэгдлийг арилгах, төрийн албан хаагчдын ёс зүйг хууль дүрмээр зохицуулах зайлиггүй шаардлага гарч байна аа. Иймээс энэ асуудлуудыг ирэх 7 хоногийн хуваарьт оруулж, энэ хяналт шалгалтын түр хороод маань ч гэсэн ирэх 7 хоногт эрчимтэй ажиллаж, гишүүд маань ч гэсэн одоо нэлээн мэдрэмжтэй, хурдтай энэ тэр Хяналт шалгалтын түр хороодын асуудал байна. Ирэх нэг дэх өдөр Хөгжлийн банкны асуудлыг Хянан шалгах түр хороо хуралдаж, гэрч дуудах албан тушаалтнуудын нэрсийг тодорхой болгож ажиллахаар одоо Баттөмөрийн Энхбаяр гишүүнтэй ажлын хэсэг санаачилгатай, хурдан ажиллаж байгаа. Энийгээ яаравчилъя. Тэр одоо өнөөдөр бас хэлэлцэнэ.

Тэр Хяналт шалгалтын түр хорооны хугацааг сунгана. Энэ нүүрсний хулгай бүр асуудлыг нь нарийн болгоод одоо тэр нь Хяналт шалгалтын түр хороон дээр төсөв мөнгө дутагдаж байгаа бол тэрийг нь шийдвэрлэж өгөөд Ганболд гишүүний Түр хороог одоо бүгдээрээ дэмжиж сайн ажиллах хэрэгтэй байна. Ингээд энэ ард түмний нийгмийн тайван жагсаалаар үзэл бодлоо илэрхийлж байгаа саналуудыг бол одоо түргэн

шуурхай шийдвэрлэхийг гэмт хэрэгтэй тэмцэх эрх бүхий байгууллагууд. Гүйцэтгэх засаглалаас шаардаж ажиллах ажлыг одоо Хууль зүйн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо холбогдох Байнгын хороод эрчимжүүлье. Одоо ингээд хэлэлцэх асуудалдаа орно.

Одоо бид *Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.*

Ажлын хэсгийн гишүүдийг оруулъя.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Пүрэвжавын Сайнзориг, Хууль зүй, дотоод хэргийн яамны сайд Хишгээгийн Нямбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын дарга Батсүхийн Болортуяа, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Ногоон хөгжлийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Борисын Буяннэмэх, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Дорждэрэмийн Цолмон. Цолмон дарга яасан бэ? Хууль зүйн яамныхан яасан бэ? Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хуулийн хэлтсийн дарга Сүхбаатарын Цогтгэрэл, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн болон газрын дарга Нармандахын Жамъянхүү. Жамъянхүү тийшээ суу. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Аялал жуулчлалын бодлогын зохицуулалтын газрын мэргэжилтэн Паламдоржийн Баярцэцэг, ИНЕГ-ын дарга Содномцэрэнгийн Мөнхнасан, Монголын эрх зүйн судалгаа хөгжлийн төв ТББ-ын хуульч Ренчинпүрэвийн

Н.Лхагвабаяр. Лхагвабаяр яасан энэ байна, босоорой.

Ингээд ажлын хэсгийн гишүүдийг танилцууллаа.

Гишүүд асуулт асууж, үг хэлж дууссан байгаа. Одоо бол Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна.

Байнгын хорооны саналаар Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Аялал жуулчлалын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлтэд оруулах тухай, Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Адъяаа гишүүн суудалдаа асуугаарай, санал хураалт явуулна.

Санал хураалт эхний санал хураалт учраас өнөөдрийн эхний санал

хураалтын бүртгэлийн санал хураалтыг явуулж байна.

Наранцогт дарга аа би таныг энэ бүртгэлийн санал хураалтад оролцохгүй байгаа гишүүдийг тасаар бүртгэж бай гэж хэлсэн шүү. Санал хураалтад оролцоогүй гишүүд хүртэл ирснээр бүртгэгдээд байгаа энэ асуудал гарсан шүү дээ. Тэгээд худлаа мэдээлэл, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд өгдгөө боль.

14 гишүүн ирцийнхээ бүртгэлд ороорой. Одоо санал хураалт явуулна.

Байнгын хорооны саналаар хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хуралт.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэн дэмжихийг тооцлоо.

Гэхдээ анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэх явцдаа Эдийн засгийн байнгын хороон дээр анхаарах зүйл маш их байна гэдгийг одоо гишүүд маш их ярьсан. Зайлигүй эдийн засгийг төрөлжүүлэх шаардлагатай байгаа учраас бодлогоо дэмжиж, гишүүд дэмжиж байгаа. Энийг асуулт саналын үед болон дэмжсэн, дэмжээгүй, үг хэлэх үедээ илэрхийлсэн ногоон хөгжлийн эрин үе гэгчхээд тэр амьтан, тэгээд л одоо олон асуудлуудаар дутуу, дутуу боловсруулсан, үг үсгийн зөрүүтэй найруулгын алдаатай маш олон асуудал байгаа. Энэ Хууль зүй, дотоод хэргийн яам ч бас хянаж байх хэрэгтэй. Хууль зүйн яамныхан алга байна. Нэлээн одоо анхаарлын тэмдэгтэйгээр гишүүд дэмжсэн гэдгийг сануулаад анхны хэлэлцүүлэгт

бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна.

Дараагийн асуудалд орно. “Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Тогмидын Доржханд танилцуулна. Индэрт урьж байна.

Т.Доржханд: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн, Хянан шалгах түр хорооны дарга Г.Ганболд 2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр хилийн боомтуудаар ачаа тээвэр, нүүрс нэвтрүүлэх болон чөлөөт бүсийн үйл ажиллагаанд учирч байгаа хүндрэлийг шалган тогтоох зорилго бүхий Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай санал ирүүлснийг Эдийн засгийн байнгын хороо 2022 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Монгол Улс хилийн боомтын асуудлыг хянан шалгах явцад холбогдох байгууллагуудаас авсан нотлох баримтуудыг нэгтгэн боловсруулах, нотлох баримтыг сонсголоор шинжлэн судлах зэрэгт тодорхой хугацаа шаардлагатай байгаа талаарх саналыг үндэслэн Эдийн засгийн байнгын хороо “Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан болно оо.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.8 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны

дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1дэх хэсэгт заасны дагуу тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах нь зүйтэй гэж үзэж, тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүдээ “Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхэнээс хүсье ээ.

Баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу?

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа.

Эрхэм гишүүн Ширнэнбандийн Адьшаа асуулт асууж үг хэлнэ.

Ш.Адьшаа: 2022 оны 6 сарын 3-ны өдөр миний бие Улсын Их Хурлын гишүүнийхээ хууль санаачлах бүрэн эрхийн хүрээнд энэ хилийн боомтын үйл ажиллагаа, нүүрс тээвэрлэлттэй холбоотой ажлыг шалгах Улсын Их Хурлын Хяналт шалгалтын хуулийн дагуу Хяналт шалгалтын тухай түр хороо байгуулахаар Улсын Их Хурлын 26 гишүүнээр гарын үсэг зуруулж, энэ Хянан шалгах түр хороог байгуулсан. Энэ хугацаанд энэ нүүрс тээвэрлэлт, нүүрсний хулгай, луйвар, энэ оффтейк гэрээтэй холбоотой олон ажлуудыг

энэ Хяналт шалгах түр хороо шалгаж, судалгаа шинжилгээ, дүгнэлт хийж, шинжээч болон хянан шалгагчдыг томилж үйл ажиллагаа явуулсан. Энэ асуудал бол өнөөдөр нийгэмд хамгийн их анхаарал татаж байгаа Монгол Улсын баялаг, ард түмний баялгийг хулгайлдаг, луйварддаг энэ сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд болсон энэ бусармаг үйл явдлыг таслан зогсоох, төр хэний талд байна гэдгийг харах ийм одоо чухал ач холбогдолтой ийм үйл ажиллагаа болж байгаа. Энэ хугацаанд олон одоо эрсдэлийг давсан олон асуудалтай энэ Түр хороо тулгарсан. Түүний дотор Улсын Их Хурлын энэ Түр хороо ажиллах нөхцөл бололцоо, төсөв хөрөнгө санхүү, бусад асуудлыг ч гэсэн шийдэхэд их бэрхшээл учирч байсан.

Одоо энэ асуудалд Улсын Их Хурал, Засгийн газар энэ асуудалд ард түмний шаардлагаар анхаарал хандуулж ажиллах цаг болсон. Энэ асуудал дээр бид олон зүйлийг холбогдуулж, олон асуудлыг шалгаж, нэг мөр болгох ёстой. Нэн ялангуяа энэ улсын нууцтай холбоотой гэдэг нэрийдлээр тэр оффтейк гэрээний асуудлыг ярихаар ерөөсөө гаргаж өгөхгүй байсан. Одоо хэзээ Засгийн газар гаргаж өгөх юм. Түүнчлэн энэ Хяналт шалгалтын түр хороог цааш нь сунгах асуудлыг бол зарчмын хувьд дэмжиж байгаа. Ингэж сунгаж, энийг ард түмний хяналт, төрийн эрх барих дээд байгууллагын хяналт дор шийдэхгүй бол болохгүй байна.

Сүүлийн үед бүр энэ Хяналт шалгалтын түр хороонд орсон зарим гишүүдийг нүүрсний хулгайч мэтээр энэ захиалгаар зарим хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэрийг нь цоллож байгаад их харамсаж байгаа. Энэ нүүрсний хулгайч бүлэглэл, түүнчлэн энэ газрын баялгийг авдаг,

ялангуяа энэ одоо орон нутагт, тэр Халзан бүрэгтэй, Хар ус нуурын хотгоруудад хулгай луйвар хийхээр энэ нүүрстэй адилхан байгалийн баялгийг хулгайлахаар байгаа энэ бүлэглэл хүртэл энэ асуудалд одоо тэр ажлыг эхлүүлсэн, шударга ёсыг ярьсан, ард түмний талд байсан төрийн түшээдийг харлуулах ийм үйл ажиллагаа явуулж байгаад их туйлын харамсалтай байна аа. Энэ Түр хорооны үйл ажиллагааг цаашид өргөтгөх ёстой. Бид энд ард иргэдийн төлөөллийг оролцуулах, хэвлэл мэдээллийг оролцуулах, нээлттэй болгох, энэ сонсголын хүрээнд ч гэсэн энэ асуудлыг шалгаж шийдэх нь өнөөдөр Монгол төрийн үүрэг, Монголын ард түмний язгуур эрх ашиг байна гэдэгт би санал нэг байгаа. Энэ Түр хороогоор дамжуулж энэ хулгай луйврыг нэн ялангуяа төрийн өмчийг үнэгүйдүүлдэг, төрийн өмч дээр тулгуурласан хулгай луйвар хийдэг энэ схемийг таслан зогсоох ёстой. Энд Түр хорооны дараа энэ гарах хууль эрх зүйн бодлогыг ч гэсэн энийг шалгаж шийдвэрлэх нь нийт Монголын ард түмний язгуур эрх ашиг гэсэн ийм одоо байр суурьтай байна.

Г.Занданшатар: Адьшаа гишүүн үг хэллээ, тийм ээ.

Одоо Содномын Чинзориг гишүүн.

С.Чинзориг: Түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай асуудал орж ирж байгаа юм байна. Яах вэ асуудлыг нь дэмжиж байна. Гэхдээ одоо бид нар чинь нэлээн амаргүй л нөхцөл байдалтай ажиллаж байна л даа. Гаднаа одоо бас жагсагчидтай энэ нүүрсний хулгайтай тэмц, холбогдсон улс төрчдийг нэрлэ, хариуцлага тооц гээд ингээд. Тэгээд ийм, одоо нөхцөл байдал

бид энэ Түр хорооны хугацааг сунгах асуудал яригдаж байна. Гэхдээ энэ Түр хороо байгуулагдаад бас багагүй хугацаа өнгөрсөн л дөө. 6 сарын хугацаа өнгөрсөн. Тэгэхээр энэ түр хорооны даргаас энэ 6 сарын хугацаанд Түр хороо ямар ажил хийгээд, ямар ордоо үр дүнд хүрчих вэ? Тэгэхээр одоо та бүхний Түр хорооны хүрээнд шийдэж чадахгүй байгаа зайлшгүй одоо Их Хурлаас парламентаас дэмжлэг одоо авах ямар одоо асуудлууд байна гэж та бүхэн одоо үзэж байна вэ?

Тухайлбал, энэ гэрээний нууцлалтай холбоотой асуудлууд хэчнээн одоо гэрээ нууцлалын зэрэглэлтэй хэчнээн эрээ байгаа юм, хэд нь одоо нууцлалаас гарч байгаа юм. Хэд нь одоо нууцлалаас гараагүй байна вэ? Энэ төмөр замын бүтээн байгуулалтын ажлуудтай холбоотой, үнийн зөрүүтэй асар их зөрүүтэй асуудлууд ярьдаг. Гашиун сухайтын зам нь 5 сая доллар километр нь. Богд хаан зам төмөр зам нь болохоор километр нь 8 сая доллар ч юм уу.

Гэтэл сая энэ хувийн хэвшил чинь Ханги чиглэлийн замыг чинь километр нь 1.7 сая долларын өртөгтэйгөөр 8 сарын хугацаанд бариад л босгочхоод бол болж байна шүү дээ. Тэгэхээр энэ төмөр замын гэрээ чинь одоо нууц байгаа юм уу, ил байгаа юм уу гэх мэтчилэн та бүхнийг одоо энэ ажиллахад бас Их Хурлын зүгээс парламентын зүгээс ямар одоо дэмжлэг байна гэж та бүхэн одоо үзэж байгаа юм. Ер нь түр хороо яагаад энэ иргэдэд олон түмэнд бодитой мэдээлэл Их Хурлын гишүүд ч гэсэн өгөхгүй байгаа юм. Түр хорооны гишүүд гээд энэ Доржханд гишүүн эд нар өөрсдөө л яриад байх юм. Энэ бол одоо баттай тоо гээд л бараг чинь одоо 40 их наядын хулгай энэ нүүрс

дээр гарсан гээд л Доржханд гишүүн хэвлэлээр яриад байх юм.

Тэгэхээр Түр хороо бүрэн бүрэлдэхүүнээрээ юм уу байж байгаад олон нийтэд Их Хуралд эд нар тодорхой бодитой мэдээлэл өгөх өгч болохгүй байгаа юм уу? Түр хороон дотор байгаа гишүүд чинь өөрсдөө ингээд улс төр хийгээд байгаа юм биш биз дээ гэсэн би ийм бас хардлага байгаа юм. Тэгээд та бүхэн одоо энэ чуулган дээр энэ яг одоо Түр хороо ямар ажил хийгээд байгаа юм, ямар үр дүнд байгаа юм. Яг үнэхээр тийм бодитой хулгай байгаа юм уу гэдэг талаар тодорхой бас мэдээлэл одоо өгөөч. Намайг Засгийн газарт ажиллаж байхад 2018 билүү, 2019 онд санаж байна, Энэ Хүрэлбаатар сайд энэ нүүрстэй холбоотой асуудлыг шалгаад 370 орчим мянган тонн нүүрс бас алдагдсан байх магадлалтай байна. Тодорхой хэмжээний, тооны машинууд, улсын дугаар нь тодорхой машинууд 2 талдаа дандаа хоосон орж гарсан гэсэн мэдүүлэгтэй байна энэ тэр гээд асуудал маш их ярьсан. Тэгээд тэрийг тухайн үедээ Засгийн газар дээр яриад цагдаагийн байгууллагад шилжвэл хууль хяналтын байгууллагаар шалгуул гээд л 3 жилийн өмнө цагдаад шилжүүлсэн. Одоогоор ерөөсөө хариу байдаггүй. Энэ мэтчилэн ингээд өмнө нь ажлын хэсэг гарсан Засгийн газраар шалгаад хууль хяналтын байгууллагуудад шилжүүлсэн, хэчнээн нүүрсний хулгайтай холбоотой хэрэг байгаа юм. Тэдгээр нь явц нь ямар байгаа юм, яагаад одоо шийдэгдэхгүй байгаа юм? Зарим нь бүр одоо бас хууль хяналтын байгууллага дээр хэрэгсэхгүй болсон, хаагдсан гэсэн ийм одоо мэдээллүүд байна шүү дээ.

Тэгэхээр одоо Түр хороо бас өөрсдийн хэмжээнд олсон энэ 6 сарын

хугацаанд олсон энэ одоо баримт дээр нь тулгуурлаад үнэн бодитой мэдээллийг иргэдэд, ялангуяа энэ парламентад өгөх хэрэгтэй байна. Тэгэхээр энэ дээр Түр хорооны дарга бас энэ дээр тодорхой бас мэдээлэл өгөх байх гэж бол бодож байна.

Г.Занданшатар: Түр хорооны дарга Гочоогийн Ганболд гишүүн асуултад хариулна.

Г.Ганболд: Манай Түр хороо бол Улсын Их Хурлаас байгуулсан 3 дахь Түр хороо. Өмнөх түр хороодууд ч гэсэн хугацаагаа сунгаад явж байгаа. Түр хорооны ажлын хүрээнд бид нар нотлох баримт цуглуулах гэрч дуудаж байцаах гээд цаг хугацаа их орж байна. Хянан шалгагч нар ажиллуулж байна. Шинжээч нар цуглуулагдсан материал дээр сууж байна.

Тийм учраас одоо шууд бид нар одоо нотлоод ийм боллоо гэж зарлахад бол эрт байгаа юм. Тийм учраас бид нар өнөөдөр одоо энэ хугацааг нь сунгах хүсэлт оруулж байгаа юм. Түр хороо бол үүргээ гүйцэтгэж байгаа. Дөнгөж сая Пүрэвдорж гишүүн хэлж байна. Өмнө нь 2 жил одоо энэ нүүрсний хулгай гэж би орилсон гэж. Өмнө нь ч гэсэн бас Энхболд гээд гишүүн 3 жилийн энэ чуулганы танхимд энэ нүүрсний хулгайн талаар орилсон. Хэн ч тоогоогүй. Энэ Түр хороо ажилласнаар нийгмийн анхаарлын төвд орж, өнөөдрийн нүүрсний хулгайн асуудал ийм түвшинд ороод явж байгаа юм.

Тэгэхээр сая Чинзориг гишүүн асууж байна, энэ оффтейк гэрээнүүд гэж. Нууц гэрээ учраас Их Хурлын гишүүд ч энтэй танилцах боломжгүй байгаа. Харин Улсын Их Хурлын түр хороо бол хуулийн дагуу энэ нууц гэрээнүүдтэй танилцах ийм боломж л

олдож байгаа. Саяхан Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан хяналтын ерөнхий сонсгол хийх ажлын хэсэг байгуулагдсан. Энэ хүрээнд энэ оффтейк нууц гэрээнүүдийг ил болгож 12 сарын 21-ний өдөр иргэдэд нээлттэй хэлэлцэхээр байгаа. Энэ бол энэ Түр хорооны хамгийн том үр дүн гэж хэлэх байна. Яагаад гэхээр энэ нууц гэрээнүүд ил болоод энэ гэрээнүүдийн цаана тэр сая таны хэлж байгаа төмөр замуудыг ямар үнэтэй барьж байгуулсан юм. Тэр барьж байгуулсныхаа хөлсөнд нүүрсийг одоо ямар үнээр авсан юм гээд энэ бүх зүйлүүдийг ил болно гэдэгт бол би эргэлзэхгүй байгаа.

Тийм учраас энэ гэрээнүүд ил болоод хяналтын ерөнхий сонсгол хийгээд ирэхээр бол олон нийтэд энэ асуудал нэлээн тодорхой болно.

44 их наядтай холбоотой Доржханд гишүүн нийгэмд ярьсан. Доржханд гишүүн бол Түр хорооны гишүүн мөн. Нэг гишүүн. Тэгэхдээ түр хорооны хуралд нэг ч суугаагүй ээ, нэг ч суугаагүй. Түр хороон дээр бол энэ 44 их наядтай холбоотой нэг ч нүүрсний мөнгөн дүнгийн асуудал яригдаагүй. Энийг одоо энд сууж байсан энэ Ганбаатар гишүүн бусад бүх гишүүн мэдэж байгаа.

Тэгэхээр өнөөдөр энэ нийгмийг талцуулаад байгаа, ард түмнийг төртэй нь толхилцуулдаг, өвлийн хүйтэнд энэ асар олон иргэдийг жагсаадаг, энэ мэдээллийнхээ төлөө Доржханд гишүүн өөрөө тэр гаргасан мэдээллийнхээ үнэн бодит байдлыг харууцах ёстой.

Нийгэмд энэ гаргаж ирсэн дүнгээ ямар үндэслэлээр, ямар тооцоо судалгаатай гаргаж ирснээ

тайлбарлах ёстой. Яагаад гэхээр зэрэг өнөөдөр одоо өвлийн хүйтэнд баахан ард түмэн 44 их наядын төлөө жагсаад байдаг.

Өнөөдөр бид нар бол Түр хороон дээр яг бодитой яригдаж байгаа зүйл бол нэг 2.5 сая тонн нүүрсний хулгай, нотлох баримт цуглуулах тухай асуудал л яригдаад явж байгаа юм. Тэгэхээр зэрэг энэнийхээ төлөө бол Доржханд гишүүн өөрөө тайлбар хийгээд, хэрэв буруу мэдээлэл өгсөн бол ард түмнээс, тэр дундаа энэ өвлийн хүйтэнд жагссан иргэдээс мөн одоо энэ иргэдийн жагсаалаас өмнө зогсож байгаад эрүүл мэндийн хувьд эрсдэл хүлээсэн энэ төрийн албан хаагчдаас цагдаагийн албан хаагчдаас уучлалт хүсэх ёстой гэж би бодож байна. Түр хорооны даргын хувьд.

Г.Занданшатар: Жигжидийн Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Түр хорооныхоо ажиллах хугацааг сунгах энэ саналыг дэмжиж байгаа. Гэхдээ 2, 3 зүйл дээр бүр нэлээн тодруулж тодорхой ярих ёстой юм болов уу гэж ингэж ойлгоод байна. Энэ Түр хороог эрх зүйд нийцэж ажиллах бололцоо боломжийг нь бид бүрдүүлж өгөх ёстой. Энэ талаар Их Хурал ч тэр, Засгийн газар ч тэр, хууль хяналтын байгууллагууд ч тэр аль аль талдаа онцгой анхаарал хандуулж, мэдээллээр хангаж, ажиллах орчин нөхцөлийг нь бүрдүүлж өгч, эрх зүйн зөв зохицуулалтаар нь бас хангаж өгөх ёстой, өнөөдөр бид нар янз бүрийн мэдээллүүдийг ил болго гээд л бүгдээрээ дуугарч байгаа. Гэхдээ бид Үндсэн хууль эрх зүйт төрийг төлөвшүүлж яваа улсууд.

Үндсэн хуульд тов тодорхой үг хэллэгүүд байгаа. Шүүх хэн нэгнийг гэм буруутай гэж тогтоогоогүй бол

урьдчилж хэн нэгэн гэм буруутай гэж ярьдаг тийм зүйл байхгүй ээ.

Тийм учраас тэр мөрдөн шалгах чиг үүрэг хүлээсэн байгууллагууд нь энэ асуудлаа бүрэн төгс хийж, маш яаралтай энийгээ гаргаж тавих ёстой, нэг.

Хоёрдугаарт, энэ Түр хороо нууцын зэрэглэлтэй байгаа материалуудыг одоо баталгаага гаргаад ороод үзлээ. Үзсэн юмаа эргээд мэдээлэх бололцоо байгаа юм уу? Нууцаас гараагүй тохиолдолд үзсэн материалыг ил гаргаад ярих бололцоо байгаа юм уу?

Тийм учраас энэ нууцын зэрэглэлд байгаа материалуудаа ил болгох тэр шийдлээ гаргаж өгч байж энэ улсуудыг ярьж, хэлэх эрхийг нь нээж өгөх ёстой гэж би ингэж ойлгож байна. Тийм учраас энэ тал дээр нь 1 онцгой анхаармаар байна гэж.

Дараагийн нэг зүйл. Нэгэнт нөхцөл байдал, анх байгуулагдаж байх үеийн Түр хороо, одоо ажиллах Түр хороо хоёрын ажлын чиглэл дээр бас нэлээн тодотгох ёстой юмнууд байгаад байх шиг байна. Үүссэн нөхцөл байдалтайгаа уялдуулж, энэ Түр хорооны ажиллах цар хүрээг нь чиглэлийг нь тодорхой болгож баталж өгөх зайлигүй шаардлагатай болов уу гэж би ингэж бодож байгаа. Энэ асуудлыг нэг шийдмээр байна. Мэдээж мөрдөн шалгадаг, тогтоодог байгууллагууд юмаа тогтоогоод, гэм буруутай нөхдүүдэд оногдох гэм зэмийг нь оногдуулах ёстой. Энүүнийг бол бүрэн дэмжиж, шахаж шаардаж ажиллах ёстой гэж Их Хурлын гишүүний хувьд ч энэ одоо бодлого дээр байх болно гэдгээ зориуд хэлмээр байна.

Дараагийн нэг хэлэх ёстой санаа бол хулгайн юмнууд явжээ. Тэгвэл цаашид явахгүй байх баталгаа, эрх зүйн зохицуулалтыг нь бид хийж өгөх ёстой. Тэгвэл одоо Улсын Их Хурал энэ янз бүрийн хуулиуд хэлэлцээд байгаа юмнуудаа бодож дараалал юмаа зөв тогтоох хэрэгтэй байна аа.

Тийм учраас Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын тухай хууль, энэ Уул уурхайн биржийн тухай хуулийг маш яаралтай хэлэлцэж, өнөөдрийн энэ үүсээд байгаа нөхцөл байдлуудыг арилгах, зөв зохицуулах, зарим тохиолдолд тэр ТУЗ, гүйцэтгэх захирлын эрх мэдэл юмнуудыг хязгаарлах, чагтлах, түгжих ийм заалтуудыг нь оруулж энэ хуулийг батлах ёстой.

Ингэж байж цаашид энэ төрийн өмч дагасан янз бүрийн хулгай луйвар арилах ёстой. Дээр нь энэ компаниудыг олон нийтийн засаглалтай болгох тал дээр Монгол Улсын Их Хурал энэ өмчийнх нь эзэн мөн юм бол шийдвэрээ гаргах ёстой. Энэ том том үнэ цэнтэй компаниудыг яаж олон нийтийн засаглалтай болгох үзэл баримтлал барих ёстой юм бэ, хэдэн хувь нь төрдөө үлдэх ёстой юм. Хэдэн хувь нь иргэддээ очих ёстой юм, хэдэн хувь нь тэр биржээрээ дамжиж, үнэт цаасны борлуулалт.

Г.Занданшатар: Ганболд гишүүн хариулах уу? Гочоогийн Ганболд гишүүн. Түр хорооны дарга.

Г.Ганболд: Батжаргал гишүүн бол зөв асуудал хөндөж байгаа юм аа.

Бид нар бол яах вэ, хуулийн дагуу одоо ингээд оффтейк гээд энэ нууц гэрээнүүдтэй танилцах боломж бол

байгаа. Тэгэхдээ одоо Засгийн газраас энэ нууц гэрээнүүдийг ил болгох шийдвэр гарахаас нааш бол олон нийтэд мэдээлэх бол боломж бол байхгүй байгаа, гэхдээ бид нар бол Ерөнхий сайд Хэрэг эрхлэхийн даргад л энэ 21-ний сонсголоос өмнө ил болгож өгөх хүсэлт тавьсан.

Тийм учраас энэ чиглэлээр бол Засгийн газраас ажиллаж, ямар ч байсан ил болгож өгөх өгнө өө гэдгээ бол илэрхийлсэн байгаа. Тийм учраас энэ одоо гэрээнүүд ил болно. Гэрээнүүд ил болж байж энэ хүмүүсийн хүсээд байгаа бас нэрүүд ч тодорхой болно гэж би хараад байгаа юм л даа. Гэрээ нь нууц учраас хэнтэй гэрээ хийснийг нь бид нар мэдэхгүй байна шүү дээ, нийгэм ч мэдэхгүй байна. Бид нар чинь өөрсдөө мэдэхгүй байна. Хэдэн төгрөгийн гэрээ хийснийг нь мэдэхгүй байна. Тэгэхээр зэрэг энэ нууц гэрээнүүд ил болоод ирэх юм бол цаана нь давхар мөнгөн дүн нь, гэрээ хийсэн эзэд нь тодорхой болоод ирэхээр энэ нийгмийн энэ хүсэн хүлээгээд байгаа энэ хүсэмжлэл бол одоо хангагдана гэж ойлгоод байгаа юм. Тэгээд энэ хүрээнд бас би Засгийн газрыг энэ нууц гэрээнүүдийг ил болгох тал дээр тодорхой шийдвэрүүд гаргаж өгнө өө гэж итгэж байгаа.

Батжаргал гишүүний дараагийн хэлж байгаа зүйл бол бид нар энэ Түр хорооны ажиллах чиг үүргийн хувьд бол анх хил, боомтын асуудлаар одоо хүндрэл бэрхшээлийг шалган тогтоох гэх нэртэй боловч дотор нь бол энэ саяын яригдаж байгаа сэдэв бол нөгөө хамрах хүрээндээ орчихсон явж байгаа учраас энийг заавал би одоо тодотгох шаардлага байхгүй, ингээд хуучин тогтоолоороо явах боломжтой гэж ингэж бодож байна.

Г.Занданшатар: Бадарчийн Жаргалмаа гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Б.Жаргалмаа: Та бүхнийхээ өглөөний амгаланг айлтгая. Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах, одоо энэ тогтоолын төслийг бол дэмжиж байгаа. Яагаад гэвэл өнөөдөр Монгол Улсад өсөөд байгаа нөхцөл байдлын хамгийн гол цөмийг хариуцан шийдвэрлэх эрх бүхий Улсын Их Хурлын Түр хороо гэж би харж байна. Өнөөдөр яагаад олон нийт гадаа жагсаад байгаа юм бэ. Энэ жагсаал цаг хугацааны хувьд болох ёстой байсан гэдэг дээр ард олон бол итгэлтэй байгаа. Ард нийт биднээс юу хүсээд байна вэ? Мэдээллээ ил тод, нээлттэй байлгаач ээ, хариуцлага тооцооч ээ гэдэг зүйлийг бид нар шаардаж байгаа. Нүүрсний хэрэг гэдэг одоо энэ нэг хөмсөгтэй, үнэн худал нь мэдэгдэхгүй энэ нэрийн дор маш олон мэдээллүүд хөвөрч байна. Хардах үүднээсээ хэн ч хардах эрхтэй, ард түмэн хардах эрхтэй, энэ парламентад ард түмнийг төлөөлж байгаа гишүүн ч хардах эрхтэй.

Яагаад энэ хардлага дор ийм эмх замбараагүй байдал үүсэв ээ гэвэл бид мэдээллээ олон нийтдээ ил тод өгч чадахгүй байна. Бид ард түмнээсээ ямарваа нэгэн зүйлийг нууж байна. Энэ нуулт энэ хардлага, энэ бүрхэг мэдээлэл ард олныг ийм байдалд хүргэж байгаа. Улсын Их Хуралд сууж байгаа гишүүд нь Улсын Их Хурлаас томилогдон ажиллаж байгаа Түр хорооны гишүүд нь зөрүүтэй мэдээлэл өгснөөс шалтгаалаад олон нийтийн бухимдал дээд цэгтээ хүрч байгаа. Өчигдөр Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын сайд нар жагсагчидтай гарч уулзсанд бас би талархлаа илэрхийлмээр байна. Яагаад гэвэл бид ард түмэнтэйгээ

хамт байх ёстой. Бид аливаа мэдээллийг цаг тухайдаа хийж байгаа ажлаа олон, нийтдээ бодитойгоор тайлбарлаж чадаагүйгээс ийм нөхцөл байдал үүсдэг гэдгийг бид бүгдээрээ мэднэ. Одоо олон түмний хардлага бүр дээд цэгтээ хүрч байна. Энэ бол цаанаасаа зохион байгуулалттай жүжиг. Ардын нам дотроо хагарсан учраас албаар ард түмнийг ийнхүү турхирч байна. Ийм мэдээллийг парламентад сонгогдсон гишүүний хувьд сонсож суумааргүй байна. Нээлттэй мэдээлээч ээ гэдэг хүсэлтийг бас тавьж байгаа.

Үнэхээр нээлттэй сонсголыг Улсын Их Хурлаас 12 дугаар сарын 21-нд зохион байгуулах гэж байгаад талархаж байна. Ганболд дарга аа сая Чинзориг гишүүн бас асуучихлаа. Өнгөрсөн 6 сарын хугацаанд бид юу хийж чадав. Яагаад мэдээллээ Их Хуралдаа тайлагнаагүй юм бэ? Их Хурлын гишүүд нь ядаж мэдээлэлтэй байсан бол зөрүүтэй мэдээллийг олон нийтэд өгөхгүй байх байсан. Ард түмнийг ингэж будилуулахгүй байсан. Өчигдөр Засгийн газраас ард түмэнтэйгээ нийлээд ажлын хэсэг байгуулъя гэж байна. Улсын Их Хурал дахь Түр хороо нь энэ Засгийн газарт байгуулагдсан ажлын хэсэгтэйгээ яаж хамтрах юм бэ? Бидэнд илүү боломж байгаа. Бид Засгийн газартаа чиглэл өгөх, хууль эрх зүйд нь өөрчлөлт орох боломж байгаа. Энэ боломжоо хэрхэн яаж ашиглах вэ, энд Түр хороонд боломж байна уу гэдэг асуултыг асууя аа?

Хил, гаалийнхны мэдээлэл зөрсөн гээд байх юм? Монгол Улс чинь нэгдсэн улс биш юм уу, нэг улс биш юм уу? Яагаад мэдээллүүд нь зөрөөд байдаг юм? Зөрүүтэй мэдээлэл өгөөд байгаа тэр ажилтан албан хаагчдад хариуцлага тооцож болдоггүй юм уу?

Өнөөдөр парламентад сууж байгаа 76 хулгайчийн нэг нь Жаргалмаа болчихоод сууж байгаа нь, нүүрсчин болчихоод сууж байгаа энэ нэр бол миний хувьд дэндүү гоёдоод байна. Би бас олон нийтийг мэдээллийг үнэн зөв дээр хамтдаа бас шийдвэрлэх энэ цагт хэн нэгний буруу ятгалгад орохгүй, автахгүй байхыг бас уриалж байна. Хариултаа авъя.

Гочоогийн Ганболд гишүүн.

Г.Ганболд: Бид нар бол яг таны хэлээд байгаа тэр хилийн мэдээлэл, гаалийн бүрдүүлэлт хоёрын зөрөө гэж яриад байгаа. Тэрийг л тогтоох гэж оролдоод байгаа юм.

2013 онд анх тэр илэрсэн Хятадын болон Монголын гаалийн одоо 2 талын мэдээллээр тулгаад тогтоогдсон зүйлийг тухайн үед нь хууль шүүхийн байгууллагууд шийдээд явсан бол өнөөдөр энэ хулгай гэдэг юм бол даамжрахгүй байсан гэдэгтэй бол би санал нэг байгаа. Тэрийг хэрэгсэхгүй болгосонтой холбоотой энэ зүйл бол даамжирсан. Тийм учраас энийг тогтоохын тулд цаг хугацаа ороод байгаа юм Жаргалмаа гишүүн ээ.

Өнгөрсөн 6 сарын хугацаанд бид нар энэ чиглэлээр нотлох гэж, хамгийн гол нь бид нарын зорилго бол нотлох баримт цуглуулах үнэхээр энэ хоосон гарсан гээд байгаа тэр 22664 машин гэж байгаа машинууд эндээс хоосон гэж бүртгүүлсэн хэрнээ Хятад руу яг нүүрстэй гарч үү гэдгийг нотлох гэж нэг талын мэдээллээр бид нар нотлох боломж байхгүй байгаа юм Монголыг.

Тэр утгаараа бол Монголын гаалийн байгууллага, хуулийн байгууллагууд Хятадын холбогдох байгууллагууд руу удаа дараа энэ машинуудын Монголын гаалиас

гарахдаа хоосон гэсэн мэдээлэлтэй машинууд Хятадын гааль руу орохдоо нүүрстэй орж уу, хоосон орж уу гэдгийг нь нотлох гэж удаа дараа бичиг явуулаад Хятадын талаас бол хариу өгөөгүй.

Тийм учраас бид нар Гадаад харилцааны яамаар дамжуулж Хятадын Хөгжил шинэтгэлийн хороо руу албан бичиг явуулсан хариу ирсэн. Дахиад гаалийн байгууллага руу нь албан бичиг явуулаад, зөвхөн одоо Хятадын гаалийн мэдээллээс гадна бид нар, олон улсын одоо байгууллагууд, энэ чиглэлийн мэдээлэл солилцдог олон байгууллагуудаас төлбөртэй мэдээллүүд авч, энэ мэдээллүүдийг тодорхой болгож, нотлох баримтаа бид нар цуглуулж, бодитойгоор энэ асуудалд хандаж Их Хуралд тайлагнахгүй бол аль нэг талын мэдээллээр бид нар Их Хурал дээр хөнгөн хуумгай хэн нэгнийг буруутгасан ийм мэдээлэл өгөх боломжгүй байсан юм.

Тийм учраас энэ Түр хорооны ажиллахад бол хугацаа ороод байгаа юм. Тэгэхээр зэрэг энэ хүрээнд бид нар энэ ойрын үед Хятадын талаас болон бас олон улсын одоо байгууллагуудад хандаж энэ мэдээллүүдийг авч тодорхой болсон үед нь Их Хуралд тайлангаа тавина. Гэхдээ бид нар аль болохоор энэ 12 сардаа багтаж нээлттэй сонсгол хийж энэ тайлангаа тавья гэсэн ийм зорилготой явж байгаа.

Г.Занданишатар: Асуулт, үг нэг учраас нэмэлт минут байхгүй. Жаргалмаа гишүүн энэ Түр хорооны ажил энэ юмнууддаа идэвхтэй оролцож бай.

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Би 3 зүйл асуух гэж байгаа юм. Үүний өмнө би бас нэг зүйл хэлье гэж байгаа юм. Ер нь бол энэ ковидын цар тахлын хатуу хорио цуцлагдсан байгаатай холбоотойгоор Их Хурлын чуулган биечилж хуралдах ийм боломжийг л бид нар анхаарах ёстой гэж би хэлэх гээд байгаа юм. Яагаад гэвэл энэ жагсаал цуглаантай холбоотой онц байдал энэ асуудалтай холбогдуулаад нөгөө цахимаар хуралдсан. I Rad төхөөрөмж ашиглах бололцоо зарим хүмүүст хязгаарлагдмал байсан учраас гар утсаараа орсон. Миний хувьд тухайлах юм бол санал хэлье гээд гар өргөөд ингээд санал хэлэх бололцоо олдсонгүй. Би энэ 2008 оны үйл явдалтай холбоотойгоор, үүний дараа үүссэн нөхцөл байдалтай холбоотой Их Хурлын ажлын хэсэгт орж ажиллаж байсан хүний хувьд бол энэ онц байдал тогтоохтой холбоотой асуудал бас нэлээн ээдрээ түвэгтэй бөгөөд анхаарал тавих ийм л шаардлагатай байдаг.

Тэр талаасаа би санал хэлье гээд хэлэх бололцоо олдоогүй. Би чатаар өөрийнхөө саналыг хэлсэн байгаа.

Тухайлах юм бол энэ давын өмнө хуулийн лавлагаа авах шаардлагатай байна гээд. Тэгээд миний санал бол их тодорхой байсан. Тийм учраас бол бид цаашид хэрвээ энэ ордонд танхимдаа хуралдах чуулган хуралдах бололцоо байхгүй бол өөр газар 2 дахь, 3 дахь хувилбараар биечлэн хуралдах ийм боломжийг нь хангах талын ийм асуудлыг бодолцох ёстой юм байна гэдэг ийм зүйлийг би санал хэлж байгаа юм.

Дараагийнх нь юм бол энэ нүүрстэй холбоотой асуудал. Энэ

өнөөдрийн Хянан шалгах түр хорооны хугацааг сунгая гэдэг дээр бол дэмжиж байгаа. Сунгаж ажиллуулах ёстой. Тэгээд энэ нүүрсний хулгай, луйвартай холбоотой асуудал чинь ер нь энэ Таван толгой орд хөдөлгөөнд орж эхэлсэн 2011, 2012 оноос хойш л эхэлсэн. Их олон жил одоо 10-аад жил явсан, ийм ужгирсан зүйл шүү дээ. Энэ нэг сүүлийн 4, 5 жилийн хугацааны асуудал биш ийм байгаа юм. Тэгээд Их Хурал анхаарал тавиад Хянан шалгах хууль батлагдсан. Энэ хуулийнхаа хүрээнд хянан шалгах Түр хороо байгуулаад ажиллаж байгаа.

Дээрээс нь Засгийн газар яаралтай арга хэмжээ аваад энэ төрийн мэдлийн Эрдэнэс Таван толгойтой холбоотой асуудлаар бүрэн эрхт төлөөлөгч томилоод, онц байдал тогтоогоод ингээд сар хүрэхгүй хугацаанд ажиллаж, тодорхой үр дүнд хүрч ажиллаж байгаа гэдгийг бид бүгдээрээ мэдэж байгаа юм. Тэгэхээр зэрэг бол одоо энэ тулгамдаад байгаа асуудал, миний ойлгож байгаагаар бол юу л даа, тэр тээвэр туургатай холбоотой нэг багц асуудал байна гэж ингэж ойлгогдож байгаа юм. Ялангуяа тэр Си зөвшөөрөл 6000 гэж яриад байгаа. 9000 машин тээвэр. Үүний цаад талд ямар одоо эрх мэдэл, нөлөө бүхий этгээдүүд байна аа? Энийг тодорхой болгох ийм шаардлага байна.

Оффтейк гэрээтэй холбоотой асуудал бол ойлгомжтой. Үүний зэрэгцээгээр энэ гэрээ хийдэг, нүүрсний гэрээнүүдийг аваад дундаас нь ашиг олдог ийм бүлэглэл байгаад байгаа. Олон жил явж ирсэн ийм зүйл байгаад байх шиг байгаа юм. Энийг одоо бас их тодорхой болгох шаардлагатай байна гэж.

Дараагаар нь бол тэр ачаад одоо гаргачихсан гэдэг ийм нэг тоо яваад байгаа. Энийг одоо мухарлах зайлшгүй шаардлага байна. Ер нь бол энэ тээврийн дундаас нь ашиг олж байгаа бүлэглэлийн одоо зорилгоор энэ төмөр замыг барьж ашиглалтад оруулахтай холбоотой асуудлыг их олон жил гацаасан, ийм зүйл яригдаад байгаа. Тэгэхээр зэрэг энэ бол алдагдсан боломжууд ямар боломжуудыг алдсан юм бэ гэдэг юмыг нэг тодорхой болгох ийм шаардлага байгаа болов уу гэж бодож байгаа юм.

Яах вэ бид нар энэ Хөгжлийн банкны хулгай луйвартай холбоотойгоор ажлын хэсэг байгуулахыг шаардаж байж ажлын хэсэг байгуулаад ажиллаад, тэгээд одоо бас тэнд бол зовлон.

Г.Занданшатар: Гочоогийн Ганболд гишүүн, Түр хорооны дарга асуултад хариулна.

Г.Ганболд: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Тийм ээ, ер нь бол зөвхөн одоо нүүрс гэхээс илүүтэй бас тээвэр. Тээвэр дотроо одоо энэ бөмбөлөг тээвэр, Си зөвшөөрлийн асуудал гээд маш олон зүйл байгаа юм. Си зөвшөөрлийн хувьд бол Зам, тээврийн яам өгч байсан. Одоо Боомтын зөвлөл цаашидаа бол ингээд тухайн аж ахуйн нэгжүүд нь нүүрс экспортолж байгаа гаргадаг, нөгөө аж ахуйн нэгжүүд нь Си зөвшөөрлөө өгөхөөр болж байгаа юм байна. Тэгэхээр тэр зөвшөөрөл бол нэг 6000 машинд өгдөг. Наана нь бол бодит хэрэгцээ нь бол 14, 15 мянган машин байдаг.

Тийм учраас мэдээжийн хэрэг өгч байгаа нь байгаа машинаасаа 2, 3 дахин цөөн болохоор мэдээж энэ дээр бол асуудал үүсэх нь тодорхой.

Тэгэхээр зэрэг бид нар энэ дээр бол аль болохоор энэ Си зөвшөөрлийг хүндрэл чирэгдэлгүй олгодог болгох чиглэлээр бас манай Түр хорооны гол анхаарч байгаа, бид нар энэ боомт дээр гарч байгаа хүндрэл бэрхшээлийг одоо бууруулах ийм одоо үүрэг хүлээж байгаа учраас энэ Си зөвшөөрлийн асуудал, энэ бөмбөлөг тээврийн асуудал бол харьцангуй одоо нэг үеэ бодох юм бол хүрдний тогтолцоонд орчихсон. Дундуур нь одоо янз бүрийн байдлаар бол өөр машинууд гарах боломжгүй, бас аятайхан боломжийн болсон.

Дээр нь одоо бас тэнд байсан олон машины жолооч нар кавинда хонодог, тэнд одоо бас архи дарс уудаг, ийм зүйлүүдийг бол цэгцэлчихсэн бас боломжийн зохион байгуулалт юм байна гэж ингэж үзэж байгаа юм.

Тэгээд энийг бол цаашидаа бас бид нар энэ Их Хуралд оруулах дүгнэлт дээрээ энэ Си зөвшөөрөлтэй холбоотой асуудал болон энэ бөмбөлөг тээвэрлэлттэй холбоотой асуудлыг бол бид нар тодорхой оруулж өгнө өө гэж ингэж бодож байна.

Мэдээж гэрээний асуудал бол би түрүүн хэлсэн Бат-Эрдэнэ гишүүн ээ.

Энэ гэрээн дээр бол олон одоо зүйлүүд байгаа. Хятадын талтай хийсэн гэрээ, Монголын дотоодын компаниудтай хийсэн гэрээнүүд байгаа. Тэрнээс гадна одоо таны хэлж байгаа энэ гэрээнүүд улс төрчид орж 100 мянган тонны 200 мянган тоннын гэрээ хийдэг гэсэн ийм одоо хардлагууд бол нийгэмд дүүрэн байна. Тэгэхдээ мэдээжийн хэрэг энэ одоо тухайн үед энэ Таван толгой компанийн удирдлагаар ажиллаж байсан хүмүүс энийг тогтоохгүй бол яг үнэндээ бол тийм хүмүүсийн нэр байгаа боловч

гэрээн дээрээ бол мэдээж энэ улс төрчдийн нэр байхгүй. Ямар нэгэн аж ахуйн нэгжийн нэр явдаг. Тэгэхээр зэрэг энийг бол мэдээж шууд цаана нь тогтоож, тэр гүйлгээ, мөнгө санхүүгээр нь тогтоож шууд ил гаргах ёстой хүмүүс нь бол энэ хуулийн байгууллагынхан. Тийм учраас энэ байгууллагынхан бол энийг тогтоож гаргах ёстой байх гэж ингэж бодож байна.

Г.Занданшатар:

Дашдэмбэрэлийн Бат-Эрдэнэ гишүүн.

Д.Бат-Эрдэнэ: Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье ээ.

Тэгээд энэ Түр хорооны хугацааг сунгахыг бол дэмжиж байгаа. Түр хорооны гишүүдэд, даргад бол энэ ажил нэлээд хүнд байгаа. Нэлээд эр зориг шаардсан ажлууд байгаа гэдгийг бас ойлгож байгаа. Улс төрийн бөгөөд эр зориг гарах хэрэгтэй. Өнөөдөр ард түмэн бол эдийн засаг доройтоод, амьдрал нь яалт ч үгүй болоод л жагсаж байгаа гэдгийг цөмөөрөө мэдэж байгаа. Гэтэл нөгөө 1072 гээд хувьцаатай энэ хувьцааны ноогдол ашиг нь хаа байна гэдэг дээр энэ асуултыг бол нийт одоо эрх баригчдад Их Хуралдаа тавьж байна шүү дээ. Энэ жагсагчдын зөв.

1072 хувьцаа ногдол ашиг хаана байна вэ? Ноогдол ашгийг нь өгөхгүй байгаа энэ компанийнхан эдийн засгийнх нь бүх одоо нөхцөл байдал, тэр гэрээ хэлцлийг нь мэдье гэдэг эрх яагаад нийт хувьцаа эзэмшигчид байхгүй байгаа юм? Тийм учраас энэ яаралтайгаар энэ оффтэйк гэрээгээ нээлттэй болгох хэрэгтэй. Энэ бол Түр хорооны гол ажил. Эндээс цаашидаа олон одоо бүх ажлууд нээлттэй болно.

Экспортоо нэмэгдүүлэх өнөөдөр эдийн засагт гол ажил бол экспортоо нэмэгдүүлэх байгаа. Тэгэхээр энэ экспортоо нэмэгдүүлэх ажлаа битгий гацаагаарай гэж бас хэлж байна. Эрдэнэс Таван толгой, Таван толгой ХК гэдэг бол 2 өөр компани байдгийг та бүхэн цөмөөрөө мэдэж байгааб

Тэгэхээр манай эрх баригчид заримдаа ямар нэгэн юм шүүхээр батлагдаагүй байхад хэний ч нэрийг хэлж болохгүй гэсэн мөртөө сөрөг хүчнийхээ Адьясүрэн гишүүн бид хоёрын нэрийг одоо хаа хамаагүй хэлж байгаа нь одоо энэ цөөнхөө дээрэлхээд байгаа юм уу, эсвэл өөрсдөө одоо хуулиа зөрчөөд байгаа юм уу гэдгээ бас хувь хүнийхээ хувьд сайн бодоцгоогоорой гэж хэлье.

Эрдэнэс Таван толгой ХК-ийн оффтейк гэрээ энэ олон олон асуудлыг цаашидаа нээж байж нээлттэй ярилцаж байж бид нар эр зориг гаргаж байж энэ дээр цаашидаа энэ жагсагчдад хариулт өгнө өө. Оффтейк гэрээ нээхгүйгээр, энийг ярилцахгүйгээр жагсагчид хувьцаа эзэмшигчид тайвшрах эрх байхгүй, тайвшрахгүй. Мөн тэр Чалкогийн 100 машин гээд яваад байдаг, яагаад давуу эрхтэй байдаг юм. Энэ давуу эрхтэй эрх, эрх баригчдын машинуудыг яагаад ярьж хөөрдөггүй юм бэ? Энэ асуудлыг бодоорой. Таван толгой ХК одоо орон нутгийн Таван толгой ХК гэдэг бол Хөрөнгийн биржийн нээлттэй компани шүү дээ. Энд би тодорхой хувьцаа эзэмшдэг үнэн. Энэ компанид энэ жил нэгж хувьцаандаа 2500-3000 төгрөг тараах юм. Энэ жишгээр 1072 хувьцаандаа энийг нийт хувьцаа эзэмшигчиддээ ногдол ашиг тараах их боломж байгаа. Энийг хэдүүлээ нээлттэй ярих хэрэгтэй. Энэ ажлыг цөмөөрөө нэг шалгахаас гадна 3/2-тоо

яаж эдийн засгаа тэлэх вэ. Энэ экспортоо яаж нэмэгдүүлэх вэ тал дээр онцгой анхаараарай. Энэ бол Байнгын, Түр хорооны гол ажил байх ёстой юм шүү.

2004 оноос нүүрсний экспорт эхэлсэн юм, 2004 оноос хойш. Тэгэхээр энэ хугацааны бүх асуудлууд бол нарийн шалгагдсан, дахиж шалгах одоо боломжтой бол тэр бүгдийг нь шалгаж болно. Саяхан бас Эрдэнэс Таван толгой ХК-руу 40, 50 хүн бас шалгалтаар явж байгаа гэж байгаа. Би нийг сайшааж байгаа. Ямар нэгэн шалгалт хэрэгтэй. Энэ юмыг эрүүлжүүлж байдаг. Энэ дээр улс төрийн өнцөг бол ерөөсөө оруулж болохгүй. Өнөөдөр сүүлийн 2016-аас өнөөг хүртэл 6, 7 жил бол хамгийн их нүүрсний экспорт явагдсан. Энд байгаа юмнуудад л гол одоо энэ Түр хорооны ажилд чиглэгдэж байгаа байхаа л гэж бодож байгаа юм. Бусад ажил бол одоо ёстой бүх юмаа шалгуулчихсан шүү дээ. Тэгэхээр энэ асуудал дээр бас онцгой анхаарч, нийт иргэд маань энэ асуудал дээр бас анхаарах ёстой болов уу гэж бодож байна аа.

Тэгээд шалгалтынхан нэлээн одоо эр зориг гаргаж байж л явна даа. Та нарт амжилт хүсье дээ.

Г.Занданшатар: Үг хэлчихлээ. За Гочоогийн Ганболд гишүүн, Түр хорооны дарга.

Оффтейк гэрээ, Чалко машин.

Г.Ганболд: Бөмбөлөг тээвэртэй холбоотой бол Чалко компанийн 100 машин явж байгаа. Тэр бол үнэн байна лээ. Очергүй өдөр болгон гардаг. Энэ бол одоо бид нар Чалко компанид бид нар бол нөгөө нүүрснийхээ өрийг төлөөд дуусчихсан

гэж ойлгож байгаа. Тэгтэл Чалко компаниас ямар хүсэлт ирээд тэрийг нь хэн хүлээж аваад, хэний ямар шийдвэрийн дагуу явж байгаа вэ гэдэг энэ бүх мэдээллүүдийг өгөхийг бид нар энэ Боомтын зөвлөл, тэр ажлын хэсгүүдэд нь бол өгсөн байгаа. Тэрийг бол би тайландаа бол тодорхой гаргана. Ер нь бол тэнд 300 гаран бөмбөлөг үүсчхээд 10 гаран мянган машин очерлож очерлож зарим нь одоо сард 2, 3 гарч байхад зарим нь сард гарч чадахгүй байхад 100 гаруй машин өдөр болгон гарна гэдэг бол энэ асар том давуу эрх олгочхож байгаа юм. Энд бол мэдээж тэнд байгаа асар олон жолооч нар дургүйцэж байгаа. Тэгээд энийг бол бид нар бас тодорхой болгож Түр хорооны тайлан тавих үеэр бол би тодорхой мэдээллүүд өгнө өө. Бат-Эрдэнэ гишүүн ээ. Гэрээ бол би түрүүн хэлсэн. Оффтейк гэрээнүүдэд бол нэг орсон заалт бол 2 тал харилцан зөвшөөрч байж гэрээгээ ил болгоно гэсэн ийм заалтууд байгаа юм байна лээ.

Тэгэхдээ бид нар бол ямар ч гэсэн энэ Хятадын талын зарим нэг гэрээнүүд дээр Хятадын тал ямар хариу өгөх юм мэдэхгүй. Дотоодын боломжтой бүх гэрээнүүдийг бол нээлттэй сонсголоос өмнө ил болгож өгнө өө гэж Засгийн газрын зүгээс бол бид нарт хэлсэн байгаа.

Тэгэхээр таны хэлж байгаа үнэн. Ер нь бол ерөөсөө Түр хорооны хамгийн гол үр дүн бол энэ нууц гэрээнүүдийг ил болгож, энэ гэрээнүүдийн цаана үнийн дүн, тэгээд эзэд нь ямар компаниуд, ямар хэмжээний гэрээ хийсэн байна вэ гэдгийг л ард түмэнд ил болгож байж энэ иргэдийн одоо уур бухимдал тодорхой хэмжээнд буурна гэж ойлгож байгаа. Тэрэн дээр бол би тантай санал нэг байна.

Г.Занданшатар: Жамъяангийн Мөнхбат гишүүн.

Ж.Мөнхбат: Энэ Хянан шалгах түр хороог хугацааг нь сунгаж ажиллуулах асуудлыг дэмжиж байгаа. Тэгэхээр манай энэ Түр хороо нэг зүйлийг анхаармаар байгаа юм. Ялангуяа энэ иргэд нэг зүйлийг шаардаж байгаа. Жагсаж байгаа энэ үед 4, 5 зүйл дээр одоо гол фокуслаж ажиллах шаардлагатай байна. Гишүүд ч нэлээн ярьж байх шиг байна. Оффтейк гэрээг нууцаас гаргах асуудал байгаа. Хэдий хэмжээний, хэдэн одоо тэр яриад байгаа шиг их наядын тийм асуудал үүсэж үү, үгүй юу гэдгийг эндээс ингээд тодорхой болгоно. Төмөр замыг өртгөөр нь барьж уу, өртгөөр нь одоо дабльдаж барьж уу, 3 трибэлдэж одоо хийж үү гэдэг энэ тодорхой болно, гуравдугаарт.

Дөрөв дүгээр асуудал юу байгаа вэ гэхээр энэ уртын тээврийг богинын тээвэр болгож зуу гаруй юанаар тээвэрлэдэг байсан юм яагаад 27-хон километр 500 гаран юаниар тээвэрлэдэг болов. Тээврийн зардал тав дахин яагаад өсөв өө? Энэний цаана ямар асуудал явж байгаа юм бэ гэдгийг тодорхой болгох хэрэгтэй.

Си зөвшөөрөлтэй холбоотой энэ асуудлууд байж байгаа. Энэ асуудлыг тодорхой болгох хэрэгтэй. Энэ гэрээ байгуулахдаа одоо ямар зарчим барьж тухайн гэрээ байгуулж байгаа компани зүгээр ингээд тохиролцооны байдлаар гэрээ байгуулж явсан юм уу, эсвэл одоо дуудлага худалдааны зарчмаар гэрээ байгуулсан юм уу гэдэг ийм ийм зүйлүүдийг ингээд тодорхой болгоод ирэх юм бол наад яриад байгаа нүүрсний гэж яриад байгаа асуудлууд

бол тодорхой болчихно оо. Жишээлбэл одоо мань мэт шиг ингээд гүтгүүлж явж байгаа янз бүрийн хэвлэлээр ингээд бичүүлж явж байгаа хүний хувьд бол би бас нэг хэдэн зүйлийг хэлчихмээр байгаа юм.

2017 онд одоо ЗГХЭГ-ын сайдаар ажиллаж байхдаа би нэг зүйлийг шийдэж байсан байдаг юм. Тэр нь юу вэ гэхээр одоо энэ мөргөцөг гэж яриад байгаа зүйлийг анх удаагаа одоо тогтоож акт үйлдэж байсан юм. 2017 оны 2 сарын 13-ны өдөр Эрдэнэс Таван толгой компани, орон нутгийн Таван толгой компани хамтраад акт үйлдээд энэ дээр юу вэ гэхээр 204.8 тонн исэлдсэн нүүрс, 63.5 мянган коксжсон нүүрсийг Эрдэнэс Таван толгой компанийн газраас, талбайгаас олборлосон нь үнэн байна гээд одоо орон нутгийн Таван толгой акт үйлдээд гарын үсэг зурж байсан ийм асуудал байгаа. Ингэж шийдэж байсан юм. Тэгээд энэний дараа энэ асуудлыг 2018 онд манай Энхболд гишүүн ярьж эхэлсэн байдаг байхгүй юу. Энэ асуудлыг шийдсэний дараа.

Дараагийн нэг асуудал энэ өнөөдрийн ярьж байгаа энэ биржийн асуудлыг тухайн үед нүүрс худалдан авах одоо хүсэлтэй бүх компаниуд дугтуйнд хамгийн өндөр үнээ өгөөд, хамгийн өндөр үнэ өгснийг нь олны өмнө одоо нүүрс худалдан авах компаниудын өмнө нээлттэй зарлаж байгаад хамгийн өндөр үнэ нь өгсөн компанид нь л одоо тэр гэрээ байгуулах эрхийг нь олгосон ийм зарчмаар тухайн үед явж байсан. Одоо болохоор сонсохноо 5, 6 янзын үнэ байх шиг байгаа юм. Чалкогийн үнэ, Бодийн үнэ, оффтейк гээний үнэ, амны үнэ, одоо хилийн үнэ ч гэдэг юм уу. Тэгээд энэ олон үнэ юм уу? Энэ олон зүйл ингээд гараад ирэхээр хаана нь хэн нь хэдэн төгрөгийн гэрээ

байгуулаад явж байгаа нь тодорхойгүй болно гэдэг чинь ойлгомжтой шүү дээ. Ийм ийм зүйлүүдийг бүгдээрээ ингээд тодорхой болоод энэ ард түмний ярьж байгаа энэ хүсэн хүлээлтэд нь шаардаж байгаа зүйлд нь хурдан шуурхай хариу өгөөд явчих боломж бол бүрэн байгаа гэж бодож байгаа. Маш ойлгомжтой. Наадах чинь ерөөсөө энэ иргэдийн шаардаад байгаа зүйлийг түрүүний ярьдаг энэ 5, 6 зүйл дээр одоо юу юу болсон юм бэ гэдэг энэ процессыг нь нээлттэй гаргаад ингээд тайлбарлаад ярихад бол энэ одоо тэр Доржханд гишүүний яриад байгаа тэр 40 их наяд нь үнэн юм уу? Худлаа юм уу гэдэг юм ингээд л тодорхой гараад ирнэ шүү дээ.

Тэгээд ийм одоо тодорхой зүйлийг бол ингээд маш хурдан хугацаанд, тэр ялангуяа одоо энэ гэрээний нууцлалуудыг ил болгох асуудлууд ямар ямар гэрээнүүд хийгдэж байсан юм, ямар ямар ханиаар хийгдэж байсан юм, ямар ямар компани авч байсан юм, тээвэрлэлттэй холбоотой тэр асуудлууд дээр ямар ямар одоо компаниуд орж байгаа юм?

Яагаад одоо зуун хэдэн юанийн тээвэрлэдэг, одоо 220, 230 километр.../минут дуусав/.

Г.Занданшатар: Жамъянгийн Мөнхбат гишүүн үг хэллээ. Одоо Балжиннямын Баярсайхан гишүүн.

Б.Баярсайхан: Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгахыг бол дэмжиж байна. Гэхдээ хугацаа сунгаад ажиллахдаа хурдтай, зоригтой, тодорхой, ард иргэдэд тодорхой мэдээлэл өгсөн, энэ Их Хурлын гишүүдэд ийм хурдтай ажиллаасай гэж хүсэж байна.

Өнөөдөр Монголын ард иргэд бол ерөөсөө хариуцлага тооцдог төртэй байхыг харахыг л хүсээд байна шүү дээ. Шударга ёс, хариуцлага гэдэг энэ үгний одоо үнэ цэн нь ч гэсэн ер нь бол алдагдаж байна. Сүүлийн 30 жил энэ Улсын Их Хурал, Засгийн газар, улс төрчдөд итгэх иргэдийн итгэл суларсан, нэр хүнд нь муудсан гэдгийг харж байгаа. Сая Бат-Эрдэнэ гишүүн үг хэллээ. Сөрөг хүчнийхээ хүмүүсийг нэр одоо цохоод цоллож байна гээд. Гэтэл сөрөг хүчнээс маань энэ Улсын Их Хурлын хурал, Засгийн газарт 30, 40 энэ нүүрсний хулгайчид байгаа гээд ингээд байх юм. Тэгээд Цогтгэрэл гишүүн ээ, Одонтуяа гишүүн ээ, энэ хүмүүсийнхээ нэрийг мэдэж байгаа юм бол яг нэрлээд өгөөч ээ. Улсын Их Хуралд нэр цэвэр, гар цэвэр гишүүд байгаа шүү. Битгий ингэж төрийн нэр хүндийг, Улсын Их Хурлын нэр хүндийг битгий их ингэж унагаагаад байгаач ээ. Битгий сөрөг хүчин гэж ийм тоглолт хийгээд байгаач ээ гэдгийг би одоо хариуцлагатайгаар бүр шаардаж байна.

Үнэхээр нэрийг нь мэдээд байгаа юм бол 30, 40 хүнийхээ 3, 4 хүнээс нь авхуулаад нэрийг нь зарламаар байна шүү дээ. Нэг мөсөн зарла. Харин тийм зарламаар байна. Энэ дунд ингэж хэлмэгдүүлмээргүй байна. Өөрөө хэлмэгдмээргүй байна. Пүрэвдорж гишүүн ээ, та жсоохон соёлтой байгаарай. Өнөөдөр нүүрсний хулгайн дээр ард түмний одоо тэвчээр барагдаад явж байгаа болохоос биш ганц нүүрсний биш энэ олон олон салбарт хулгай нүүрлээд, олон олон газар төрийн албаны нэр хүнд унаад, ингээд одоо итгэл найдвар тасарчихсан хүмүүсийн жагсаал, хашираан гэж ингэж харж байгаа. Би 2 жил Улсын Их Хурлын гишүүний хувьд бүхэл бүтэн нэг аймгийг тоноод явчихсан хулгайчдад хариуцлага

тооцоод өгөөч ээ гэдэг асуудлыг зөндөө ярьж байгаа. Тэр битгий хэл энэ хүүхдийн мөнгөнд нэг арай чүү батлуулаад тавьчихсан 8 тэрбум төгрөг нь хүртэл хумсаа шигтгээд сууж байгаа ийм хулгайч нар нүүрлэчихсэн л байгаа шүү дээ. Энэ хүмүүстэйгээ хариуцлага бүх шатанд нь тооцоод өгөөч ээ гэж ингэж одоо хэлж дуугарч байгаа хүний нэг шүү.

Тэгэхлээр би одоо ажлын хэсгээс 2 зүйлийг асуумаар байна, энэ оффтейк гэрээг нууцаас гаргах ажил яг хэзээ хэрэгжих боломжтой юм бэ? Эцсийн хугацаа нь яг хэзээ байдаг юм бэ?

Хоёрдугаарт нь энэ 40 их наяд гэж хэлээд байгаа энэ Доржханд гишүүний яриад байгаа энэ тоо яг эцсийн тоо мөн юм уу эсэн энэ 2 асуултад хариулт авъя.

Г.Занданшатар: Гочоогийн Ганболд гишүүн, Түр хорооны дарга хариулъя.

Г.Ганболд: Шуурхай ажиллах тухайд тантай санал нэг байна. Ер нь бол зүгээр бид нар хянан шалгагч нар, шинжээч нар нь ажиллаад бас нэлээн цаг хугацаа орж байгаа юм. Яагаад гэхээр би хэлсэн. Бид нар дангаараа манайх өөрийн мэдээлэл дээр тулгуурлаад энэ хэргүүд дээр яг нотлох баримт цуглуулахад бол төвөгтэй байгаа учраас гаднын одоо Хятадын талаас ч юм уу мэдээлэл авах ийм цаг хугацаа орж байгаа учраас хугацаа сунгаж байгаа юм гэдгийг би танд хэлэх гээд байна.

Хоёрт нь бол би та өөрөө мэдэж байгаа л даа. Оффтейк гэрээнүүдийг бол Их Хурлаас бол тогтоол гарчихсан. Гэхдээ би сая бүлгийн хурал дээр би санал хэлсэн,

мэдэж байгаа. Тэгээд ямар ч гэсэн энэ 21-ний энэ сонсголоос өмнө Засгийн газрын зүгээс энэ оффтейк гэрээнүүдийг ил болгох тал дээр анхаарал хандуулж ил болгож өгнө өө гэдгээ хэлсэн шүү дээ, тийм ээ. Тэгэхээр тэрийг та бол мэдэж байгаа учраас энэ гэрээнүүд ил болох дээр зэрэг бид нар бол бүх зүйл тодорхой болно оо гэж би сая бүх гишүүд л асуулаа л даа би бүгдэд нь л яг энэ байдлаар хариулж байна. Тэгээд энийг бол би ойрын үед одоо ямар ч гэсэн энэ Засгийн газрын зүгээс 21-ний сонсголоос өмнө гарна гэж итгэж байгаа.

Г.Занданшатар: Ажлын хэсэг гэж зарлагдаагүй Түр хорооны дарга л хариулж байгаа.

Дэгээрээ тийм эрх байхгүй л дээ, нэг л хариулт явна. Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудлыг дэмжиж байна.

Би 3, 4 зүйлийг хэлье ээ гэж бодож байгаа юм. Өнөөдөр талбай дээр жагсаж байгаа хүмүүс бол нэг л том шаардлага тавьж байгаа шүү дээ, бидэнд. Төр засагт хариуцлага тооц гэдэг ийм л. Хариуцлагыг хэн тооцдог юм бэ гэж хариуцлагыг шат шатандаа тооцох ёстой. Тооцдог албан тушаалтан байна. Үндсэндээ энэ хариуцлага тооцох хамгийн том систем нь бол Засгийн газар. Тийм учраас Засгийн газрыг би хариуцлага тооцож эхэлж байна гэж бодож байна. Энэ дээр бол Засгийн газар, хууль хяналтын байгууллага бүгдээрээ хариуцлага тооцох ёстой. Улсын Их Хурал хариуцлага тооцохыг байнга дэмжиж байгаа. Тооц гэж шахаж байгаа. Тийм ч учраас Улсын Их Хурал

б сарын өмнө энэ нүүрстэй холбоотой асуудал болохгүй байна. Энийг судалж үзье ээ. Энэ дээр ажиллая шаардлагатай бол хянаж шалгая гээд Түр хороо байгуулсан. Би Түр хороо сайн ажиллаж байгаа гэж бодож байгаа. Харамсалтай нь Түр хороонд ажиллах зарим нэгэн боломж олгохгүй байгаа. Боломж олгохгүй байгаа. Тэрнээс болж цаг хугацаа жаахан алдсан юм байгааг үгүйсгэхгүй. Хамгийн түрүүнд оффтейк гэрээтэй холбоотой асуудал. Энийг бол бид нар Улсын Их Хурал 11 сарын 15-нд Төсвийн тухай хуулийг хэлэлцэж, батлахдаа гаргасан, дагасан тогтоол дээр байгаа. Засгийн газрыг, оффтейк гэрээнүүдийг яаралтай ил арга хэмжээ ав гээд чиглэл өгчихсөн байгаа.

Тийм учраас бол би Улсын Их Хурлаас тодорхой арга хэмжээнүүд авч хэрэгжүүлж байгаа. Цаашидаа ч гэсэн нүүрсний хулгайтай тэмцэх чиглэлээр тодорхой томоохон арга хэмжээ авах шаардлагатай гэж ингэж бодож байгаа.

Хоёрдугаарт, хариуцлага тооцохтой холбоотой асуудлыг бид нараас хэвлэлийнхэн байнга асууж байгаа юм. Энэ Монгол Улс чинь хилтэй, гаальтай, тэрийг хянадаг, шалгадаг ийм газар байж байгаа шүү дээ. Хил, гаалийн байгууллагууд бүгд байж байна. Үнэхээр тэр нүүрс хулгайгаар гараад байгаа бол тэр чинь хянаж байдаг, хяналт тавих үүрэгтэй тийм байгууллагууд нь бүгд байж байна шүү дээ.

Тийм учраас шатандаа хариуцлага тооцох асуудал үнэхээр чухал байгаа юм Их хурлаас шаардаад байгаа юм. Та нар нэр зарла гээд байгаа юм. Бид нар Их Хурал нэр зарладаг байгууллага биш. Тэр нэрийг чинь зарладаг холбогдсон хүмүүсийг нь

тогтоодог, тогтоолгохоор холбогдох байгууллагад нь шийдвэрлүүлдэг энэ байгууллага тэртэй тэргүй байж байгаа. Эд нар ажлаа хийх хэрэгтэй байгаа шүү. Тийм учраас шат шатандаа хариуцлага тооцож, ингэж ажиллаж байж л бид нар энэний ард гарна. Энэ чиглэлээр, харин Улсын Их Хурал, цаашидаа Түр хороо маш хурдтай, хариуцлагатай ажиллаж, энэ нүүрсний хулгай болон энэ жагсагчдын тавьж байгаа шаардлага бол нүүрсний хулгай гэдэг нэг том асуудал мөн. Гэхдээ энэний цаана бас би ажлын хариуцлагын асуудлууд байна. Юмны үнийн өсөлт инфляцид нөлөөлж байгаа юм байна. Олон асуудлууд бий.

Олон асуудал хуримтлагдаж байж явж байгаа асуудал. Тийм учраас ганцхан нүүрс гэдэг юмыг хараад бүхнийг хаачхаж болохгүй. Юмныхаа үнийн өсөлтийг яаж одоо тогтвортой хүрээнд барих вэ, инфляцыг яаж тодорхой хүрээнд барих вэ? Иргэдийнхээ амьжиргааны түвшинд дордуулчихгүй байхын тулд юу хийх вэ. Энэ өчнөөн олон том асуудлууд байна аа. Тийм учраас их олон зүйл дээр олон талаас нь харж ажиллах шаардлага байна гэдгийг хэлье гэж бодож байна.

Баярлалаа.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч үг хэлж дууслаа.

Байнгын хорооны саналаар хянан шалгах дүрвэн хорооны ажиллах хугацааг сунгах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалттай.

Санал хураалт. Горимын санал өглөө хэлэгдээд дууссан. Та үгээ хэлсэн. Та өглөө горимын санал хэлчихсэн. Одоо санал хураалт.

Баталъя гэсэн томъёоллоор. Туришилтын санал хураалт эхлээд явуулж байна. Одоо л асуулт үг түрүүнээс хойш яваад гишүүд нэмэгдэж хэлээд дууссан шүү. Зүгээр энэ туришилтын санал хураалт гэсэн. Одоо Байнгын хорооны саналаар Хяналт шалгалтын түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалт. 36 гишүүн дэмжиж, 59 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Улсын Их Хурал сая Тогтохсүрэн дарга тодорхой хэллээ. Улсын Их Хурал бол хууль тогтоох дээд байгууллага. Баталсан хуулийнхаа хэрэгжилтийг хянан шалгах эрх мэдлийг хэрэгжүүлнэ. Хуулийн хэрэгжилтийг биелүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх үүрэг бол гүйцэтгэх засаглал, хууль сахиулах байгууллагуудын үндсэн үүрэг. Ийм учраас одоо бид нар энэ хуулийн хэрэгжилтийг яаж хангаж байгаа юм, гэмт хэрэг хулгайтай яаж тэмцэж байгаа юм, энэ талаар л хяналт шалгалтын энэ үйл ажиллагаагаа үргэлжлүүлж гэж шийдэж байгаа, тийм ээ. Энд нь одоо тэр оффтейкийн гэрээ энэ тэрийг одоо ил болгох асуудлыг төсвийн хууль батлахдаа 11 сарын 15-нд өгсөн Улсын Их Хурлын тогтоолоор үүрэг чиглэл өгсөн. Одоо нээлттэй сонсгол дээр тэр үнэлгээ тогтоосон, нотлох баримт цуглуулсан бүх юмаа энэ талаар ярьж байгаа үг, хэлж байгаа гишүүд гаргаж өгөх үүрэгтэй. Гэрчээр оролцох хэрэгтэй.

Одоо ард түмний энэ хүсэл эрмэлзлэл, шаардлагыг биелүүлэх нь Улсын Их Хурал ард түмний элч төлөөлөгчийн үндсэн үүрэг шүү.

Тийм учраас одоо нүүрсний хулгай, аливаа хулгайтай хатуу тэмцэх талаар бүх талын дэмжлэг үзүүлж аж ажиллах шаардлагатай.

Тогтоолын төслийг уншиж танилцуулъя. Яагаад Энэ Хяналт шалгалтын Түр хороо ажиллах хугацаа сунгах асуудлыг эсэргүүцээд байна. Ямар санаа зорилготой байгаа улсууд тэрнийгээ хэлэх хэрэгтэй.

Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.8 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь.

Нэг хилийн боомтуудаар ачаа тээвэр, нүүрс тээвэрлэх болон чөлөөт бүсийн үйл ажиллагаанд учирч буй хүндрэлийг шалгахаар Монгол Улсын Их Хурлын 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 31 дүгээр тогтоолоор байгуулсан Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг 2022 оны 12 дугаар сарын 11-ний өдрөөс 6 сараар сунгасугай.

Энэ тогтоолыг 2022 оны 12 дугаар сарын 8-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй. Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Дараагийн асуудалд оръё. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг танилцуулна. Индэрт урж байна.

Х.Ганхуяг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг Улсын Их Хурлын 2022 оны 12 дугаар сарын 1, 2-ны өдрүүдийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Тус Байнгын хороо 2022 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай асуудлыг хэлэлцээд чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж, олонхын дэмжлэг авсан тул саналыг хуулийн төсөлд нэмж тусган, төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, хууль зүйн техникийн шинжтэй засваруудыг хийсэн төслийн эцсийн хувилбарыг Та бүхэнд хүргүүлсэн болно оо.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Газрын тосны бүтээгдэхүүн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж,

хуулийн төслийг баталж өгөхийг та бүхэн хүсэж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийг танилцуулъя.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд Батнайрамдал, ИНЕГ-ын дарга Содномцэрэнгийн Мөнхнасан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Болдбаатарын Анхбаяр, МИАТ компанийн захирал Батбаярын Мөнхтамир, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга Чулууны Хишигдалай, АМТГ-ын Газрын тосны бүтээгдэхүүний хэлтсийн дарга Даваахүүгийн Даваабаяр, ИНЕГ-ын Агаарын тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга Гүррагчаагийн Батбаяр, МИАТ ТӨК-ийн Санхүүгийн удирдлагын газрын захирал Нарангэрэлийн цэц, Эрчис ойл ТӨХК-ийн захирал Заншарын Ширзана, Эрчис ойл ТӨК-ийн менежер Хүүхээгийн Эрдэнэбилэг.

Г.Занданшатар: Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу?

Сайнхүүгийн Ганбаатар гишүүнээр тасаллаа.

Тогмидын Доржханд гишүүн асуулт асууна.

Т.Доржханд: Баярлалаа. Энэ газрын тосны бүтээгдэхүүнтэй холбоотой хуулийн төслийг хэлэлцээд явахыг юм бол дэмжиж байгаа юм. Энэ газрын тос тэгээд нүүрс, зэс, алт гээд байдаг шүү дээ Маш олон

асуудлуудын энэ нэг орж ирдэггүй орлого тэгээд хилийн цаана үлддэг энэ байдал бол түгээмэл болчихоод байна. Тэгээд үүнтэй холбоотойгоор нийгэмд бол шүгэл үлээж байгаа нь үнэн. Засгийн газар бас мэдэгдлээ хийсэн нь бас үнэн. Тэгээд өнөөдөр ингээд анзаарч байхад нэг зүйлийг бас хэлэхгүй бол болохгүй нь ээ, эрхэм нөхөд өө.

Өчигдрөөс хойш, тухайлбал Хууль зүйн сайд Нямбаатараас авхуулаад өнөөдөр манай эрх барьж байгаа намынхан бол энэ 40 их наяд гэж юу яриад байгаа юм бэ? Ийм юм хаана байдаг юм бэ? Бараг уучлалт гуй ч гэж байх шиг. Тэгээд энийг нь бүр дэмжээд манай АН-ын гишүүн Пүрэвдорж гэдэг хүн бол тийм юм байхгүй, бараг 9000 хүнтэйгээ жагсана ч гэж байх шиг. Үгүй ээ, тэгээд энэ Ардын намын захиалгаар хэн нь ингээд одоо эсрэг юм яриад байдаг юм бэ? Үгүй ээ энэ одоо иргэд харж байгаа шүү дээ, боль л доо. АН ингээд Хүн ам бид нарын орон зайг гэж хэлэх гээд байна гэдгээ больчих хэрэгтэй. Одоо бүгдээрээ сөрөг хүчний юм бол сөрөг хүчин шиг бай л даа. Би АН-ын бүлэг рүү нэг ч үг хэлж үзээгүй шүү өнөөдрийг хүртэл. Өнөөдрийг хүртэл энэ нэг хулгай дээр эм болохгүй байна гэж ярьсан нь үнэн шүү, нэг.

Хоёрдугаарт Ардын намын гишүүддээ бас хэлчмээр байна. Тэр Ганболд дарга эд нар одоо бас бодитой байх хэрэгтэй шүү. Тоогоо өгөхдөө 6.4 сая ийм байна гэдгийг хэлээд тохироод ярьсан. Одоо болсон чинь 2.3 болчихсон явж байна. Одоо болохлоор би мэдэхгүй ээ гээд. Одоо боль л доо та нар. 40 их наяд төгрөг чинь хэд юм бэ? Одоо ингээд тоо бодъё л доо. Хэн энэ асуудлыг гаргаж ирсэн юм бэ гэдгийг ярьчихъя. Хэн юм бэ? Хэзээ юм бэ? Монгол Улсын эдийн засагтай тэмцэх

хэмжээний мөнгийг бид нар алдчихаад байна гэдгийг Монгол Улсын Ерөнхий сайд, танай намын дарга анх хэлсэн шүү. Монгол Улсын эдийн засаг хэд юм, дотоодын нийт бүтээгдэхүүн хэд юм. 40-45 их наяд шүү, нэг.

Би бол энэ дээр яг тооцоолол нь юу юм бэ гэж гаргаж ирсэн, үнэн. Яг өнөөдрийн байдлаар 40-45 их наяд төгрөг орж ирэх ёстой. Орлогоо бид нар алдчихаад байгаа. Түүнд ногдох 10 орчим их наяд төгрөгийн татварын орлогоо бид нар алдчихаад байгаа нь бодитой. Би энийг бол нотолж чадна. Манай экспертүүд сууж байгаа. Энэ бол ямар нэгэн зүйлийг гуйсан юм байхгүй. Тэгэхдээ Засгийн газар дээр бас тооцоо нь бол байх ёстой байх. Тэгээд би энэ талаар бол иргэдэд болоод энэ залуучуудад дээрээс нь энэ хэвлэл мэдээллийн байгууллагуудад тооцооллоо хангалттай хийгээд өгчихнө битгий санаа зов. Энэ миний хийдэг ажил. Харин гэв гэнэт л одоо ингээд л бүгдээрээ Доржханд гэдэг хүн бол одоо ингээд иргэдийг ингээд бухимдуулж байна. Худлаа мэдээлэл тараалаа. Уучлаарай тийм юм байхгүй шүү, бодитой мэдээлэл шүү.

40 их наядын ийм орлогоо бид нар 10 жилийн хугацаанд алдчихсан. 1 жилдээ бид нар нэг 1 их наяд төгрөгийн орлогыг нүүрснээс авдаг юм. 10 жилийн хугацаанд бид нар нүүрснээс татвараар бид нар 10 их наядынхаа орлогыг алдчихсан. Өөрөөр хэлэх юм бол 2 их наядынхаа нэг их наядыг нь бид нар төсөвтөө аваад байдаг.

Нэг их ноёд нь хилэн гадаа үлдээд байгаа энэ бодитой мэдээлэл юм. Энэ асуудал ингэж сөхөгдөж байж өнөөдөр оффтейк гэрээний асуудал явж байгаа шүү. Хамгийн гол юм бол оффтейк гэрээн дээр чинь

байгаа. Хулгайчуудаа бүгдээрээ хайгаад байна. Эрх баригчдаа боль оо энэ сөрөг хүчний 2 хүнийг л зарлаад байх юм. Муухай харагдаж байна. Энэ Бат-Эрдэнэ гишүүн, Адьясүрэн 2-ыг та нар яриад байна. Муухай гаргаж байна боль оо намайг ярь л даа, ярь ярь, ярьж болно. Харин АН-ынхан та нараас муухай харагдаж байна шүү Пүрэвдорж гишүүн ээ. Эрх барьж байгаа намынхны дууг бас дуулж болохгүй шүү хамтдаа байх хэрэгтэй шүү.

Тэгээд хоёрдугаарт юу вэ гэхлээр оффтейк гэрээний үр дүнд маш олон хүмүүсийн асуудал ил болно шүү. Энийгээ л бүгдээрээ сайн мэдэж байгаа. Энэ дээр.

Г.Занданшатар: Залуучууд, ард түмэн энэ нэрээ зарлахыг шаардаад байна шүү дээ. Одоо мөнгөн дүнг нь хэлчихсэн юм бол тэр 40 их наядыг хулгайлсан хүмүүсийнхээ нэрийг зарлах хэрэгтэй, нэрээ зарла, нотлох баримтаа гаргаж өг тэр хууль хяналтын байгууллагуудад хулгайлсан хүмүүсийг. Цаана нь эзэн нь байх ёстой шүү дээ. Эзэн холбогдог ч үгүй хэрэг гэж нүүрс чинь өөрөө алга болчихсон юм уу? Тэр 40 их наяд.

Содномын Чинзориг гишүүн.

С.Чинзориг: Би хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад 2, 3 зүйл тодруулъя. Яах вэ, нүүрсний хулгайтай холбоотой асуудал Их Хурал ч анхаарч байгаа, Засгийн газар ч анхаарч байгаа. Энэ хууль хяналтын байгууллагад ажиллаж байгаа. Тэгээд эзэн холбогдогч нь гараад тэгээд шийдэгдэнэ биз дээ.

Гэхдээ манай энэ хүн намынхан, Ардчилсан намынхан бас энэ асуудлаар улс төрийн ашиг хонжоо бүү

хайгаасай л гэж би бол бодож байгаа гэдгээ бас хэлье ч гэж бодож байна.

Тэгээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан 2, 3 зүйл бас байна. Нэг дэх асуудал нь энэ улсын хэмжээгээр дизель түлшний хүрэлцээ, хомсдол бий боллоо гэж нэг хэсэг асуудал үүссэн юм. Одоо тэгээд энд дизель түлшний чинь хүрэлцээ хангамж сайжирч байгаа юу? Ганбаатар сайд ярихдаа ОХУ-аас оруулж ирж байгаа Хятад улсаас бас дизелийн түли оруулж ирж байгаа хангамж, хүрэлцээ асуудал байхгүй болно гээд байсан. Энэнтэй холбоотой ямар арга хэмжээ аваад хангамж, ямар түвшинд хүрээд хэд хоногийн одоо нөөцтэй болоод байна гэдэг тодорхой мэдээлэл өгөөч?

Хоёрдугаарт, Их Хурлаас авсан арга хэмжээний үр дүнд Засгийн газар ч бас ажиллаж байна. 92 Түлшний үнэ дээр бас тодорхой хэмжээний зохицуулалт хийгдээд үнэ нь бас тогтвортой байх арга хэмжээ авч байгаа юм энэ бол сайн хэрэг. Гэхдээ энэ дизель түлшний үнэн дээр хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ үнэн дээр нь бас урт хугацаанд тогтвортой байлгах талаар Засгийн газар, холбогдох яамд ямар арга хэмжээ авах гэж байгаа юм бэ? Бид бол үндсэндээ дизель түлшний үнэ бол хяналтгүй л яваад байна л даа, өсөөд байна. Дизель түлшний хэрэглээ хаа байдаг вэ гэхээр гол нь хөдөөгийн иргэдэд, ялангуяа малчдад, газар тариалан эрхлэгчдэд энэ дизель түлшний хэрэгцээ чинь асар өндөр байдаг шүү дээ. Энэ жил цаг хатуу байна. Олон аймагт өвөлжилт хүндрэлтэй өвөлжиж байна. Олон аймгийн малчид гаднын суманд аймагт отор хийж өвөлжиж байна. Дизель түлшний хүрэлцээ хомс байна.

Үнийн өсөлт өндөр байна гэдэг асуудал маш их одоо гарч байгаа.

Тэгэхээр энд дизель түлшний хангамжийг нэмэгдүүлэх, дээр нь энэ дизель түлшний үнийг бас тогтвортой хугацаанд, урт хугацаанд тогтвортой байлгах талаар ямар одоо арга хэмжээ авах вэ гэдгийг нэг тодруулж хэлээч.

Гурав дахь асуудал нь бидний энэ хэлэлцэж байгаа хууль гарснаар тодорхой хэмжээгээр энэ онгоцны түлшний үнэ чинь ямар хугацаанд тогтвортой үнийн өсөлт байхгүй байна гэж та нар тооцож байгаа юм. Урьдчилж тэр хамтарч компани байгуулах гэж байгаа ОХУ-ын холбогдох газруудтай ярьж байгаа юм уу? Ямар хугацаагаар гэрээ байгуулах юм? Ямар хугацаанд энэ онгоцны түлшний үнэ нэмэгдэхгүй байх юм? Энэ нь нөгөө талаараа онгоцны энэ билетийн үнэ тийзний үнэд тогтвортой байх, цаашилаад энэ тийзний үнэ буух ямар одоо нөхцөл боломжийг олгох юм бэ гэдэг дээр та бүхэн тодорхой тайлбар хариу өгөөч ээ гэдэг ийм 3 зүйлийг асууж байна?

Г.Занданшатар: Одоо хэн хариулах уу? 85 Отгоншаравын Батнайрамдал дэд сайд хариулъя.

О.Батнайрамдал: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе.

Чинзориг гишүүний асуултад хариулъя аа.

Тэгэхээр дизелийн түлшний хомсдолтой холбоотойгоор ОХУ-д 10 сард ЭХЯ-наас бол ажлын хэсэг гарч хуралдаад ер нь экспортоо цаашидаа илүү хязгаарлах, ялангуяа дундын зуучлагч тендерүүд дээр дамжуулах, экспортыг бол хязгаарлах арга хэмжээ

авахаар ажлын хэсгийн дүгнэлт гарсан байгаа. Тэгээд үүнтэй холбоотойгоор Монгол Улсын дизель түлшний нийт хэрэгцээний бараг 65-70 хувийг бол Роснефт, бусад үлдсэн хувийг бол трейдүүдээс хангадаг байгаа. Тэгэхээр трейдүүдээс орж ирэх нийлүүлэлт дээр доголдол гарсантай холбоотой. Тэгэхээр бид УУХЯ-наас бол авсан арга хэмжээ бол Роснефт компаниас одоо гэрээнийхээ хүрээнд нийлүүлэлтээ ихэсгэх, мөн одоо БНХАУ-аас нэмэлт дизель түлш авахаар захиалгаа өгч баталгаажуулсан. Яг өнөөдрийн байдлаар бол ОХУ-д бол замдаа 16800 тонн буюу 280 вагон дизель түлш ирж байна. Мөн БНХАУ-аас бид нар 21040 тонны захиалгыг бол баталгаажуулж авснаас 9350 тонн дизель түлш бол Монгол улсад орж ирчихсэн байгаа юм. Тэгэхээр ОХУ талаасаа, мөн БНХАУ-аас ингээд дизелиуд ороод ирэхээр бол нөөцийн хэмжээ бол энэ 7 хоногоос эхлээд илүү тогтвортой болж эхэлж байгаа. Тэгэхээр энэ жишээлбэл Улаанбаатар хотод дизелийн түлшний нөөц бол одоо жишээлбэл 12 хоногоос 16 хоног болж илүү сайжирсан дүн харагдаж байгаа. Тэгэхээр цаашидаа ч гэсэн одоо энэ 12 сардаа БНХАУ-аас бол нэмээд одоо 10000 орчим тонн дизелийн түлш орж ирнэ.

12 сард бид нар дизелийн түлшний захиалгыг бол Роснефт компаниас сарын 80000 орчим хэрэглээний бол 83000 тонныг Роснефт компаниас бид нар авахаар баталгаажуулаад захиалгаа өгчихсөн. Тэгэхээр энэ байдал бол цаашидаа сайжраад 12 сардаа бол тогтворжино гэж харж байгаа. Дизель түлшийн үнийн хувьд бол бид нар одоо өнөөгийн байдлаар бол Роснефт компанитай хийсэн хэлцлийн дагуу 5 хувийн одоо

хямдралыг бол авч байгаа. Тэгэхээр мөн цаашидаа бид нар Роснефт компанитай урт хугацааны 5 жилийн гэрээнийхээ хүрээнд бол дараа жилээс эхлүүлээд 10 хувийн хямдралаар аваад явахаар энэ бол бас нэлээн тогтвортой цаашидаа дискаунтын үнээр авахад бол нөлөөлнө гэж харж байгаа. БНХАУ-аас бид нар 21040 тонны захиалгыг өгч баталгаажуулсан байгаа. Үүнээс яг өнөөдрийн байдлаар бол 9350 тонн дизель түлш одоо буюу 187 вагон бол Замын- Үүдээр орж ирээд одоо нэг ёсондоо ААН-үүд рүү хөдөө орон нутгаар болон Улаанбаатар руу шилжин хуваарилагдчихсан байгаа. Мөн ОХУ-аас Роснефтиэс бол 26 вагон буюу 1500 тонн дизелийн түлш бол өдөр болгон нэмэлтээр бол ачигдаж байгаа.

Тэгэхээр 2 талаасаа дизелийн түлш ороод ирэхээр бол цаашидаа одоо жишээлбэл бид нарын нөөцийн тоон дээр ч гэсэн сайжралт бол харагдаж байгаа. Тэгэхээр 12 сарын одоо сард бол бид нарын хэрэглээ 80000 орчим тонн байдаг. Роснефт компаниас бид нар 83000 тонны захиалгыг өгч 12 сардаа баталгаажуулчихсан байгаа.

Мөн АИ-92 өргөн хэрэглээний одоо шатахуун дээр нөөцийн хувьд асуудалгүй байгаа. Нөөцийн хувьд бол улсын хэмжээнд 45919 тонн буюу одоо ойролцоогоор бол нэг 34 хоногийн нөөц бол Монгол Улсын хэмжээнд байгаа. Тэгэхээр ер нь бол зайлигүй байх ёстой 30 хоногийн нөөцөөсөө илүү байна гэсэн үг. Мөн одоо энэхүү хууль батлагдсанаараа төрийн өмчит Эрчист ойл болон одоо Роснефт, Аэра 2 компани бол 60х40-ийн одоо хамтарсан компанийг байгуулах боломжтой болно. Үүгээрээ бид нар одоо ОХУ-ын Роснефт, Аэрогоос илүү хямдралтай дискаунт үнээр

ингээд цаашидаа авах боломж, нөхцөл нь одоо нээгдэнэ.

Одоогийн байдлаар бол яг Роснефть Аэрогийн 11 сарын байдлын үнийг аваад үзэх юм бол.

Г.Занданишатар: Содномын Чинзориг гишүүн тодруулж асууя.

С.Чинзориг: Яах вэ, дизель түлшний хангамж нэмэгдэх л юм шиг л байна. Гэхдээ цаашидаа энэ дизель түлшний үнэ бас нэмэгдэхгүй байх боломж байвал жаахан үнийг нь одоо бас буулгах, ядаж одоо буулгадаггүй юм гэхэд бас урт хугацаанд тогтвортой байх одоо боломж бүрдэх үү, үгүй юу гэдэг нэг асуудал.

Хоёр дахь асуудал Их Хурал чинь зарим бараа бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах нөөц бүрдүүлэх хууль баталсан. Энэ хуулийн дагуу газрын тосны бүтээгдэхүүнүүдийг импортлож байгаа ААН байгууллагуудад компаниудад урт хугацаатай, хүү багатай санхүүжилтийн эх үүсвэр олгох чиглэлээр хууль батлагдсан шүү дээ.

Тэгээд энэ хуулийн хэрэгжилт ямар үр дүнтэй байгаа вэ? Энэ компаниудад нь энэ хямд, урт хугацааны хямд эх үүсвэр нь олгогдож байгаа юу? Энэ нь одоо хангамжийг нэмэгдүүлэхэд нөөц бүрдүүлэхэд үнийг тогтвортой болгоход хэр ямар эерэг нөлөө үзүүлж байгаа гэж та бүхэн одоо үзэж байна.

Г.Занданишатар: Отгоншаравын Батнайрамдал дэд сайд, 85.

О.Батнайрамдал: Чинзориг гишүүний тодруулгад хариулт өгье.

Тэгэхээр дизель түлшний хувьд бол ер нь одоог хүртэл зах зээлийнхээ зарчмаар бас явж ирсэн. Роснефть компанитай Монгол Улсын Засгийн газраас байгуулсан урт хугацааны гэрээний хүрээнд бол цаашидаа 10 хувийн хямдралаар бид нар 2023 ондоо бол авахаар байгаа. Энд эдийн засгийн одоо эрэлт нийлүүлэлтээсээ хамаараад явна гэхээр ер нь цаашидаа одоо түүхий тосны үнэ дэлхийн зах зээл дээр бас хир байх вэ. Тэгэхээр энэ прогнозыг хүртэл бас Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас бол байнга харж байгаа.

Тэгэхээр ер нь одоо сая Европын холбооноос тавьсан 8 дугаар санцрын хүрээнд бол одоо ОХУ-ын түүхий газрын тос болон газрын тосны бүтээгдэхүүн дээр тавьсан санцр, цаашилаад одоо мөн БНХАУ-ын 0 ковидын бодлоготойгоор холбоотой эдийн засгийн удаашралтай холбоотой түүхий газрын тосны үнэ дэлхийн зах зээл дээр одоо жоохон ялангуяа сүүлийн сар бол нэлээн уналттай байгаа. Яг өнөөдрийн байдлаар.

Г.Занданишатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Нүүрсний тээврийн асуудал дээр нүүрсний хулгайны асуудал дээр үгээ үргэлжлүүлэн хэлье ээ.

Тэгэхээр 2000, 2012-2016 онд АН засаг барьж байх үед нүүрсний үнэ 27 доллар байсан. Тэрэн дээр одоо хэн ч сонирхдоггүй. Нүүрсний тээвэр нь одоо жишээ нь 3 сая төгрөгийн л тээвэртэй байсан. Өөрөөр хэлбэл Цагаан хаднаас Ганц мод хүртэл. Тэрийг хэн ч сонирхдоггүй. Дээрээс нь Си зөвшөөрөл гэдгийг хэн ч тоодоггүй цаас байсан юм. Зүгээр нөгөө машинд

өгдөг л цаас гэж ойлгодог. Тэгээд энэ анхнаасаа яагаад ингээд хулгай гарч ирсэн бэ гэхээр С зөвшөөрөл дээр хүнд суртлыг бий болгоод С зөвшөөрлийг 2 сая хүртэл төгрөгийн улирлын 2 сая төгрөгийн авлигатай болгоод тэрэн дээрээ одоо хамгийн их хүч чадалтай нь машинуудаа хятадуудын машинуудыг өөрсдөөрөө авдаг ийм л болсон юм л даа. Тийм учраас энэ 2016 оноос хойш л энэ нүүрсний хулгайны асуудлыг ярих ёстой юм байгаа юм. Тэгээд 600 доллар 2021 оны 11 сард энэ коксжсон нүүрсний хамгийн одоо өндөр үнэ нь 600 доллар болсон юм. Тэгээд энэ 600 доллар цаанаас нь ийм үнээр авах ёстой шаардлага ирдэг гэтэл манай нөхдүүд аман дээрээсээ 70, 80 доллароор зарж байгаад тэгээд зөрүү тэр 400 доллар, 300 доллар энэ тэрийг ер нь бол 250 гэж тооцогддог л доо. 250 долларыг 120 сая буюу 254 долларыг 130 тонныг 250-иар үржүүлээд 120 сая болж байгаа юм. Тэр 120 саяыг одоо талыг нь хувааж авдаг талыг нь тэр Хятадын компаниуд нь авдаг ийм л юм байгаад байгаа юм. Энэ дээр гол асуудал байгаа юм. Тэгээд энэ оффтейк гэрээний асуудал, энэ нүүрсний тээврийн хулгайны асуудал, гэрээний хулгайны асуудлыг одоо бүр 2 жилийн турш яриад байгаа юм. Харамсалтай нь энэ дээр дөнгөж саяхан энэ дээр эрх баригч нар 1-нийгээ нухах тийм одоо хэрэгсэл болж хувирч байх шиг байна. Эрдэнэс Таван толгой Монгол Улсад нэг төсөвтэй.

Гэтэл Монгол Улс 10 төсөвтэй болсон. Энэний хамгийн том бялуу нь Эрдэнэс Таван толгой байхгүй юу даа. Тэгээд эрх баригчдын шунал бүх юм бүгдээрээ тэр Эрдэнэс Таван толгой дээр очсон. Тэр Монгол Улсын эдийн засгаас том хулгайны тийм төсөв болж хувирсан. Тийм учраас энэ өнөөдрийн энэ асуудал гарч ирж

байгаа. Одоо Их Хурлын гишүүдэд нэг зүйл байгаа. Энэ нь Их Хурал, Засгийн газрыг Ерөнхий сайдыг томилдог. Ерөнхий сайдыг гүйцэтгэх эрх мэдлийг бас тодорхой хэмжээгээр одоо хянах эрхтэй, ийм байгууллага. Оффтейк гэрээгээ нээлттэй, Засгийн газар нээлттэй болгохгүй байх ийм сонирхол маш их байгаа. Ингэх юм бол Засгийн газар нээх сонирхолгүй байгаад байна гэдэг чинь Их Хурлыг тараах сонирхол явж байгаа байхгүй юу даа.

Оффтейк гэрээг нэхэх үү, Монголын төрийг хямралт байдалд оруулах уу гэдэг 2 сонголт энд ирчихсэн байж байна. Тэгээд энэ дотор одоо ингээд Хүрэлбаатар сайд сууж байна. Та нар тэр Засгийн газар дээр ажилла л даа. Оффтейк гэрээгээ ил болго л доо. Оффтейк гэрээгээ нуухын тулд Их Хурлыг чинь тараана гэдэг юм явж байна шүү дээ. Ийм аюултай, ноцтой ийм юман дээр та урьд нь бас санаачлаад явж байсан. Энийгээ хурдан хий л дээ. Ийм учраас ер нь бол яах вэ тийм жижиг сажиг маргаан байна. Тэр бол нэг тийм проблем биш. Бид нар тэгэхдээ энэ том хулгайн ард гарах нь л хамгийн чухал. 2 жилийн турш ярьсан энэ зүйл маань өнөөдөр ингээд бүх нийтийн хэлэлцүүлэг болоод жагсаал цуглаан болоод Их Хурал дээр бүгдээрээ ярьдаг болж байгаад л би их баярлаж байгаа.

Г.Занданшатар: Түрүүн тэр Хяналт шалгалтын түр хорооны асуудал ярьж байхад энэ асуулт ярихгүй. Одоо Газрын тосны тухай хууль ярьж байхад тэгэхдээ яах вэ, цаг үеийн асуудал учраас тасалсангүй. Тэгээд ер нь энийг нэг Засгийн газрын мэдээллийг сонсох байдаг юм уу? Гишүүд санаачилга гаргаад даргын дэргэдэх зөвлөлөөр хэлэлцээд нэг жич ярих нь зүйтэй байх. Ер нь том

агуулгаар нь. Одоо үндсэн асуудлаа явъя даа.

Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

Ер нь бол энэ яриад байгаа асуудал дээр Улсын Их Хурал нээрээ үнэхээр маш хариуцлагатай хандах ёстой байгаа шүү, Гишүүд сайн мэдээлэлтэй байгаа бол одоо тэр хууль хүчний байгууллагынханд нь бас мэдээллээ сайн өгөх хэрэгтэй байх. Өчигдөр л харж байх Засгийн газрын мэдээлэл, Нийслэлийн прокурорын мэдээлэл 2 зөрөөд байсан тохиолдлууд байгаа шүү Тэгэхээр энэ дээр бас анхаарах хэрэгтэй байх. Ер нь бол олон улсын санхүүгийн байгууллагаас анх удаагаа Монгол Улс оффтейк гэрийн ТӨК-ууд нь хууль бусаар БНХАУ руу нефть нүүрс гаргаад байна гэж анх гаргаж ирсэн шүү. Тэгэхээр бүгдээрээ энэ дээр бол нээлттэй сонсголоор маш хариуцлагатай, бодит тоотой эзэнтэй юмнуудыг гаргах нь чухал байгаа гэдгийг хэлжээ.

Тэгээд энэ газрын тостой холбоотой мэдээлэл дээр сая дизель түлшний нөөц үүнтэй холбоотойгоор Чинзориг гишүүн асуулаа. Гэхдээ яг үнэнийг хэлэхэд хомсдол бол одоо хүртэл байгаад байна. зарим хүмүүс энэ БНХАУ-аас бас ингэж дизель түлш нийлүүлж байгаа нь бол маш сайн хэрэг. Зүгээр чанарын хувьд шаардлага хангахгүй байна гэсэн юм гараад байна. Үнэхээр тийм байна уу, эсвэл бас одоо ийм явуулга явж байна уу тэ. Та нар маань бас орж ирж байгаа нефтийн дизель түлшний чанар дээр хэр анхаарч байгаа бол. Тэгээд ер нь цаашидаа энэ нөөцийн хувьд болоод хүртээмжийн хувьд энэ тасалдах асуудал гарахгүй гэж ойлгож болох уу? Энэ дээр нэгдүгээрт хариулт авъя.

Хоёрт нь энэ хууль маань Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан хууль маань 2023 оны 1 сарын 1-нээс хэрэгжиж эхэлнэ гэж ойлгож байгаа. Гэхдээ та нарын хэлж байгаагаар Илч ойл компани маань одоохондоо ОХУ-тайгаа тэр бүтэц зохион байгуулалтын хувьд ажиллах шатандаа явж байна гэсэн. Тэгэхээр одоо яг бүрэн гүйцэд зохион байгуулалт, бүтэц бүрэлдэхүүн, үйл ажиллагаа, тооцоо хүний нөөц нь бүрдээгүй байгаа бол шууд хэрэгжээд эхлэх бололцоо хэр байгаа юм бол? Энэ хэрэгжиж эхлэнгүүт одоо тэр онгоцны тийзний үнэ л гэхэд 8-10 хувиар хямдрах, дизель түлш болон бусад түлшний үнэ ханш, бүр 500 орчим доллароор хямдрах гээд ийм одоо нааштай эдийн засгийн үзүүлэлтүүд гарна гэсэн хүлээлт байгаа.

Тэгэхээр та нар маань энэ тооцоо судалгаан дээр одоо яг хэр ажиллаж байна? Яг энэ хэрэгжээд эхлэнгүүт эдийн засагт иргэнд очих карманд нь яаж нөлөөлөх вэ гэдэг тооцоо судалгаагаа яг одоогийн байдлаар яаж гаргаад байгаа талаараа мэдээлэл өгөх үү?

Тэгээд яг энд хэрэгжиж эхлэхэд бэлэн үү?

Энэ дээр хариулт авчихъя. Баярлалаа.

Г.Занданшатар: 85.
Батнайрамдал сайд. Дэд сайд хариулъя.

О.Батнайрамдал: Оюунчимэг гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр бид нар БНХАУ-аас бол яг 21040 тонн дизелийн түлш баталгаажуулж аваад эхнээсээ 9350

нь бол ороод ирсэн байгаа. Хятадаас авч байгаа дизель түлшний чанарын хувьд бол евро-5 стандарт байдаг. Тэгэхээр ерөөсөө БНХАУ-д зарагдаж байгаа бүх бүтээгдэхүүнүүд маань одоо хуулийнхаа дагуу Евро-5 бүтээгдэхүүн. Тэгэхээр илүү үнэтэй байдаг л даа. Тэгэхдээ бид нар одоо ялангуяа ААН-үүдийн хувьд бол илүү нэмэлт үнэ төлөх боломжит нөхцөлтэй. Тэгэхээр евро-5 бол БНХАУ-аас орж ирж байгаа. Чанарын хувьд гэхээр евро-5 гэдэг маань одоо маш сайн чанарын гэсэн үг.

Монголд одоо жишээлбэл зарагдаж байгаа ихэнх дийлэнх АИ-92 ч юм уу, дизель түлш бол бас евро-2 стандарт байдаг л даа. Тэгэхээр Роснефтээс бид нар ОХУ-аас авч байгаа ихэнх дизель түлж АИ-92-ын хувьд бол Евро-2 стандартын бүтээгдэхүүнүүдийг бид нар авч байгаа. Тэгэхээр цаашдаа бид нар илүү евро-5-ыг нэмэгдүүлэх алхмыг бол ОХУ болон Монгол Улсын Засгийн газрын комиссын хуралдааны хүрээнд бид нар байнга энэхүү асуудлыг тавьж, Засгийн газрын шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд цаашаа чанарыг илүү сайжруулах талаар ажиллаж байгаа. Тэгэхээр өнөөдөр бас яг гадуур бас яваад байна лээ л дээ. Яг 92-ын хувьд бас нөөцийн асуудал байна уу гээд. Яг энэ дээр бол яг албан ёсоор хэлмээр байна. АИ-92-ын нөөцийн хувьд бол ямар ч доголдол байхгүй байгаа. Өнөөдөр бол АИ-92-ыг одоо аваад үзэх юм бол 45919 тонн улсын хэмжээнд буюу 34 хоногийн хангалттай нөөцтэй байгаа. Тэгэхээр АИ-92-ын хувьд бол ямар нэгэн нөөцийн доголдол, хомсдол огт байхгүй байгаа гэдгийг бас албан ёсоор хэлэх ёстой байх гэж бодож байна.

Тэгээд цаашдаа бид нар, ялангуяа гол нийлүүлэгч Роснефт

компанитай бид нар 5 жилийн урт хугацааны гэрээгээ бол байгуулсан байгаа. Тэгэхээр энэхүү урт хугацааны гэрээгээр бол бид нар энэ дээр бол үнэд бас тасралтгүй хангамжийн талаар бас гэрээндээ тусгаж оруулсан байгаа юм. Тэгэхээр АИ-92-ын хүрээнд бол бид нар илүү тогтвортой үнээр 2023 ондоо нийлүүлэх гэрээ бол байгуулсан. Дизель түлшний хувьд бол өнөөдрийн авч байгаа 5 хувийн хямдралыг бид нар 10 хувь болгож ахиулж чадсан байгаа. Тэгэхээр тэгэхээр дизель түлшний хувьд бас бид нар ойлгох ёстой. Энэ бол зах зээлийнхээ эрэлт нийлүүлэлтээсээ хамаардаг одоо шатахуун түлш байгаа.

Тэгэхээр мэдээж дэлхийн зах зээл дээр түүхий тосны үнэ хэр хэлбэлзэж байгаагаас хамаараад цаашаа явна. Гэхдээ бид нар одоо өмнө нь одоо авч байсан Сингапурын хөрөнгийн бирж дээр хүнээс 10 хувийн хямдралыг авна гэдэг бол бас томоохон хэмжээний бас хямдрал бас үнэнд нөлөөлнө өө гэж бас бид бүхэн үзэж байгаа. Яг өнөөдрийн байдлаар бол Эрчис ойл ТӨК бол 2020 оны 4 сараас хойш байгуулагдаад явж байгаа. Тэгэхээр өнөөдөр яг Эрчис ойл компанд яг хамтарсан компани байгуулаагүй ч гэсэн Роснефт Аэротэй шууд холбогдоод одоо хямдралтай бүтээгдэхүүнээ аваад эхэлчихсэн байгаа. Тэгэхээр одоо яг 2022 оны 11 сарын авсан яг үнийг бид нар аваад үзэх юм бол Эрчис ойл компани агаарын түлшийг 1350 доллароор нэг тонныг авч байгаа. Бусад ААН-үүд бол 1602 доллароор зарж байгаа. Тэгэхээр энэ дээр бол үнийн зөрүү 300 доллар буюу ойролцоогоор бол 23.2 хувийн дискаунтыг бид нар аль түрүүн аваад ААН-үүд МИАТ-д ингээд хуваарилаад олгож байгаа.

Тэгэхээр энэ хууль батлагдсанаараа Роснефть, Аэро төрийн өмчит Эрчист ойл компани 2 албан ёсоор хамтарсан компаниа байгуулаад хамтын гэрээгээ байгуулах юм. Тэгэхээр одоогоор бол бид нар Уул уурхайн ямар улс Роснефтийн хувьд бол санамж бичиг байгуулчихсан. Санамж бичгийн хүрээндээ энэ үйл ажиллагаа маань явж байгаа. Тэгэхээр энэ хууль батлагдсанаараа албан ёсоор хамтарсан компани байгуулагдаад хамтын гэрээнд орох юм. Тэгэхээр тэр гэрээн дээрээ бол бид нар илүү бас цаашаагаа илүү бас урт хугацаандаа тогтвортой, бас илүү хямдралтай авах тал дээрээ бол одоо нэмж тусгана гэсэн үг. Тэгэхээр өнөөдөр бол яг.

Г.Занданшатар: Оюунчимэг гишүүнд 1 минут.

М.Оюунчимэг: Дэд сайд маань цаг нь давчдаад маш олон мэдээлэл өгөх гээд ингээд хурдан ярьчих шиг боллоо.

Миний ойлгосноор энэ Эрчит ойл буюу ОХУ-ын тухайн компанитай гэрээ хийсний дараа нөгөө 1 онгоцны тийз эдийн засгийн эерэг үр нөлөө нь гарна гэж ойлгох юм байна, тийм үү? МИАТ ХК жишээ нь эхнээсээ нийлүүлээд эхэлсэн гэж байна шүү дээ, хямралтай үнээр. Тэгвэл бараг он гараад МИАТ-ын тийзний үнэ ч хямдрах эдийн засгийн нөхцөл байдал бол бүрдэж эхэлж байна гэж ойлгох юм байна шүү дээ. Та энэ дээр нэг тодорхой хэлчихмээр байна.

Хоёрт нь ер нь энэ Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар, Мэргэжлийн хяналт энэ тэр анхааралдаа авч ажиллах хэрэгтэй байна. Яагаад гэвэл сая ингээд маш олон хүнсний дэлгүүрүүд, хүнсний зах,

дэлгүүрүүдээр ороод яагаад энэ юмны чинь үнэ ингээд өссөн юм болоо гээд л асуухад нэгдүгээрт долларын хани, шатахууны үнэ, дизель түлш одоо 92 гээд бензин шатахууны үнэ өссөн. Нөөц хомсодсоноос болоод энэ бараа бүтээгдэхүүн нэмэгдэж орж ирээд байгаа. Тэгээд бид нар яах вэ дээ тэр үнээр нь л зарахгүй бол бидэнд ямар ч.

Г.Занданшатар: 85.
Батнайрамдал.

О.Батнайрамдал: Оюунчимэг гишүүний тодруулгад нэмэлт хариулт өгье.

Тэгэхээр яг өнөөдрийн байдлаар хамтарсан компани байгуулагдаагүй ч гэсэн бид нар энэ хүлээлттэйгээр Эрчист ойл компани маань Роснефть, Аэро компанитай шууд холбогдоод илүү хямдралтай үнээр аваад эхэлчихсэн байгаа. Тэгэхээр өнөөдрийн яг авч байгаа үнэ маань бусад ААН-ээс 23 хувийн хямдралтайгаар аль түрүүн 11 сараас хойш нийлүүлэгдээд бол эхэлчихсэн байгаа.

Сүүлийн 2 сар бол хямдралтай үнээр бусад ААН-ээс ойролцоогоор нэг 20-25 хувийн хямдралтайгаар нийлүүлэгдээд бол эхэлчихсэн. Тэгэхээр энэ хууль батлагдсанаараа яг хамтарсан компани маань албан ёсоор байгуулагдаад хамтын гэрээн дээрээ бүх. Тэгэхээр эдийн засгийн үр дагавар бол одоо жишээлбэл хямдралтай 11 сард жишээлбэл 23 хямдралтай нийлүүлэгдээд эхэлчихсэн. Тэгэхээр бид нарын судалгаагаар бол онгоцны тийзний үнэд 8-10 хувийн хямдрал бас шууд нөлөөлнө гэж судалгаа байгаа.

Г.Занданшатар: Буланы Бэйсен гишүүн.

Б.Бейсен: Энэ Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дэмжиж байгаа юм аа. Энэнтэй холбоотой хэд хэдэн асуулт асууя.

Ер нь энэ жил 2022 он, 2021, 2022 онд энэ хэчнээн мянган тонн, сая тонн ч гэх юм уу, газрын тос экспортлсон бэ? Одоо энэ Хятадаас орж ирж байгаа газрын тос, дизель авч байна гэж ярьж байна. Энийг чинь бас газрын тосны хулгай байна гээд гадуур жагсаж байх шиг байна.

Тэр гаргасан газрын тосоо боловсруулаад ингээд дизель болгоод оруулж ирж байна уу? Нэгдүгээрт, энийг асууя.

Хоёрдугаарт, энэ баруун аймагт энэ шатахууны өндөр өсөлт нь маш хүндээр тусаж байна. Өвлийн хүйтэн зудтай байна. Бид сая хил, гааль, бензин шатахуун, нүүрс тээвэрлэлтийн ажлын хэсэгт ороод ажиллаад ирсэн. Гэтэл яг боомт дээрээс мэдээлэл авахад 80 бензин 2300-2350-иар орж ирж байгаа.

92 бензин 2350-иар. Дизелийн түлш гэхэд одоо яг агуулах дээр бууж байгаа нь биш 3450-3500. Гэтэл одоо зарж байгаа нь 92 бенз 2700, 80 бензин 2650 дизелийн түлшний энгийн нь 4150, евро түлш 4250 хүрчхээд байна. Энэ яг тээвэрт явж байгаа хүнс өргөн хэрэглээний бараа зөөж байгаа жолооч нарт маш хүндээр тусаж байна. Нөгөө талаар хөдөөгийн ард иргэд одоо өвс тэжээл авах, ингэхэд ер нь маш хүндрэлтэй байна. Энийг бууруулах ямар арга байна?

Хоёрдугаарт, онгоцны шатахууны үнэ өндөртэй холбоотой, баруун аймгуудаас хот руу эмчилгээнд явах улсууд, хүүхэд, эмэгтэйчүүд энэ

маш хүндээр тусаж байна. Үнэ өндөр байна. Энэнтэй холбоотой газраар явж байна өвчтэй улсууд. Сая гэхэд одоо 3 хоногийн өмнө Өлгийгөөс наашаа одоо өвчтэй, аавыгаа авч явж байсан 2, 3 хүн зэрэг нас барчихлаа шүү дээ. Замд ааварт ороод. Энэ онгоцны билетийн үнэ өндөртэй холбоотой. Энийг бууруулах ямар арга байна. Цаашидаа ямар бодлого барьж байна? Энэ талаар асууя аа?

Г.Занданшатар: 85.
Батнайрамдал дэд сайд.

О.Батнайрамдал: Бейсен гишүүний асуултад хариулъя.

2020, 2021, 2022 онд Монгол Улс газрын тосны хэчнээн бүтээгдэхүүн хэчнээн долларын бүтээгдэхүүн оруулж ирсэн бэ? Тэгэхээр ер нь 2019, 2020, 2021 оныг аваад үзэх юм бол бид нар ойролцоогоор хамгийн оргил үедээ бол 2 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн 2020, 2021 онд бол 1.9 сая, 2021 онд бол 1.8 сая тонн газрын тосны бүтээгдэхүүнийг бол импортлодог. Мөнгөн дүнгээр аваад үзэх юм бол нэг ойролцоогоор 800 сая-аас 2021 онд бол 1.1 тэрбум долларын газрын тосны бүтээгдэхүүн авах буюу бас гадагшаа валют урсдаг гэсэн үг.

2022 оны яг өнөөдрийн байдлаар аваад үзэх юм бол 1.5 сая тонн газрын тосны бүтээгдэхүүнийг бол бид нар одоогоор импортлосон байгаа. Баруун аймгуудын хувьд бол Цагаан нуур, Боршоо боомтоор газрын тосны бүтээгдэхүүнүүд бол илүү орж ирдэг. Роснефть компанитай хийсэн гэрээ хэлцлийн хүрээнд орж ирж байгаа бүтээгдэхүүнүүд бол ихэнхдээ бол Сүхбаатар, Монголын одоо Наушик одоо Сүхбаатарын боомтоор орж ирдэг байгаа юм. Тэгэхээр Сүхбаатарын боомтоор орж ирээд

баруун аймаг руу түгээгдэх, эсвэл Цагаан нуур, Боршоо боомтоос цаагуураа авах хоёрын хамгийн хувийн ААН-үүдэд хамгийн хямдралтай, илүү боломжит нөхцөлөөр бол оруулж ирдэг. Яг одоогийн байдлаар хамгийн боломжит нөхцөл нь бол Боршоо, Цагаан нуур боомтоор оруулж ирж ерөнхийдөө бол зарж байгаа юм. Тэгэхээр Боршоо, Цагаан нуур боомтоор орж ирж байгаа бүтээгдэхүүнүүд илүү одоо тухайн бүс нутгийн нийлүүлэгчдээс орж ирдэг буюу тэрэн дээр Роснефтийн бид нарын хэлэлцээрийн хүрээнд хийсэн хямдрал бол тэрэн дээр одоо нэг ёсондоо үйлчилдэггүй гэсэн үг. Тэгэхээр тэр тухайн бүтээгдэхүүн орж ирээд яг баруун аймагт зарагдаж байгаа үнэ дээр бол яг одоо таны түрүүн хэлсэнчлэн АИ-92 бүтээгдэхүүний хувьд бол 2400-2900-гийн хооронд бол хэлбэлзэж байгаа юм. Тэгэхээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны хувьд бол энэ жилээс өгсүүлээд жишээлбэл бүс бүс дээрээ бол салбараа байгуулж байгаа. Баруун аймгийн ялангуяа Ашигт малтмал газрын тосны салбар бол одоо Ховд аймагт байгуулагдаж байгаа.

Тэгэхээр бид нар илүү тэрэн дээрээ хариуцсан хөлтэй болж байгаа. Тэгэхээр энэ дээрээ энийгээ түшиглээд бид нар цаашидаа бол баруун аймгуудад одоо уул уурхай, хайгуул, тэр дундаа бас газрын тосны энэ бүтээгдэхүүнүүд бас хэрхэн ингэж ямар үнээр зарагдаж байгаа. Тэрэн дээр ямар боломж нөхцөл байгаа талаар бол бид нар тухайн салбараараа дамжуулаад илүү цаашаа ажил хийхээр бол төлөвлөж байгаа.

Ялангуяа ер нь баруун аймагт зарагдаж байгаа газрын тосны бүтээгдэхүүнүүд бол илүү үнэтэй байгаа. Тэгэхээр энэ дээр бол илүү

нарийвчилсан судалгаа хийж бас ямар алхам цаашаа байж болох вэ? Цаашилаад бас ОХУ-аас оруулж ирж байгаа тэр нийлүүлэгч дээр бид нар тэгвэл Монгол Улсын Засгийн газраас бас нэмэлт ямар арга хэмжээ байж болох вэ талаар бол бид нар салбараараа дамжуулаад, нэмэлт судалгаа тооцоогоо цаашаагаа хийгээд явж байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Буланы Бейсен гишүүн тодруулъя. 1 минут.

Б.Бейсен: Хуучин энэ Цагаан нуурын дамжлага бас тэр нефть бааз гээд бааз байсан. Цаанаасаа ойр газраар орж ирж байгаа байхгүй юу, шатахуун нь. Горна Алтайск, Барнаул эд нараас. Гэтэл энэ хотоос алслагдсан гэдэг утгаараа баруун аймгийн баруун 5 аймагт аймаар хүндээр тусаж байна. Өндөр үнийг энэ борлуулагч нар нь одоо янз бүрээр өндөр үнээр зараад байна. Яг бид нар түрүүн очоод гаалиас ч мэдэгдэл авсан шатахуун түгээх агуулахаас авсан дүн шүү энэ чинь. Тэгэхэд энийг одоо яаралтай байхгүй бол судалж байна, энэ дээр хойшлуулмааргүй байна, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энэ сая урагшаа гарч байгаа газрын тос улсын төсөвт хэчнээн тэрбум төгрөг төвлөрүүлсэн юм бэ? Тэрийг асууя.

Г.Занданшатар: 87.

Ч.Хишигдалай: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын хэрэгжүүлэлтийг зохицуулах хэлтсийн дарга Хишигдалай. Улсын Их Хурлын гишүүн Бейсений асуултад хариулъя. Газрын тосны экспорт 2022 онд бол эхний 6 сар экспорт хийгдээгүй. БНХАУ-ын хил, гаалийн асуудалтай холбоотой 6 сарын 18-

наас хойш бол газрын тосны экспорт хийсэн. Өнөөг хүртэлх хугацаанд 240 орчим мянган тонн газрын тос экспортолсон байна. Улсын төсөвт ойролцоогоор төсвийн гүйцэтгэл 40 орчим хувьтай явж байна. Монгол Улс бол газрын тосны бүтээгдэхүүн нийт 2 сая орчим тонныг хэрэглэдэг. Экспортолж байгаа тос маань жилд ойролцоогоор нэг 500 мянга орчим тонн байдаг. Энэ хоёрын хооронд бол бүтээгдэхүүн, түүхий эд хоёрын хооронд бол нэлээн зөрүү байгааг та бүхэн анзаарч байгаа байх. Үүнтэй холбоотой, бас газрын тосны олборлолтыг нэмэгдүүлэх, газрын тос боловсруулах үйлдвэрүүдийг түүхий эдээр хангах чиглэлээр бид нар хайгуул.../минут дуусав/.

Г.Занданшатар:

Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн.

Дараа нь санал хураалтын гишүүд чуулганы танхимд цуглаарай.

Б.Энх-Амгалан: Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зарчмын хувьд бол дэмжиж байгаа юм. Дэмжих бас шалтгаан байна. Сингапурын бирж дээр одоо нэг тонн бензин, газрын тосны энэ онгоцны түлш 1100 доллар байгаа бол манайд 1700 доллар байна. 350-450 доллароор өндөр байна гэсэн үг. Өмнө нь манай улсад 11 аймагт онгоц нисэж байсан бол одоо хоёрхон амьд нисэж байна. Яагаад гэвэл одоо дотооддоо ниссэн дор бол бараг гадаадаа ниссэн нэг хямдхан болчихоод байна. Солонгос руу 1.3 сая төгрөгөөр нисэж байна. Баян-Өлгий рүү 1.5 сая төгрөгөөр нисэж байна. Тийм учраас дотоодын нөгөө ядарсан зүдэрсэн, өвчтэй, зовлонтой байгаа, аваар осолд орсон, эмнэлгийн үйлчилгээ авах шаардлагатай, нялх нойтон

хүүхэдтэй ийм хүмүүс бол байдаг мөнгөө зараад одоо энд ирж байгаа. Энийг буулгах гэж л бид нар энийг үзэж байгаа юм.

Нэг зүйлийг бас хэлэхэд, одоо ингээд манай энэ агаарын тээвэрлэгчид нийт хэрэглээнийхээ 57 хувийг гадаадаас очиж авч байгаа байхгүй юу. Тэгээд далавч дүүрэн бензинтэй, тэгээд бөөн хүн суулгаад ингээд наашаагаа дааж ядан нисэж байгаа юм. Эрсдэлийн дунд. Гаднын онгоцууд, ер нь манайхаас бол бензин авахгүй байх юм. Онцгой тохиолдолд л авна. Тэгэхээр бид нар яах вэ гэхээр зэрэг 532950 төгрөгөөр илүү байгаа учраас явж өгөхгүй байгаа байхгүй юу. Энэ Эрчис ойл гэдэг компани бол Монгол Улсын газрын тосны боловсруулах үйлдвэрийн охин компани гэж ойлгож байгаа. Тийм учраас одоо ингээд Монгол Улс цаашидаа өөрсдөө газрын тосны бүтээгдэхүүнээ үйлдвэрлэвэл бид нар энэ Роснефтээс хамааралтай байгаад байхгүйгээр өөрсдийнхөө бензинийг авах юм байгаа биз дээ? Хэрэглэх юм байгаа биз дээ? Нэг дэх нь энэ.

Хоёр дахь нь та бүхэн маань тэр Тамсагийн ордоосоо тэр Дорнодоосоо нөгөө бүтээгдэхүүн хуваах гэрээгээрээ нефть түүхий эдээ авч чадахаар байна уу, чадахааргүй байна уу? Нөгөө Хятадтайгаа одоо тохиролцож байна уу, тохиролцохгүй байна уу? Сая Байнгын хороодын шалгалт явахад бол нэлээн эвгүй дүр зураг харагдаж байсан шүү. Ер нь бид нар нефть бүтээгдэхүүнээ авч чадах ч юм уу, үгүй ч юм уу байдалтай. Энийгээ анхаараарай. Энэ дээр нэг хариулт аваадахъя.

Хоёрт нь энэ шинэ Чингис хаан нисэх буудлын шатахуун түгээх байгууламжийг одоо та нар

Роснефтьтэй хуваагаад хувь эзэмшээд явчих юм биш биз? Энэ чинь бол зээлийн хөрөнгөөр хийсэн объект шүү дээ. Тэгээд энэ дээрээ аваачаад хувь эзэмшээд нөгөө нэг дундуур нь шланк шургуулна гэдэг шиг урьдын юм руу ингээд яваад орчихгүй биз? Энийг би бүр тодорхой асууж байна. Та нар өмнө нь бас нэг дундуур нь шланк шургуулж байгаад авах, концессоор авах тухай юм орж ирж байсан шүү. Одоо тийм юм байхгүй биз? Энэ чинь бол бид нар сүүлд нь өөрсдөө төлөөд явах өр л юм байгаа юм шүү дээ. Тэгээд энийг одоо Роснефтьтэй хуваалцаад явчих юм биш биз?

Дараагийн асуудал ингэж явж байгаад цаашдаа энэ нөгөө үнэгүйдүүлж байгаад хувьчлаад авчих ийм руу орохгүй биз?

Хамгийн сүүлд нь нэг асуулт асууя.

Дөрөв дэх асуулт. Одоо ингээд үнэ буугаад ингээд ороод ирэх юм бол та нар энэ зөвхөн МИАТ-д өгөх гээд байна уу? Эсвэл энэ нисэж байгаа бүх хувийн компаниуддаа энэ бензинийг одоо энэ хямдралтай үнээр өгөх гээд байна уу? Ийм 4 асуултад маш тодорхой хариулаадхаач.

Г.Занданшатар: 83. Гидратыг түрээслэхгүй биз? Ашиглуулахгүй биз гэж байна шүү дээ.

Б.Анхбаяр: Сайн байцгаана уу? Та бүхэнд өдрийн мэндийг хүргэе ээ Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Анхбаяр.

Энх-Амгалан гишүүний асуултад хариулья.

Бүтээгдэхүүн авах гэрээтэй холбоотой асуудал дээр бол яалт ч үгүй одоо Энх-Амгалан гишүүний хэлж байгаатай бол санал нэг байна. Бид нар бол ер нь 24 хувийгаа бүтээгдэхүүн хуваах гэрээнээс бол авч байгаа. Энэнтэй холбоотой бол улсын төсөвт орлого ингээд төвлөрөөд явдаг. Газрын тос боловсруулах үйлдвэр ашиглалтад орсноос хойш бол бид нар гарсан бүтээгдэхүүнийг бол 100 хувь дотооддоо одоо хэрэглэнэ гэсэн тооцоотой байгаа. Тэр ч утгаараа газрын тос боловсруулах үйлдвэрээс гарсан онгоцны түлшийг бол бид нар нэн тэргүүн ээлжид дотооддоо хэрэглэх талаар бол энэ санамж бичиг дээрээ бол оруулсан. Цаашдаа гэрээн дээрээ ч гэсэн энийг бол тусгаад явна. Тэгэхээр үндсэндээ юу гэж байна гэхлээр газрын тос боловсруулах үйлдвэрээс гарах бүтээгдэхүүнийг бид нар нэн тэргүүн ээлжид МИАТ болон дотоодын иргэний нисэхийн байгууллагууд маань одоо хэрэглээд явна. Энэ хэмжээгээр бол одоо Роснефть компаниас авах, гаднаас авах экспортын хэмжээ бас буурна гэж ойлгох нь зүйтэй. Шинэ нисэх онгоцны буудлын тэр хувь эзэмшлийн асуудал дээр бол яг одоогийн байдлаар бол ИНЕГ дээр 100 хувь эзэмшилтэй байгаа. Гидратын систем болон хадгалах байгууламжийг бол ер нь цаашидаа зөвхөн төрийн өмчит 100 хувь төрийн өмчит Эрчис ойл компанид бол одоо эзэмшүүлэхээр төлөвлөөд явж байгаа. Энэ дээр бол ямарваа нэгэн байдлаар Роснефть Аэра компанид бол хувь хувьцаа эзэмшүүлэх талаар бол ямарваа нэгэн тийм асуудал бол огт байхгүй. Тэгэхээр үндсэндээ энэ дээр төрийн өмчит 100 хувь одоо байх байдгаараа хэвээрээ байна гэсэн үг. Цаашидаа бол ер нь бусад компаниудад нийлүүлэх үү гэдэг асуулт асуусан. Роснефть компанитай хамтарснаар бид нар

зөвхөн МИАТ гэж одоо хязгаарлагдахгүйгээр бусад авиа компаниудад бол бас тод яг хүссэн хэмжээгээр нь одоо нийлүүлж явахаар төлөвлөж байгаа. Энэ дээр бол одоо Аэро Монголиа байна.

Дээрээс нь бизнес, бусад ААН-үүд, Хүннү эйр гээд. Одоогийн байдлаар бол, жишээлбэл одоо Аэра Монголиа бол Эрчис ойл компаниас бүтээгдэхүүнийг бол худалдаад авсан. Авч эхэлчихсэн байгаа. Тэгэхлээр ер нь бид нар ганцхан ТӨК гэхгүйгээр бусад ААН-үүд хувийн хэвчлүүдээ бас дэмжих зорилготойгоор хямд бүтээгдэхүүнүүдийг бол нийлүүлэх талаар арга хэмжээ аваад явж байгаа. Хариулт дууслаа.

Г.Занданшатар: Хэдэн хувиар хямд бүтээгдэхүүн нийлүүлэх үү? Яг одоо энэ хууль баталсны дараа хэдэн хувиар хямдрах вэ? Агаарын бензиний хувьд.

Б.Анхбаяр: Өнөөдрийн байдлаар бол яг газрын тосны Сингапурын бирж дээрх үнэ болон одоо спермексийн олон улсын одоо биржээс хамааралгүйгээр зүгээр 300 орчим доллароор бол ерөнхийдөө хямд нийлүүлэгдэж байгаа. Энийг цаашидаа бид нар улам буулгах талаар арга хэмжээ авч ажиллана. Энэ дээр бол бид нар үйлдвэрлэгчийг өөрийг нь оруулж ирж байгаа учраас ямарваа нэгэн дундын зуучлагчийн нэмэлт байхгүй. Премиум үнэ байхгүй гэдэг утгаараа бол илүү буурч орж ирнэ ээ гэсэн.

Г.Занданшатар: Яг хэдэн хувиар, өмнө нь хэд хэдэн тоо орчихсон учраас.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Газрын тосны

бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороо шилжүүлж байна.

Тэр уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль одоо энэ юмыг чинь ил тод болгох хамгийн чухал шүү дээ. Энэ дээрээ та нар олон асуудлууд байна гээд тэрнийхээ эргэлзээг яам хойшлуулаад байгаа. Тэрнийгээ яаралтай гаргаж өг, тэгж байж хэлэлцэхгүй бол одоо өнөөдөр яаралтай хэлэлцэх гээд байдаг, тэгээд тэр 2 дугаарт нь тэр олборлох байдлын ил тод байдлын санаачилгын хууль хамт орж ирэх ёстой байсан яагаад орж ирэхгүй байгаа юм бэ? Энэний цаана ямар санаа байгаа юм бэ? Жинхэнэ нүүрсний хулгайны юм чинь олборлох салбарын бүх ил тод байдлын санаачилгын хуулийг танай вэб сайтаар байршуулаад бараг 6 сар жил боллоо. Тэрнийгээ оруулж ир Батнайрамдал сайд.

Эцсийн хэлэлцүүлэгт шилжүүлчихлээ. Санал хураалт байхгүй, одоо эцэслэн батлах 39 гишүүнээр эцэслэн батална. Тэгээд маргааш өглөө эцэслэн батална. Энэ чинь Газрын тосны бүтээгдэхүүн тухай хууль нэмэлт оруулах тухай хуулийг эцэслэн батлах, бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна. Одоо эцсийн хэлэлцүүлэг ингээ дуусаж байгаа байхгүй юу.

Дараагийн асуудалд орно. Хот, суурины ус хангамж ариутгах, татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг танилцуулна. Индэрт урьж байна.

М.Оюунчимэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан, Б.Баттөмөр, Х.Булгантуяа нараас 2021 оны 7 дугаар сарын 5-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хот, суурины ус хангамж, ариутгах татуурга, ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2022 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд ишлэжүүлсэн.

Тус Байнгын хороо 2022 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай асуудлыг хэлэлцээд чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж, олонхын дэмжлэг авсан саналуудыг хуулийн төсөлд нэмж тусган, төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, хууль зүйн техникийн шинжтэй засваруудыг хийсэн төслийн эцсийн хувилбарыг та бүхэндээ хүргүүлсэн болно оо.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хот, суурины ус хангамж, ариутгах татуурга, ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн

хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж, хуулийн төслийг баталж өгөхийг Та бүхнээсээ хүсье ээ.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Барилга, хот байгуулалтын яамны Нийтийн аж ахуйн инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах бодлогын газрын дарга Ганчулууны Цогтсайхан, Барилга, хот байгуулалтын яамны Хуулийн хэлтсийн дарга Батдэлгэрийн Нямдорж, Барилга, хот байгуулалтын яамны Нийтийн аж ахуйн инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах бодлогын газрын ахлах шинжээч Рэнцэнсүрэнгийн Батчимэг, Хот суурины ус хангамж, ариутгах татуурга, ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн дарга Жамъянсүрэнгийн Батсуурь, Хот суурины ус хангамж, ариутгах татуурга ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөлийн тусгай зөвшөөрөл хэрэглэгчийн газрын дарга Гантөмөрийн Нарантуяа. Нарантуяа байхгүй байна уу?

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна.

Баделхан гишүүн өөрөө санаачлагч.

Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг эцэслэн батлах, бэлтгэл хангуулахаар Эдийн

засгийн байнгын хороонд шилжүүлж байна.

Энэ дээр чинь одоо нэр томъёоны нэлээд хэдэн асуудал байгаа шүү дээ.

Баярлалаа. Эцэслэн батлах бэлтгэл хангуулья.

Дараагийн асуудалд орно Монгол Улсын хилийн зурвас газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22.2-т хаалттай хэлэлцэхээр хуульд заасан болон төрийн нууцтай холбоотой асуудлыг хаалттай хуралдаанаар хэлэлцэнэ гэж заасан. Одоо хэлэлцэх гэж байгаа асуудал нь төрийн нууцтай холбоотой учир нэгдсэн хуралдааныг хаалттай хэлэлцүүлгийн горимд шилжүүлбэ.

ЗАВСАРЛАГА

12 дугаар сарын 8-ны өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулья.

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл,

Геодези зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэнэ ээ.

Ингээд гишүүд ажлын хэсгийг урьж байна.

Ингээд хууль санаачлагч байхгүй бол хуулийг хойшлуулна.

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ ээ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар танилцуулна.

Хууль санаачлагчийг индэрт урьж байна. Хууль санаачлагч 5 минут байхгүй бол Тамгын газрын хүмүүс яагаад зохион байгуулахгүй байгаа юм.

Хуралдаан зохион байгуулах хэлтэс Наранцогт дарга яагаад та хуралдаан зохион байгуулахгүй байна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар танилцуулна.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлаас Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуулийн төслийг 2012 оны 12 дугаар сарын 27-ны өдөр баталж, 2013 оны 1 дүгээр сарын 31-ний өдрөөс дагаж мөрдөж ирсэн. Тус хуульд хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хууль, Зөрчлийн тухай хууль

батлагдсантай холбоотойгоор нийт 3 удаа өөрчлөлтүүд орсон байдаг.

Энэ хууль хэрэгжээд 10 жил болж байна. Олон улсад татварын бодлого эрс өөрчлөгдөж, түүнд улс орнууд нэгдэж байгаа. Тиймээс Монгол Улс нэгдэж, уг бодлогод нийцүүлэн татварын эрх зүйн шинэчлэл хийсэн. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг 2020 онд баталсан зэргээс татварын харилцаанд олон шинэ ойлголт, зохицуулалт бий болсон.

Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгад татвар төлөгч нь татварын хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, эрхээ эдлэх талаар хуулиар зөвшөөрөгдсөн татварын мэргэшсэн зөвлөхийн туслалцаа зөвлөгөө авах эрхтэй байхаар хуульчилсан. Татвар төлөгчийн энэхүү эрх хангагдах боломж, өнөөгийн Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хууль, зохицуулалт дутмаг байна. Одоогийн Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуулиар татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээг зөвхөн хуулийн этгээд үзүүлэхээр байгаа.

Сангийн сайдын тушаалаар 1800 гаруй хувь хүнд татварын мэргэшсэн зөвлөх Зөвлөхийн эрх олгогдсон байна. Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэх этгээдийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх үүднээс олон улсын жишгээр татварын мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээг эрх бүхий хувь хүнээр болон хуулийн этгээдээр үзүүлэх боломжийг нээхээр нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа.

Энэ нь орон нутагт, ялангуяа сумдад хууль хэрэгжүүлэхэд

туслалцаа үзүүлэх орчин бий болгох буюу татвар төлөгч эрх бүхий мэргэжлийн үйлчилгээгээр хууль ёсны эрх ашгаа хамгаалах боломжтой болно гэсэн үг юм аа.

Мөн эцсийн эзэмшигчийн харилцан хамааралтай этгээдийн болон тэдгээрийн холбогдох гүйлгээний мэдээллийг гаргаж өгөх, мэдээлэх үүргийг хэрэгжүүлэх зэргээр олон шинэ зохицуулалтууд нь энэ хуульд нэмэлт, өөрчлөлт орох шаардлагатай болохыг илтгэж байгаа юм аа.

Олон улсад татвараа өөрөө тодорхойлон төлөх системтэй улс орнуудад татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээнд татварын алба, татвар төлөгчийн хооронд бат бөх гүүр нь болж, татварын хуулийн хэрэгжилтэд мэргэшсэн мэргэжилтнүүд туслалцаа үзүүлдэг тогтолцоо болон төлөвшижээ.

Бэфс буюу татварын суурийг гажуудуулж, ашиг шилжүүлэхтэй тэмцэх төслийн баримт бичиг, татвар татварын төлөлт бол бэфсийн нэг хэсэг төдийгүй татварын мэргэшсэн зөвлөх зөвлөхүүдийн ажил гэдгийг онцолсон байдаг аа.

Энэ үйлчилгээг татварын тогтолцоондоо бүрэн ашиглаж, төрийн үйлчилгээг хөнгөвчилсөн олон улсын сайн практик олон байгаа. Тухайлбал, Япон улсын татварын мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээгээр татварын тайлангийн үнэн зөв байдлаа бүрэн хариуцуулдаг төдийгүй энэ үйлчилгээний гаргасан тайланд үндэслэн банк барьцаагүй зээл олгодог.

Хуулийн төслийг Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах

хэлбэрээр боловсруулсан. Энэ төсөл нь 4 зүйл, 47 хэсгээс бүрдэж байгаа. Үүнд, нэгдүгээрт нэмэх 17 зүйл, хоёрдугаарт өөрчлөн найруулах 18 зүйл, гуравдугаарт өөрчлөх 11 зүйл, дөрөвдүгээрт хүчингүй болгох нэг зүйл туссан болно оо.

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид нийцэж байгаа бөгөөд тус хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр боловсруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл байхгүй болно оо.

Хуулийн төслийг хэлэлцэж шийдвэрлэж өгнө үү.

Г.Занданшатар: Төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга Бөхчулууны Пүрэвдорж танилцуулна.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүнийг индэрт урьж байна.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн хаачсан бэ? Хурал тасалчихсан байна. Бөхчулууны Пүрэвдорж гишүүний чуулганы танхимд дуудаж байна. Одоо байнга суудаг тэгэхээр төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатараас 2022 оны 10 дугаар сарын 5-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Татварын мэргэшсэн

зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Төсвийн байнгын хороо 2022 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэх этгээдийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх, бусад улс орны жишигээр татварын мэргэшсэн зөвлөх хуулийн тодорхой нөхцөл, шаардлага хангасан бол татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэх боломжийг нээх, мөн хуулийн этгээдэд тавигдах шаардлагыг сонгох боломжтой болгох, татвар төлөгчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалагдах нөхцөл бүрдэнэ гэж үзэж хуулийн төслийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ үзүүлснээр төсөвт орох татварын хэмжээ нэмэгдэх, буурах талаар судалгаа хийсэн эсэх, татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ нь заавал эс үгүй бол сайн дурын үндсэн дээр үзүүлэх үйлчилгээ байх эсэх талаар.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан Хуулийн төслийн гол өөрчлөлт болон татварын мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээний төлбөр тогтоосон тариф байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ үзүүлж буй хувь хүн, хуулийн этгээдийн хуулиар хүлээх хариуцлага ялгаатай эсэх, хугацаагүй эрхтэй болсон, татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч иргэний үйл ажиллагааг хэрхэн хянадаг талаар, Улсын Их Хурлын гишүүн Булгантуяа төрийн өмчит ААН-үүдэд мэргэшсэн

зөвлөх үйлчилгээ үзүүлэгч этгээд нь заавал ААН байх, жижиг дунд бизнес эрхлэгчдэд татварын хялбаршуулсан горимоор тайлан гаргах ажилд дүгнэлт хийсэн эсэх, хууль эрх зүйн орчныг хэрхэн дүгнэж байгаа болон төрийн өмчит ААН-үүдийн хариуцлагын заалтыг тусгасан эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж Улсын Их Хурлаас баталсан татварын хууль тогтоомж нь татвар төлөгчдөд ээлтэй байгаа бөгөөд хувь хүний татвар ноогдох орлогын хэмжээ 50 сая төгрөгөөс дээш бол нэг хувиар, ААН-ийн хувьд жилийн бол борлуулалтын орлого нь 300 сая төгрөгөөс доош тохиолдолд 1 хувийн албан татварыг төлөх боломжтой. Мөн Улаанбаатар хотоос алслагдсан аймгууд 500 километрийн зайтай үйл ажиллагаа эрхэлдэг бол албан татварыг 50 хувь, мянган километрийн зайтай бол албан татварыг 90 хувиар хөнгөлөх нь ААН-үүдийн үйл ажиллагааг дэмжсэн татварын таатай орчныг бүрдүүлсэн боловч хуулийг хэрэгжүүлэх шатанд олон баримт бичиг шаардаж байгааг анхаарах, цаашид татварын эрх зүйн орчныг сурталчлах, мэргэшсэн зөвлөхүүд, татвар төлөгчдөд энэхүү үйлчилгээг үзүүлэхэд энэ хуулийн өөрчлөлт зайлиггүй шаардлагатай гэсэн саналыг гаргасан болно оо.

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 63.6 хувийн саналаар дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

Баярлалаа.

Г.Занданшатар: Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Ажлын хэсгийг нь хооронд танилцуулж байя.

Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн ерөнхийлөгч Гүнсэнгийн Алтанзаяа, Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн дэд ерөнхийлөгч Хүрлээгийн Галмандах, Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн Хууль, эрх зүйн хорооны дарга Намсрайдоржийн Түмэнбаяр, Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн Тамгын газрын дарга Галаагийн Хишигзул, Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн хуулийн зөвлөх Ерөнхий нягтлан бодогч Пүрэвжавын Даидаваа.

Асуулт алга байна уу? Асуулт алга байна.

Тэгвэл хууль санаачлагч Байнгын хорооноос ямар ч асуулт алгуу тэгвэл үг хэлэх гишүүн байна уу? Дэмжсэн, дэмжээгүй. Дараа нь санал хураалттай. Гишүүн чуулганы танхимд цуглая.

Асуулт хариулт дууссан. Одоо үг хэлсний дараа дэмжсэн, дэмжээгүй

үг хэлсний дараа санал хураалт явуулна.

Гишүүд чуулганы танхимд цуглана уу. Үг хэлэх гишүүн байна уу?

Дамдины Цогтбаатар гишүүнээр тасаллаа.

Цогтбаатар гишүүнийг үг хэлсний дараа санал хураалт явуулна.

Гишүүд чуулганы танхимд цуглая. Асуулт хариултыг нь цаг дууссан учраас.

Д.Цогтбаатар: Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе ээ.

Энэ Татварын мэргэшсэн зөвлөгөө, зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль бол өнөөдөр ард иргэдэд, ялангуяа бичил бизнес, жижиг бизнесүүд рүү хүрсэн энэ үйлчилгээг хүргэх энэ өөрчлөлтийг хийж байгаа юм. Энэ бас нэмэлт, өөрчлөлт дотор нэг чухал зүйл байж байгаа. Энийг бас манай гишүүд анхаарч үзээсэй гэж бодож байгаа. Ганбаатар гишүүн энийг бас нэлээн онцолж чухалчилж дурдаж байна лээ.

Энэ бол нэмэлт, өөрчлөлтийн 4 дүгээр зүйл дээр энэ төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдэд энэ татвар хариуцсан ажилтан татварын мэргэшсэн зөвлөх байна гээд. Өөрөөр хэлбэл энэ дээр төрийн өмчит компаниуд дотроо өөрөө ийм мэргэшсэн зөвлөхтэй байхаас гадна гаднаас энэ мэргэшсэн зөвлөхийнхөө үйлчилгээгээ авах боломжтой нээлттэй. Энэний дүнд юу болж байна гэхээр яг өнөөдөр одоо энэ нүүрсний хулгай яригдаж байгаа үед энэ татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ үзүүлж байгаа энэ хүмүүс чинь

өөрсдөө энэ мэргэшсэн зөвлөх үйлчилгээгээ үзүүлээд эндээсээ татвар төлөгчтэйгөө хэрэв буруу үйлдэл хийгээд аливаа нууц хаах үйл ажиллагаандаа оролцсон бол тэр татвар төлөгчтэйгөө хамт хариуцлага хүлээнэ ээ.

Тэгээд нэг насны хоолноосоо салах эрсдэлтэй учраас энэ татвар тайлан тооцооны нээлттэй байдлыг хангахад энэ институтчлэгдсэн өөрчлөлт орж байгаа юм шүү. Энэ утгаараа бас яг өнөөдрийн энэ яригдаж байгаа асуудалд бол маш чухал шийдлүүдийн нэг. Өөрөөр хэлбэл энд олон шийдэл явж байж энэ нүүрсний хулгайн энэ асуудал чинь шийдэгдэнэ ээ. Энэ дотор гэхдээ яг ийм дорвитой шийдвэрүүд орж ирж байж энэ чинь ил тод болж, цаашидаа урьдчилан сэргийлэгдэх энэ боломж бас нээгдэж байгаа шүү гэдгийг манай гишүүд онцгой анхаараарай гэж бодмоор байгаа юм.

Хөдөө орон нутгаас сонгогдсон гишүүдийн хувьд бол үнэхээр хөдөө орон нутагт энэ үйлчилгээ байхгүй, хүрэлцэхгүй байгаад байгаа юм. Хөдөө орон нутагт бизнес байхгүй юм шиг, хөдөө орон нутаг, жижиг дунд бизнесүүд хувь хүмүүс, бизнес эрхэлж байгаа. Тэд нарт татварын эрсдэлд, өөрөөр хэлбэл татварын хариуцлагын эрсдэлд байнга орж байгаа юм. Гэтэл харин энэ хувь хүн энэ үйлчилгээг үзүүлэх боломжтой болоод эхлэнгүүт хөдөө орон нутагт, яагаад гэвэл энэ том компаниуд чинь бүгд Улаанбаатарт байж байгаа. Хөдөө орон нутагт үйлчилгээ үзүүлэх этгээд байхгүй байгаад байгаа юм. Хувь хүн үзүүлэх боломж нээгдэнгүүт хөдөө орон нутагт энэ жижиг бизнесүүд, бичил бизнесүүд, хувь хүмүүс энэ үйлчилгээг авах боломж үүсэж байгаа юм. Тэгээд энэ дээр нэг их чухал юм

байгаа. Юу гэвэл манай татвар төлөгчид аягүй олон татвараа буцааж авах, энэ одоо тооцоогоо хийх боломжгүй тэр чадвар нь дутаад байдаг учраас татварын эргэн одоо төлөлтөө авч чаддаггүй. Харин энэ үйлчилгээг авснаараа буцааж авах хуулийн дагуу буцааж авах тэр бүх боломжуудаа ашиглах боломжтой болж байгаа юм. Нөгөө талаасаа татвар одоо ингээд тайлангаа буруу бүртгээд тооцчихоод татварын өмнө хариуцлага хүлээчих гээд бүр эрүүгийн хариуцлага хүлээчих гээд байдаг энэ эрсдэл ийм мэргэшсэн үйлчилгээ ороод ирэхлээр тэр эрсдэл харин тэр хүмүүсийн нуруун дээр шилжиж бууж байгаа юм. Мэдээллээ зөв гаргаад л өгсөн бол тэр тооцоог хийсэн хүмүүс тэр хариуцлагыг хүлээнэ. Энэ утгаараа жижиг дунд бизнесүүдэд яг хүрсэн энэ үйлчилгээ одоо бий болох суурь нь тавигдаж байгаа юм шүү л гэдгийг хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа.

Одоо санал хураалт явуулна.

Байнгын хорооны саналаар Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Цогтбаатар гишүүнээ санал хураалт явууллаа шүү. Санал хураалт явуулъя.

Байнгын хорооны саналаар Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд

хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалт.

Үдээс хойших нэгдсэн хуралдааны эхний санал хураалт учраас бүртгэлийн санал хураалт явууллаа.

40 гишүүн бүртгэгдсэнгүй. Энэ 40 гишүүн. Болорчулуун гишүүн хөдөө явчихсан, чөлөө аваад. Эсрэг гараад байна.

Байнгын хорооны саналаар Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт. Цогтбаатар гишүүн гадагшаа дотогшоо явсаар байгаад кноп нь зэвэрсэн бололтой. Санаачилсан хууль нь эсрэг гараад байгаа юм.

55.6 хувийн саналаар төслийг хэлэлцэхийг олонхын саналаар дэмжлээ. Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслийнхөө үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлж байна аа.

Ер нь тэгээд зөвлөх үйлчилгээ үзүүлэх этгээд бүрийг татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн гишүүн байхыг шаардаж байгаа бас нэг танхимын хууль энэ тэр дээр бас анхны хэлэлцүүлгээр нарийвчлан харахгүй бол Худалдаа аж үйлдвэрийн танхим, жижиг дунд бизнес эрхлэгчдийн холбоодын саналыг сайн авч тусгахгүй бол бас эргэлзээтэй

заалтууд бас байгаа шүү. Ингээд Төсвийн байнгын хороонд шилжүүлээ.

*Дараагийн асуудалд оръё.
Ажлын хэсэгт баярлалаа.*

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшин танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Амартүвшин: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн нарын 3 гишүүн 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2022 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хороо 2022 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39

дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцсэн болно оо.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Амартүвшин хуулийн дагаж мөрдөх хугацаа 2023 оны 1 дүгээр сарын 31-ний өдрөөс, мөн Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 6¹-ийн баталгаа, батлан даалт гаргана гэсний даатгагчийн баталгаа, батлан даалт гаргаж болно гэж өөрчлөх санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно оо.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг танилцуулъя.

Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газрын дарга Зоригтын Батболд Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүн буюу дэд

дарга Нанжидын Хүдэрчулуун, Монголын даатгалын холбооны гүйцэтгэх захирал Жамсрангийн Батжаргал, Монголын даатгалын холбооны удирдах зөвлөлийн гишүүн Баттөмөрийн Батзул, Монголын эрчим хүчний барилга засварын холбоо болон Монголын үндэсний барилгын ассоциацийн удирдах зөвлөлийн гишүүн Махбалын Батболд, Үндэсний давхар даатгал хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Батмөнхийн Жавхлант.

Байнгын хорооны санал дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаарх Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Нэгдүгээрт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Төслийн 4 дүгээр зүйлийн хуулийн дагаж мөрдөх хугацааг “2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөс” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшин.

Санал хураалт.

61.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 6¹.1-ийн “баталгаа, батлан даалт гаргана.” гэснийг “даатгагчийн баталгаа, батлан даалт гаргаж болно.” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшин.

Санал хураалт.

62.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 6¹.1.1-ийн “төлбөрийг даатгагчийн баталгаагаар гаргаж болно;” гэснийг “төлбөрт;” гэж өөрчилж, 6¹.1.2, 6¹.1.3 дахь заалтын “даатгагчийн баталгаа гаргаж болно.” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшин.

Санал хураалт 60.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Найруулгын санал

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн төсөл.

Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Санал гаргасан Улсын

Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшин.

Санал хураалт.

60.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн төслийн найруулгын санал.

Төслийн гарчгийн “нэмэлт” гэсний дараа “, өөрчлөлт” гэж, төслийн 2 дугаар зүйлийн “бараа, ажил, үйлчилгээ” гэсний дараа “худалдан” гэж нэмж, төслийн 1 дүгээр зүйлийн “4.1.13 дахь хэсэгт заасныг ойлгоно” гэснийг “4.1.13-т заасныг” гэж, төслийн 3 дугаар зүйлийн “хуульд дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.” гэснийг “хуулийн 20.2, 43.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.” гэж өөрчилж, төслийн 2 дугаар зүйлийн “5.1.7, 5.1.8” гэсний дараах “дахь заалт, 5 дугаар зүйлийн” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшин.

Санал хураалт.

60.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “зүйлд заасан зохицуулалтыг хэрэглэнэ” гэснийг “зүйлд заасныг баримтална” гэж, “6.1-д заасан” гэснийг “6.¹-д заасан” гэж, төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “үйл ажиллагааны журмыг Санхүүгийн зохицуулах хороо батална” гэснийг

“үйл ажиллагааны журам” гэж өөрчилж, төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “даатгагчийн баталгаагаар” гэснийг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшин.

Санал хураалт.

64.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт орон өргөн мэдүүлсэн Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд илгэжүүлж байна.

Дараагийн асуудалд орно.

Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Барилга, хот байгуулалтын сайд Бэгзжавын Мөнхбаатар танилцуулна.

Мөнхбаатар сайдыг индэрт урьж байна.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Геодези, зураг зүйн салбар нь улсын хил, нутаг дэвсгэрийн хэмжээ,

газрын гадаргын бодит байдал болон түүн дээрх объектуудыг геодезийн өндөр нарийвчлал бүхий хэмжил зүйгээр зураглаж байрлалд суурилсан орон зайн болон газрын зургийн тоон мэдээллээр газрын харилцаа, байгаль орчин, ХАА, хот байгуулалт, дэд бүтэц, уул уурхай зэрэг нийгэм, эдийн засгийн салбаруудыг ханган, улс орны батлан хамгаалах, аюулгүй байдалд чухал үүрэг гүйцэтгэдэг салбар билээ.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.7.1.2-т заасны дагуу Геодези зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Засгийн газраас 2022 оны 10 дугаар сарын 22-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ. Геодези, зураг зүйн тухай хууль нь анх 1997 онд 3 бүлэг, 15 зүйл, 44 хэсэг, 79 заалттай батлагдсан бөгөөд үүнээс хойш 11 удаа 26 хэсэг, заалтад нэмэлт өөрчлөлт орж, 2 хэсэг, 7 заалтыг хүчингүй болгон тооцож 2 хэсэг шинээр нэмэгдсэнээр одоо мөрдөгдөж буй хуулийн 30 хүртэлх хувьд өөрчлөлтийг оруулсан байдаг юм аа.

Хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын урьдчилан тандан судалгаагаар геодези, зураг зүйн үйл ажиллагааны ангилалд тавигдах шаардлага, салбарын удирдлага, зохицуулалт, үйлдвэрлэл, үйлчилгээний хяналт болон баримт, мэдээллийн нэгдсэн тогтолцоог боловсронгуй болгох шаардлагыг тодорхойлсны дагуу Геодези зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг нийт 6 бүлэг, 32 зүйл, 169 хэсэг, 236 заалттайгаар боловсрууллаа. Шинэчилсэн хуулийн төслөөр салбарт баримтлах зарчмыг тодорхойлон, геодези, зураг зүйн үйл ажиллагаа,

бүтээгдэхүүний нэр төрөл, ангилал, хэрэглээ, тавигдах шаардлага, Улсын Их Хурал, Засгийн газрын бүрэн эрх, төрийн болон ТББ, захиалагч иргэн, хуулийн этгээдийн чиг үүрэг, оролцооны зохицуулалтыг нарийвчлан тогтоож, геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг шинээр батлагдсан Зөвшөөрлийн тухай хуульдаа нийцүүлэн тусгалаа.

Мөн Геодези, зураг зүйн ажилд магадлал, магадлан хэмжилт, захиалагчийн техникийн хяналт, зөвлөх үйлчилгээ, салбарын даатгал, норм, нормативын асуудлыг шинээр тусган бусад салбарт хийгдэж буй геодези, зураг зүйн ажлыг нэгтгэн нэгдсэн арга зүйгээр хангах, үр дүнг сайжруулах, газрын зургийг үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийн системээр дамжуулан хэрэглэгчдэд түгээх, улмаар салбар бүрийн оролцоотой газрын зургийн шинэчлэлтийг тогтмол хөдлөх тогтолцоог бүрдүүлэхээр зааж өглөө. Геодези, зураг зүйн тухай хуулийг шинэчлэн боловсруулсан геодези, зураг зүйн үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, үргүй зардал, үе шатны ажлын давхардал, хийдлийг арилгах, ил тод, нээлттэй иргэн, хуулийн этгээдийн хувьд цаг хугацаа үнсэн чирэгдэлгүй, чанартай бүтээгдэхүүнээр үйлчлэх, мэргэжлийн түвшинд үйл ажиллагааг хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ ээ гэж үзэж байна.

Хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Г.Занданшатар: Төслийн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, тус Байнгын

хорооны дарга Батсүхийн Саранчимэг танилцуулна.

Индэрт урьж байна.

Б.Саранчимэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Геодези, зураг зүйн тухай хуулийн Шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2022 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч газар, түүний доор дээрх агаарын орон зайд хийгдэх геодези, зураг зүйн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих, санхүүжүүлэх болон тэдгээртэй холбогдсон бусад харилцааг зохицуулахаар хуулийн төслийг боловсруулсан байна аа. Геодез зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд бүх салбарт хийгдэж байгаа геодези, зураг зүйн ажил, үйлчилгээг улсын хэмжээнд нэгдсэн удирдлагаар хангах үйл ажиллагааны төрлөөр нийтийн буюу иргэний тусгай буюу батлан хамгаалах гэж ангилах салбарууд тус тусдаа хийгддэг байсан байр зүйн зургийг улсын нэгдсэн санд оруулах, нэг эх үүсвэр ашиглах, геодезийн хэмжилт, зураглалын ажил, бүтээгдэхүүн, төрийн болон хөндлөнгийн хяналт тавих эрсдэл үүсэхээс сэргийлэх газар зүйн нэрийн зохицуулалт зэрэг асуудлыг нарийвчлан тусгасан бөгөөд хуулийн төслийг *d.parliament.mn* цахим сайтад байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно оо.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Идэрбат иргэд өвөлжөө, хаваржааны газарт олон наст ургамал тарьж болох эсэх, орон нутагт сум, багийн хилийн цэсийг шинэчлэн тогтооход маргаан гардаг асуудлыг хэрхэн зохицуулах, Улсын Их Хурлын гишүүн Батжаргал геодезийн тэмдэгт, түүний хамгаалалтын асуудлаар шинээр тусгаж байгаа зохицуулалт, хилийн цэс баталгаажуулах явцад хөдлөл үүсээд талбайн хэмжээ өөрчлөгддөг, зөрүү үүсдэг асуудлын талаар нарийвчилсан зохицуулалт нэмж тусгасан эсэх, газрын сангийн зураглалын талаар Улсын Их Хурлын гишүүн Дамдинням хилийн цэсийг шинэчлэн тогтооход зарим аймгийн талбайн хэмжээ өөрчлөгдөж байгаа шалтгаан, Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшин аймаг, сумдын хилийн цэсийн маргааныг шийдвэрлэх, дахин оновчтой тогтоох боломжтой эсэх, Хот байгуулалтын тухай хуулийн төсөлтэй уялдаж байгаа эсэх, суурин газрын солбицлын бие даасан тогтолцооны талаар Улсын Их Хурлын гишүүн Саранчимэг Улсын Их Хурлаар хэлэлцүүлж байгаа газрын багц хуулийн төслүүдтэй уялдуулсан эсэх, газар зүйн мэдээллийн нэгдсэн портал сайтыг ашиглахад салбар хооронд хүндрэл үүсэх. Уг мэдээллийн системийг ашиглахад шаардагдах төсөв, зардлын талаар асуулт асууж, хариулт авсан болно оо.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Дамдинням тухайн аймаг, сум, баг, хорооны хилийн цэсийг шинэчлэн тогтоохдоо түүхэн цаг хугацаанд гарсан, тухайн үеийн шийдвэрээр тогтоосон хэмжээг өөрчлөхгүй байх зарчмыг баримтлах Улсын Их Хурлын гишүүн Батжаргал, Ардын Их Хурал, Улсын Их Хурлын шийдвэрээр

тогтоосон хэмжээг орчин үеийн техник, технологи ашиглан цахим системд бүртгэхдээ өөрчлөлт оруулж, маргаан үүсгэхгүй байхад анхаарах, газар зүйн нэрийн зураглалд байгаа нэрийг өөрчлөхгүй байх, Улсын Их Хурлын гишүүн Саранчимэг уг хуулийн төслийг газрын багц хуулийн төслүүдтэй нийцүүлэх, ажлын хэсгийн түвшинд сайтар нягталж ажиллах шаардлагатай талаар санал хэлсэн болно оо.

Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг тус Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 66.7 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно оо.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон албаны нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хаягжуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын бүртгэлийн ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол хэлний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Соёлын өвийг хамгаалах хуульд

өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авто замын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Геодези, зураг зүйн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Баярлалаа.

Байнгын хорооны санал, дүгнэлт болон хууль санаачлагчийн илтгэлтэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд. Баттөмөрийн Энхбаяр гишүүнээр тасаллаа.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Барилга, хот байгуулалтын сайд Бэгзжавын Мөнхбаатар, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга Сандагийн Магнайсүрэн, тус яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Цогтын Баярбат, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын Геодези, зураг зүйн хэлтсийн дарга Далхаагийн Мөнхцэцэг, Барилга, хот байгуулалтын яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Геодези зураг зүйн бодлого зохицуулалт хариуцсан шинжээч Сүрэнжавын Болороо, Монголын

геодези фотограммар фраметр зураг зүйн холбоо ТББ-ын тэргүүн зөвлөх инженер Оросоогийн Хосбаяр, Монголын геодези, фото громметр зураг зүйн холбоо ТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүн зөвлөх инженер Цэрэнсангийн Даишзэвэг, Газар зохион байгуулалт геодези, зураг зүйн газрын дарга Анандын Энхманлай.

Эрхэм гишүүн Төмөртоогоогийн Энхтүвшин асуулт асууна.

Т.Энхтүвшин: Баярлалаа.

Энэ хуулийг бол дэмжиж байгаа. Хилийн зурвас газар байж байна. Тусгай хамгаалалттай газар нутаг дээр байж байгаа энэ геодезийн цэг, тэмдгийн асуудлыг яг хэн хариуцах юм бэ? Бүрэн бүтэн байдал дээр хэн хяналт тавих юм бэ? Энэ дээр нэг тодорхой хариулт хэлмээр байна та хэдийн энэ бичсэн зүйлүүдийг хараад байхад 9.13-т нь улсын тусгай хэрэгцээний газар байгаа геодезийн сүлжээний эхлэл, цэг болон байнгын цэг, тэмдэгтийн бүрэн бүтэн байдал, тусгай хэрэгцээний газрыг эзэмшигч байгууллагын дарга хяналт тавина гээд ингээд. Дарга гэдэг байгууллагын дарга л одоо энэ тусгай хэрэгцээний газарт геодезийн цэг тэмдэгт хяналт тавихаар ингээд ороод ирсэн байж байна. Тэгээд энийг одоо байгууллага гэж бичиж болоогүй юм уу?

Хоёр дахь асуудал, би бас Байнгын хороон дээр ярьж байсан. Энэ хилийн цэсийн асуудал бол ер нь 330 сум дээр чинь маргаантай байгаа шүү. 300 суманд чинь.

Ардын Их Хурлын тэр тогтоолоор баталсан геодезийн цэг тэмдэг бол өөрчлөгдөхгүй байх. Энийг одоо баталгаажуулахдаа маш их алдаа гаргасан байж байгаа. Одоо

малчдын отор нүүдлээс эхлүүлээд сум хоорондын одоо газрын маргаанаас эхлүүлээд 21 аймаг ч гэсэн одоо газрын маргаантай шүү дээ. Тэгээд энийг дахиж баталгаажуулаад цэг тэмдэгтийг нь нарийвчлан тогтоох энэ ажлыг бас энэ хууль гарсны дараа яаралтай хийхгүй бол болохгүй. Байнга яригддаг асуудал, энэ бол хилийн цэсийн асуудал бол. Тийм учраас энэ дээр одоо юу гэдэг юм, ялангуяа одоо би юу хэлэх гээд байна вэ гэхээр энэ Хил хамгаалах ерөнхий газар, Байгаль орчны яам, Барилга, хот байгуулалтын яам Геодезийн газар орон нутагтайгаа хамтарсан энэ томоохон ийм ажлын хэсэг гаргаад энэ тусгай хамгаалалттай газар нутаг хилийн тусгай хэрэгцээний газар энэ асуудал дээрээ нэг цэг тавьж баталгаажуулалтыг яг үнэн зөв хийх шаардлагатай байна. Энэ талаар одоо та хэд ямар бодлого барьж ажиллаж байгаа юм бэ?

Энэ дээр одоо нэг мэдээлэл өгөөч ээ гэж хүсэж байна. Баярлалаа.

Г.Занданишатар:

Энхмандалтай хариулъя.

А.Энхманлай: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга Энхманлай Энхтүвшин гишүүний асуултад хариулъя.

Шинээр боловсруулж орж ирж байгаа Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд геодезийн байнгын цэг, тэмдэгтийн талаар нэлээд одоо зохицуулалтыг оруулж өгсөн байгаа. Энд бол одоо сүүлийн үед бас геодезийн цэг тэмдэгт үрэгдэж алга болох, устаж үгүй болох ийм одоо асуудлууд гарч байгаа учраас энэ геодезийн цэг, тэмдэгтийн хамгаалалтын бүсүүдийг бид бүхэн энэ

хуулиар тогтоож өгч байгаа. Энд бол хот суурин газрын ангилалд хамаарч байгаа газар дээр цэг тэмдэгтийг бол 1.5 метрээр тогтооё, хамгаалалтын зурвасыг, бүсийг. Бусад ангиллын газар дээр 3 метрээр ингэж хамгаалалтын зурвас гаргаж өгч байгаа. Байнгын ажиллагаатай станцууд бас ажиллаж байгаа. Энэ станцуудын хамгаалалтын бүсийг Засгийн газраас тогтоож өгөхөөр ингэж заасан.

Тэгээд энэ өнөөдрийн энэ асууж байгаа улсын тусгай хэрэгцээний газрууд дээрх геодезийн цэг, тэмдэгтийг бол бүрэн бүтэн байдал, тусгай хэрэгцээний газрын хариуцаж байгаа байгууллагын дарга хяналт тавина гээд хуульчилсан. Энэ нь бол тусгай хэрэгцээний газрын, хамгаалалтын захиргааг хариуцаж ажиллаж байгаа. Түүний удирдлага бол энэ асуудалдаа хариуцаж, цэг, тэмдэгтийн бүрэн бүтэн байдлыг бол хариуцаж ажиллахаар ингэж одоо хуулийн төслийг зохицуулж өгсөн байгаа.

Бусад бүс нутгууд дээр бол тэгэхээр орон нутаг дээр бол орон нутгийн Засаг дарга нар энэ цэг тэмдэгтийн бас бүрэн бүтэн байдлыг хариуцаж ажиллана. Ер нь бол цэг, тэмдэгтийг ямар нэгэн байдлаар устгаж үгүй болгохыг хориглож иргэд байгууллагууд ч бас Зөвшөөрлийн тухай хууль дээр энэ зохицуулалтыг оруулж өгсөн.

Зөрчлийн тухай хууль дээр. Ингээд ямар нэгэн байдлаар устгаж үгүй болгосон, энэ хамгаалах үүргээ биелүүлээгүй тохиолдолд Зөрчлийн хуулиар бас холбогдох арга хэмжээг авахаар ингэж хуульчилсан.

Г.Занданшатар: 81. Бэгзжавын Мөнхбаатар сайд хариулъя.

Б.Мөнхбаатар: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя.

Өнөөдрийн байдлаар Монгол Улс 17 аймаг, 154 сум, ер нь хилийн цэсийн наана цаана маргаан байгаад байгаа юм. Үүнээс одоо зарлиг тогтоолын алдаанаас үүссэн нэг сум, аймгийн төвүүдийн сумдын хүн амын нягтралаас үүдэн зэргэлдээ сумын нутаг дэвсгэртэй байрласан асуудлууд. Үүн дээр бол 12 сумын асуудал байгаа. Газар усны нэр, хилийн зураг нэрилийн алдаанаас үүссэн 3, иргэдийн хилийн цэсийн талаарх ойлголт, мэдээлэл, бодит байдлаас зөрүүтэй гээд ингээд нэг олон асуудлууд байгаад байгаа. Тэгээд энэ хууль одоо хэлэлцэгдээд батлагдаад явсны дараа Засгийн газраас ер нь орон нутагтайгаа хамтраад нэг томоохон ажлын хэсэг байгуулж бас тодорхой хэмжээгээр цэгцэлье ээ. Ажлын хэсэг байгуулъя гэсэн бид нар бодолтой байгаа.

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Геодези, зураг зүйн тухай хуулийн хэлэлцэх эсэхийг бол дэмжиж байгаа. Иргэд бол яг энэ хууль ямар хууль юм бол гээд нэг их сайн мэдээлэл байдаггүй юм. Тэгээд энэ их чухал хууль гэдгийг нотлох хүрээнд би нэг асуулт асууя гэж бодож байгаа юм.

Нэгдүгээрт, энэ одоо геодези хэмжил зүй гэдэг бол ер нь бүх юмны суурь. Хаягжуулалтын суурь, барилга байшин барихын суурь, дайн байлдаан хийхийн суурь. Тэгэхээр энэ хэмжил зураглал гэдгийг бол яг иргэд ахуй амьдралдаа яаж мэдрээд байна вэ гэхээр одоо энэ гүүгл мафи гэж байгаа. Бүгд гар утастай болчихсон, одоо

гүүгл мафи гээд. Тэгээд одоо бусад улс орон руу явахаар энэ гүүгл мафи рүү ороод хаана юу байгаа юм гээд л шууд мафи дээрээ очих гэж байгаа газраа хийгээд л, явган ч бай уу, машинтай ч бай ингээд л явчихдаг болчихсон.

Тэгэхээр энийг хэн хийгээд байна вэ гэхээр мэдээж геодези, зураг зүйн хэмжил зураглалын ажил л даа. Хориод жилийн өмнө бол манай иргэд газар дээрээ энэ геодези хэмжил зүйн кадастрын зураглал гэдэг юм бол байгаагүй. Засаг дарга нар газар олгохдоо одоо тэр байшингийн баруун талд хэдэн метр квадрат, зүүн талд 4 давхар шар байшингийн ар талд нь 3 метр квадрат гэж газрын захирамжууд гардаг байсан байхгүй юу?

Тэгээд нөгөө газрын давхцал зөрчил одоо хэрүүл бүх юмны одоо үндэс. Тэгэхээр энэ геодези, зураг зүйн салбарынхны одоо энэ газрын шинэтгэлд оруулсан хувь нэмэр бол маш их байгаа юм. Одоо бол бүгд кадастрын зурагтай болчихсон давхцал гэж байхгүй болчихсон. Тийм учраас энэний чинь гол одоо үндэс болсон хуулийг бол бид хэлэлцээд сууж байгаа юм. Одоо энэ Улаанбаатар хотын Гүүгл мафиийг харахаар энэ хойд талын гэр хороолол бол одоо ямар ч юм байхгүй цав цагаан байгаа юм. Ямар ч хаяг байхгүй, энд юу байхгүй нь мэдэгдэхгүй. Хотын төв болохоор ингээд хэдэн том блокууд нэг гарч ирнэ. Одоо жишээлбэл энэ Централ товерын хаяг юу гэж гарч байна вэ гэсэн чинь louis vuitton гэдэг дэлгүүрийн нэртэй гүүгл дээр шууд гарч ирж байгаа байхгүй юу.

Тэгэхээр louis vuitton дэлгүүр Монголоос гараад хэдэн жил болж байгаа билээ тэ? Тэгэхээр энэ гүүгл мафи дээр энэ апдэт хийдэг юмтай ер

нь энэ салбар яаж холбогддог вэ гэсэн эхний асуулт байгаа юм.

Хоёр дахь асуудал бол бид нар нүүрсний хулгай яриад байгаа. Энэ нүүрсний хулгай бол төмөр замтай холбоотой. Төмөр замтай холбоотой бид алдагдсан боломжийнхоо үйлийн үрийг эдлээд сууж байгаа юм. Баттулга гэж хүн одоо энэ төмөр зам бариулаагүй. Энэний алдагдсан боломжоор энэ одоо маш их хэдэн их наяд төгрөгийн ийм боломж алдаад сууж байгаа юм. Машинаар зөөсөн төмөр зам бариулахгүй. Тэгээд нэг машин дээр нь хулгай гарчихсан тухай яриад байгаа шүү дээ одоо. Нэг мухар төмөр замууд нээгээд байгаа. Тэгээд мухар төмөр замууд нээгээд байгаагийн гол үндэс нь нөгөө Баттулга чинь энэ цэг координац нь Хятадын төмөр замтай уулзах цэг, координатыг нь зөрүүлчихсэн гэж яриад байгаа шүү дээ.

Өндрийн зөрүүлчихсэн хэдэн километр зөрүүлчихсэн. Одоо энэ зөрүүг нь арилгахад дахиад төмөр зам барьсантайгаа адилхан мөнгө гарна гэж яриад байна л даа. Тэгэхээр би яг энэ геодезийн нарийн мэргэжлийн дарга нараас асуух гэж байгаа. Мөнхцэцэг даргаас л асууя даа.

Энэ төмөр зам барих ажилд одоо ингээд анхнаас нь энийг бол зөрүүлэхгүй байх ажил нь бол суурь хэмжилзүй байж байна шүү дээ геодезийн. Энд одоо та хэд оролцоогүй юм уу? Энэ төмөр зам барихад нь анхнаас нь зураг төслийг нь хийгээгүй юм уу? Ийм зөрүү одоо геодезийнхэн бол би бодохдоо хэзээ ч ийм зөрүүлж ийм төмөр зам бариулах ёсгүй. Энэ бол бүр шинжлэх ухаан, миллиметрийн зөрүүгүй уулзуулах ёстой мэргэжил байхгүй юу?

Тэгэхээр та хэдийн ийм дүгнэлтгүйгээр энэ шууд бариад явчихсан юм уу? Энэ ямар учиртай юм бэ? Гэсэн ийм асуулт байна.

Г.Занданшатар: Энхманлай 80.

А.Энхманлай: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга Энхманлай.

Энхбаяр гишүүний асуултад хариулъя.

Геодези, зураг зүйн тухай хууль маань өөрөө маш чухал хууль байгаа. Өөрөөр хэлбэл одоо манай газрын харилцаа. Тэр дундаа одоо энэ хаягжилтын асуудлыг гол нь одоо шийдвэрлэх. Хаягжилт гэдэг бол угаасаа тухайн одоо объектын байршилыг тодорхойлж нэршүүлж, газар зүйн нэрийн нэг бүрэлдэхүүн хэсэг байгаа.

Тийм учраас энэ геодезийн хуулиар бид бүхэн энэ хаягжуулалтын асуудлыг өшөө одоо нарийвчлах, технологижуулах энэ мэдээ мэдээллийг мэдээллийн сан үүсгэж ашиглах ийм одоо асуудал дээр шийдэл олж оруулж ирж байгаа. Ингээд хаягжуулалтын асуудлаар Засгийн газрын одоо шинэ хаягжуулалтын системд шилжүүлэх ийм шийдвэр гараад одоо бид бүхэн бас энэ Монгол Улсад хаягжуулалтыг ашиглаж ажилладаг, хэрэгжүүлж ажилладаг Харилцаа холбооны яам, мөн УБЕГ, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар, мөн үүнийг одоо ашигладаг хувийн хэвшлийн байгууллагууд, мөн одоо хүргэлтийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд, тэгээд цагдаа, онцгой байдал, эрүүл мэндийн байгууллагуудтай бид бүхэн бас хамтарч ажиллаж, энэ одоо навигешиний системийг байршил

тодорхойлолт системийг бас хөгжүүлээд ашиглалтад оруулах гээд ажлын хэсэг байгуулаад ингээд хамтраад ажиллаж байгаа. Гүүгл мафи дээр бид бүхэн бол харилцан мэдээлэл солилцдоггүй байгаа.

Өөрсдөө ямар ч байсан дотоодын энэ үүсгэсэн шинэ системээ хөгжүүлээд байнгын одоо шинэчлэгдэж явдгаар төрийн байгууллагууд нь дундын мэдээллийн сан үүсгээд ингээд үйл ажиллагаандаа шинэ системээ нэвтрүүлж ажиллахад бэлэн болж байгаа.

Г.Занданшатар: 82.

Д.Мөнхцэцэг: Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын Геодези, зураг зүйн хэлтсийн дарга Мөнхцэцэг.

Хоёр дахь асуултад хариулъя.

Төмөр замыг уулзуулах яг аль цэгт уулзуулах вэ гэдэг асуудлыг анхнаасаа бид нартай ерөөсөө хамтарч ажиллаагүй. Сүүлийн 2 жилд л энэ асуудал сөхөгдөөд аль цэг дээр уулзах вэ гэдэг асуудал гарч ирсэн.

Хятадын тал бол 2012 онд төмөр замаа бүр өөрсдөө барьчихсан байсан. Тэгэхээр бид нар одоо тэрэнд нь нийцүүлэхийн тулд нэлээн өндрийн зөрүүтэй, байршлын ч хувьд бас зөрүүтэй асуудал бид нарын төлөвлөсөн төмөр зам бас нэлээн өөрчлөгдөх тийм асуудал гарч ирж байгаа юм.

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр гишүүн тодруулъя.

Б.Энхбаяр: Тэгвэл манай Монголчууд чинь төмөр замаа Геодези, зураг зүйн энэ байгууллага

ажилтнуудаа оролцуулалгүй хэмжил зураглалаа хийхгүй л барьсан юм байна л даа. Тэгээд энэ геодези, зураг зүйн компанийн хүмүүс энэ Баттулга Ерөнхийлөгчийн зөвлөхөөр дамжуулаад та нар хийчих гэсээр байгаад баахан ажил хийлгээд дампууруулаад нэг захирал чинь амиа хорлоно гээд гэрээслэл бичээд яваад байсан шүү дээ. Энэ юу болсон бэ нөгөө компани нь дампуураад. Одоо тэр улсад хэчнээн төгрөгийн энэ төр засгаас тийм хохирол учруулсан юм бэ тэр компани хүмүүст, энэ геодезийн салбарт. Хуульгүй, дүрэмгүй амаар ажиллуулаад тэгээд сайд хүн одоо ажил гээд байхаар чинь тэр төрдөө итгээд компаниуд чинь ажил гүйцэтгэж байна шүү дээ.

Тэгээд дараа нь мурьчихдаг хулхидчихдаг.

Г.Занданишатар: Тодорхой хариулъя. 82.

2 улсын зам ямар хариуцлагагүй юм бэ?

Д.Мөнхцэцэг: Баригдаж байгаа төмөр замууд бол бүгд зураг төсөлтэй хийгдсэн. Одоо яг Хятадын талтай нийлэх, уулзах төмөр замын асуудлыг би түрүүн тайлбар хэлсэн. Өмнөх төмөр замын барих үед зураг хийгдсэн компаниуд бол мөнгөө авсан байгаа. Тэр ажлууд бүгд зураг төсөлтэй хийгдээд тэр зураг төслийнхөө дагуу төмөр зам нь баригдсан.

Г.Занданишатар: Болчихсон уу?

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүн байна уу? Дэмжсэн, дэмжээгүй 3 хүртэл гишүүн үг хэлнэ. Содномын Чинзориг гишүүнээр тасаллаа.

Содномын Чинзориг гишүүн үг хэлнэ ээ.

С.Чинзориг: Энэ хуулийн төслийг нь яах вэ, хэлэлцэх эсэхийг нь дэмжээд явъя гэсэн ийм бодолтой бол байгаа юм. Гэхдээ хэлэлцэх явцдаа ер нь цаашидаа хууль батлагдсаны дараа Мөнхбаатар сайд нэг тодорхой судалгаа хийгээд Их Хуралд нэг асуудал оруулж танилцуулмаар байгаа юм аа.

Гишүүдийн яриад байгаа хилийн цэсийн маргаантай холбоотой асуудал хаа сайгүй л байгаа л даа. Манай Өвөрхангай аймагт ч байна. Аймаг дотроо ч одоо сумдууд хилийн цэстэй, маргаантай асуудал байна. Өөр аймгуудтай зэргэлдээ аймгийн зэргэлдээ сумуудтайгаа ч одоо хилийн маргаантай асуудал байнга л ярьдаг. Бид одоо өсөхөөс л энд одоо өссөн, төрсөн манай өвөөгийн аавын өвөлжөө хаваржаа энд л байсан юм. Одоо тэгээд энэ хилийн цэсээр бол ингээд бид өөрийнхөө нутагт өвөлжиж, хаваржиж чадахгүй болчихоод байгаа юм. Тэр харагдаж байгаа уулын толгой бол манай одоо нутаг л байсан гэж ийм юм байнга л ярьж байгаа юм. Ялангуяа манай Өвөрхангай аймагт энэ эдийн засгийн маргаантай холбоотой асуудал яригддаг. Баян-Өндөр сум байна. Төв аймгийн зэргэлдээ Дэлгэрхаан сумтай бас ийм хилийн цэсийн маргаан маш ихээр яригддаг. Бүрд сум байна, бас одоо Төв аймгийн сумдуудтай мөн одоо бас аймаг дотроо сумдуудтайгаа ч бас хилийн цэс ярьдаг.

Булгантай холбогдсон хилийн маргаан маш ихээр яригддаг. Манай Өвөрхангай аймгийн Хархорин сум байна. Аймгийнхаа сум дотроо бас хилийн маргаан ярьдаг. Архангай Булгантай бас ийм хилийн маргаантай асуудал, байнга одоо гишүүдийг очих

бүрд яригддаг асуудал. Тэгээд энд нь одоо бид нар тодорхой хариу хэлж чаддаггүй. Зайлшгүй одоо Их Хурлаар орж ирж шийдэх ёстой, ийм л одоо асуудал гээд ийм ерөнхий юм бол хэлээд яваад байдаг.

Тэгэхээр энэ хууль хэлэлцэх явцад юм уу, амжихгүй бол хууль батлагдсаны дараагаар ер нь энэ сум хоорондын хилийн цэсийн маргаантай холбоотой асуудлууд, аймаг хоорондын 2 аймгийн 2 сумдын хоорондын эдийн засгийн маргаантай холбоотой асуудлыг нь судлаад, шаардлагатай бол Их Хуралд одоо танилцуулах, шаардлагатай бол тодорхой асуудлыг шийдэх хууль, эрх зүйн орчныг нь бүрдүүлэх талаар Их Хурал дээр тодорхой санал оруулж ирж нэг танилцуулмаар байгаа юм.

Тэгэхгүй бол энэ хилийн цэсийн маргаантай холбоотой асуудал, ерөөсөө дуусашигүй маргаан. Биднийг одоо очих болгонд л одоо эдгээр ийм сумдууд бол ярьж байдаг, байнга л одоо ярьж байдаг. Тэгээд бид нар бол ерөнхий асуудал яриад л одоо явдаг. Тэгэхээр энийг бол нэг талд нь одоо бас шийдэх талаар танай яам санаачлаад Их Хуралд нэг ойрын хугацаанд тодорхой судалгаа хаяг явуулаад тодорхой нэг санал оруулж ирээч. Хэрвээ шаардлагатай бол Их Хурлын холбогдох шийдвэрийн төсөл ч гэсэн одоо бас оруулж ирж асуудлыг танилцуулж болно шүү дээ.

Гэхдээ энэ бол бас богино хугацаанд шийдчих асуудал биш л дээ.

Тодорхой одоо аймгуудтай сумдуудтай нь ярилцах, ойлголцох, зөвшилцөлд хүрэх гээд нэлээн одоо асуудал бол бий. Гэхдээ энийг бол бас халираад хойшоо суугаад байж болохгүй ээ.

Нэг шийдвэр одоо гаргах бүгдийг нь биш ч гэсэн нэг хэсгийг нь боломжтой нэг хэсгийг нь одоо бас энэ маргаанд нь цэг тавих ийм асуудлыг танай яам нэг санаачлаад, ажлын хэсэг гаргаад орон нутгууд ажлаа судлаад ингээд нэг Их Хуралд танилцуулаад тодорхой бас боломж байдаг бол нэг шийдвэрийн төсөл танилцуулаач гэсэн ийм саналтай байгаа юм аа.

Тэгэхээр энийг одоо та бүхэн тодорхой ажил хэрэг болгоод засаг дээрээ яриад ажлын хэсэг гаргаад, тэгээд энэ орон нутгуудад ажиллаад саналыг нь аваад, тэгээд Их Хуралд тодорхой шийдвэрийн төсөл оруулж ирээч ээ гэсэн ийм санал хэлэх гээд байгаа юм.

Г.Занданшатар: Зүгээр санал хэллээ. Дэмжиж үг хэллээ.

Одоо санал хураалт явуулна.

Санал хураалтаа бэлдээрэй. Санал хураалт явуулна.

Байнгын хорооны саналаар Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон албаны нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хаягжуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын бүртгэлийн эрхийн хуульд өөрчлөлт оруулах тухай, Иргэний улсын

бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол хэлний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авто замын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Геодези зураг зүйн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалтад бэлтгээрэй.

Санал хураалт 54.3 хувиар дэмжлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлдүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлж байна.

Тэгэхдээ энэ хууль нэлээн өмнө нь хэлэлцэгдсэн энэ Магнайсүрэн дарга, Мөнхбаатар сайдаа энэ Газрын тухай хууль, Кадастрын тухай хуультайгаа энэ нягт уялдах ёстой. Зарим нэр томъёо энэ тэр 2 хууль дээр 2 хуулийн төсөл дээр өөр агуулгатай, өөр зөрчилтэй явж байгаа юмнууд жигдлэх шаардлагатай юмнууд бий.

Хуулийн хийдэл, зөрчил, давхардлыг арилгахад анхаарах хэрэгтэй.

Ер нь тэгээд л геодези, кадастр чинь ер нь татвараас газрын татвараас, газраас, газрын хэмжилт зүйгээс ингээд бүгдээрээ л уялдаа холбоотой тулгарсан асуудлууд учраас энэ нягт нямбай хандахгүй бол тэр Стандарт хэмжил зүйн тухай хууль дээрээ хүртэл Газрын тухай хууль чинь шинээр ороод ирсэн байна лээ шүү дээ. Тэрнийг ер нь Барилга, хот байгуулалтын яам үзсэн үү? Газрын харилцааны газрын зөвшөөрлийн асуудал чинь. Тэр хуулиудыг уялдуулах ажлыг одоо маш сайн хангаарай, эхний хэлэлцүүлэгт бэлтгүүлэхэд.

Ингээд анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлээ.

Асуудал танилцуулъя. Өнөөдөр энэ 7 хоногт хэлэлцэхээр төлөвлөж байсан Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг татан авч байгаагаа мэдэгдэж байгаа Засгийн газраас бичиг ирсэн байна. Ингээд хуулийн төсөл татан авах тухай Монгол Улсын Засгийн газраас 2020 оны 5 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг татан авч байгаагаа үүгээр мэдэгдэж байна.

Засгийн газрын 2012 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг хавсаргав.

Ингээд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг татан авахаар тогтсон байна.

Хуулийн төслийг татан авсанд тооцлоо.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд, Улсын Их Хурлын тухай хуулиар х.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Хуулийн төслийг татан авлаа.

Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөл хуралдаж, маргааш болон ирэх 7 хоногт хэлэлцэх асуудлуудын талаар цаг үеийн асуудлуудын талаар хэлэлцэнэ ээ.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА*

